



МОНГОЛБАНК

**ТӨРӨӨС МӨНГӨНИЙ БОДЛОГЫН
ТАЛААР 2016 ОНД БАРИМТЛАХ
ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ТӨСӨЛ**

**УЛААНБААТАР
2015 ОН**

ГАРЧИГ

I. ТӨРӨӨС МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ТАЛААР 2016 ОНД БАРИМТЛАХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА	5
II. ТӨРӨӨС МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ТАЛААР 2015 ОНД БАРИМТЛАХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙГ БАТЛАХ ТУХАЙ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2014 ОНЫ 69 ДҮГЭЭР ТОГТООЛЫН ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦ	17
(2015 оны 8 дугаар сарын байдлаар)	
III. ТӨРӨӨС МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ТАЛААР 2015 ОНД БАРИМТЛАХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ХЭРЭГЖИЛТ	29
(2015 оны 8 дугаар сарын байдлаар)	
IV. ТӨСЛИЙН ТООЦОО, СУДАЛГАА	45
4.1 ИНФЛЯЦИ	45
4.2 БОДИТ СЕКТОР	46
4.2.1 Нийт нийлүүлэлт	46
4.2.2. Нийт эрэлт	47
4.3 УЛСЫН ТӨСӨВ	48
4.4 ТӨСӨӨЛӨЛ	51
4.4.1 Инфляцийн төсөөлөл.....	51
4.4.2.Эдийн засгийн өсөлтийн төсөөлөл.....	52
4.4.3. Төсөөллийн тодорхой бус байдал	53
4.5 МӨНГӨНИЙ ҮЗҮҮЛЭЛТҮҮД	54
4.5.1 Мөнгөний нийлүүлэлт	54
4.5.2 Мөнгөний зах, хүүний түвшин	55
4.5.3 Төгрөгийн гадаад валюттай харьцах ханиш	57
4.6. ТӨЛБӨРИЙН ТЭНЦЭЛ, ГАДААД ЗАХ ЗЭЭЛ	58
4.6.1. Төлбөрийн тэнцэл	58
4.6.2. Монгол Улсын гадаад хөрөнгө оруулалтын позиц	63
4.6.3. Монгол Улсын нийт гадаад өр	64
4.6.4. Гадаад секторын 2016 оны төлөв хандлага.....	65
4.7. БАНКНЫ САЛБАРЫН ТОГТВОРТОЙ БАЙДАЛ	69
4.7.1. Банкны салбарын өөрийн хөрөнгө болон төлбөрийн чадварын үзүүлэлтүүд	72
ХАВСРАЛТ.....	77

ТӨСӨЛ

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТОГТООЛ**

2015 оны ... сарын ... өдөр

Дугаар ...

Төрийн ордон, Улаанбаатар хот

**Төрөөс мөнгөний бодлогын талаар
2016 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай**

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалт, Төв банк /Монголбанк/-ны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. “Төрөөс мөнгөний бодлогын талаар 2016 онд баримтлах үндсэн чиглэл”-ийг хавсралтаар баталсугай.

2. Макро эдийн засгийн тэнцвэрийг хангаж, эдийн засаг тогтвортой өсөх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор дунд хугацаанд төсвийн нэгдмэл байдлыг хангасан зохистой бодлого хэрэгжүүлэн улсын төсвийг алдагдалгүй байлгаж, гадаад валютын орох урсгалыг нэмэгдүүлэх замаар төлбөрийн тэнцлийн тогтвортой байдлыг ханган, улсын өрийн зохистой удирдлагыг хэрэгжүүлж ажиллахыг Монгол Улсын Засгийн газар /Ч.Сайханбилэг/-т даалгасугай.

3. Доор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Ч.Сайханбилэг/, Монголбанк /Н.Золжаргал/, Санхүүгийн зохицуулах хороо /З.Нарантуяа/-нд тус тус даалгасугай:

1/Санхүүгийн тогтвортой байдлыг хангах, санхүүгийн салбарт эрсдэл хуримтлагдахаас сэргийлэх арга хэмжээний хүрээнд активын удирдлагын мэргэшсэн институцийг хөгжүүлж, эрх зүйн орчныг сайжруулах;

2/Ази, номхон далайн орнуудын мөнгө угаахтай тэмцэх бүлгээс хийх хамтын үнэлгээг хамтран зохион байгуулах, Монгол Улсын үнэлгээг дээшлүүлэх арга хэмжээг авах замаар эдийн засгийн эерэг орчныг дэмжих.

4. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороо (Ж.Батсуурь)-нд үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА****З.ЭНХБОЛД**

*Монгол Улсын Их Хурлын
2015 оны ... сарын ...-ны өдрийн
... дугаар тогтоолын хавсралт*

ТӨРӨӨС МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ТАЛААР 2016 ОНД БАРИМТЛАХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ

Мөнгөний бодлогын үндсэн зорилт нь эдийн засгийн урт хугацааны тогтвортой өсөлтийн суурь болох макро эдийн засгийн тэнцвэрийг хангаж, банк, санхүүгийн тогтвортой байдлыг хадгалахад чиглэнэ.

1. Мөнгөний бодлогын зорилтын хүрээнд:

1.1. Хэрэглээний үнийн индексээр хэмжигдэх инфляцийг 2016 оны эцэст 7 хувьд, 2017-2018 онд 5-7 хувьд тогтворжуулсны үндсэн дээр эдийн засгийн гадаад, дотоод тэнцвэрийг ханган эдийн засаг тогтвортой өсөх нөхцөл бүрдүүлнэ.

1.2. Төгрөгийн гадаад валюттай харьцах ханш нь эдийн засгийн суурь нөхцөлтэй нийцтэйгээр уян хатан тогтох зарчмыг баримтална.

2. Банкны салбарын тогтвортой байдлыг бэхжүүлэх хүрээнд:

2.1. Банкуудын төлбөрийн чадварыг хадгалж, санхүүгийн тогтвортой байдлыг хангах, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ.

2.2. Олон улсад мөрдөгдөж байгаа хяналт шалгалтын зарчим, зохицуулалтын арга хэрэгслийг банкны салбарын үйл ажиллагааны онцлогтой уялдуулан эрсдэлийн үнэлгээнд суурилсан хяналт шалгалтын шинэчлэлийг үргэлжлүүлнэ.

2.3. Санхүүгийн тогтвортой байдлыг хангах, үр нөлөөтэй хяналт шалгалтыг боловсронгуй болгох чиглэлээр дотоод, гадаадын эрх бүхий байгууллагуудтай хамтын ажиллагааг өргөжүүлнэ.

3. Санхүүгийн зах зээлийн дэд бүтэц, түүний институцийг бэхжүүлэх хүрээнд:

3.1. Монгол Улсын төлбөрийн системийн найдвартай, тасралтгүй ажиллагааг ханган, төлбөрийн системийн шинэчлэлийг эрчимжүүлж, эрх зүйн орчныг сайжруулна.

3.2. Санхүүгийн салбарын активын удирдлагын бүтцийг төрөлжүүлэх, хоёрдогч зах зээлийг хөгжүүлэх ажлыг эхлүүлнэ.

3.3. Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөрийг холбогдох байгууллагатай хамтран үе шаттай хэрэгжүүлнэ.

I. ТӨРӨӨС МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ТАЛААР 2016 ОНД БАРИМТЛАХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын эдийн засаг дэлхийн зах зээл дэх эрдэс түүхий эдийн үнийн мөчлөг болон уул уурхайн олборлох үйлдвэрлэлийн салбараас хэт хамааралтай байж ирсэн. Тухайлбал, сүүлийн 5 жилийн дунджаар экспортын 90 гаруй хувь, эдийн засагт цэвэр дүнгээр орж ирсэн гадаадын шууд хөрөнгө оруулалтын 80 гаруй хувь нь зөвхөн уул уурхайн салбарт ногдож байв. Гэтэл 2012 оноос эхлэн дэлхийн зах зээлд түүхий эдийн үнэ буурч, уул уурхайн бүтээгдэхүүний үнийн супер мөчлөг үндсэндээ дуусгавар боллоо. Энэ нь манай улсын эдийн засагт 2012 оны сүүлийн хагасаас эхлэн гадаад худалдааны нөхцөл муудах, экспортын бүтээгдэхүүний үнэ дунджаар 30-70 хувиар буурах, гадаадын шууд хөрөнгө оруулалт цэвэр дүнгээр гуравхан жилийн дотор ДНБ-ий 45 хувьтай тэнцэх түвшнээс 2 хувьтай тэнцэх хэмжээнд хүртэл огцом буурах зэрэг сувгаар дамжин сөрөг нөлөөлөл бий болгосон юм.

Гадаад секторын эрсдэл өндөртэй, төлбөрийн тэнцлийн огцом цочролтой, гадаад санхүүжилтийн хүндрэл бүхий нэн сөрөг орчинд Монгол Улсын макро эдийн засгийн бодлогод 12 хувийн бодит өсөлттэй эдийн засгийг богино хугацаанд огцом агшуулах уу, эсвэл эдийн засаг дахь шаардлагатай тохиргоог алгуур хийлгэж, эдийн засгийг дунд хугацаанд зөөлөн газардуулах уу гэсэн бодлогын хоёр л сонголт байсан юм.

Эдгээр сонголтоос Монголбанк мөнгөний уламжлалт болон уламжлалт бус бодлогын хүрээнд макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, санхүүгийн тогтвортой байдлыг хадгалах, эдийн засгийг зөөлөн газардуулах бодлогын арга хэмжээг 2012 оны сүүлээс эхлэн үе шаттай хэрэгжүүлсэн. Үүний үр дүнд макро эдийн засгийн тогтвортой байдлыг хадгалан, санхүүгийн салбарт системийн шинжтэй эрсдэл үүсэхээс урьдчилан сэргийлж, эдийн засаг богино хугацаанд огцом агших, ажилгүйдэл эрс нэмэгдэх, санхүү-эдийн засаг-нийгмийн хямрал бий болох аюулаас зайлсхийсэн болно.

Эдийн засгийг зөөлөн газардуулах, макро эдийн засгийн тэнцвэрийг хангахад чиглэсэн мөнгөний бодлогын багц арга хэмжээний нөлөөгөөр эдийн засаг, санхүүгийн салбарт дараах эерэг өөрчлөлтүүд бий болоод байна. Үүнд:

- Инфляцийн бүтцэд зарчмын эерэг өөрчлөлт гарч нийлүүлэлтийн гаралтай инфляцийн дарамт буурч, эрэлтийн гаралтай инфляцийг хязгаарлан, төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийн инфляцид үзүүлэх сөрөг нөлөөллийг саармагжууллаа. Ингэснээр бага, дундаж орлоготой иргэдийн бодит орлогод ирэх ачааллыг зөөлрүүлж, жилийн инфляци 2012 оны 14.0 хувиас 2015 оны 8 дугаар сарын байдлаар 6.6 хувь болж бууран зорилтот түвшиндээ хүрээд байна.
- Санхүүгийн салбарт сүүлийн 2 жилд зээл тасалдах, активын чанар огцом муудах, банкуудын төлбөрийн чадвар, өөрийн хөрөнгийн хүрэлцээний зохистой харьцааны үзүүлэлтүүд алдагдах, дотоод актив үнэгүйдэх зэрэг болзошгүй байсан эрсдэлээс урьдчилан сэргийлж, банкны салбарын тогтвортой байдлыг хадгаллаа.

- Гадаад худалдаа 2006 оноос хойш анх удаа тэнцвэржин, 2014 онд 538 сая ам.доллар, 2015 оны эхний 8 сард 705 сая ам.долларын ашигтай гарлаа. 2015 оны эхний 8 сарын гадаад худалдааны тэнцлийг 2011-2013 оны дундажтай харьцуулахад гадаад худалдааны тэнцэлд 2.8 тэрбум ам.долларын эерэг өөрчлөлт гарсан байна. Ингэснээр төлбөрийн урсгал дансны алдагдлын ДНБ-д эзлэх хувь хэмжээ 2011-2013 оны дундаж -26 хувиас 2015 оны эхний хагаст -6 хувь болтол буураад байна. Төлбөрийн урсгал тэнцлийн алдагдал ийнхүү буурсан нь 2013 онд -1.9 тэрбум ам.доллар, 2014 онд -0.5 тэрбум ам.долларын алдагдалтай байсан төлбөрийн нийт тэнцэл 2015 оны эхний 7 сард 82 сая ам.долларын ашигтай гарахад эергээр нөлөөлөв. Улмаар төлбөрийн тэнцэл, нийт эдийн засагт шаардлагатай тохиргоо хийгдсэнээр гадаад валютын суурь эрэлт буурч, төгрөгийн гадаад валюттай харьцах ханш сулрах дарамт багасаад байна.

- Хөдөө аж ахуй, барилга, агуулахын аж ахуй зэрэг ашигт малтмалын бус салбар, бодит секторыг дэмжсэнээр ажилгүйдэл огцом нэмэгдэх эрсдэлээс сэргийлж, эдгээр салбарт ажлын байрыг хадгалах, улмаар нэмэгдүүлэхэд эергээр нөлөөлөн, уул уурхайн бус салбарын өсөлтөөр дамжуулан эдийн засгийн тэнцвэртэй өсөлтийг дэмжив.

- Дундаж давхаргын хуримтлалыг нэмэгдүүлэх бодлогыг эхлүүлснээр өрхийн зардлын бүтцэд зарчмын эерэг өөрчлөлт гарч өрхийн хуримтлал нэмэгдэн, эдийн засагт урт хугацаатай мөнгөний нийлүүлэлт өсч, инфляци урт хугацаанд нам, тогтвортой түвшинд байх нөхцөлийг бүрдүүлэхийн зэрэгцээ хөрөнгийн хоёрдогч зах зээлийн хөгжлийг дэмжиж байна. 2015 оны 8 дугаар сарын байдлаар орон сууцны ипотекийн зээлдэгчдийн тоо 74 мянгад хүрч, 2012 оны эцсээс 2.5 дахин, орон сууцны ипотекийн зээлийн үлдэгдэл 3267 тэрбум төгрөгт хүрч, 2012 оны эцсээс 3.9 дахин өсч, орон сууцны ипотекийн зээлийн ДНБ-д эзлэх хувь хэмжээ 2012 оны 5.1 хувиас 2015 онд 14.9 хувь болж өсөөд байна.

Монгол Улсын Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлөөс 2015 оны эхэнд эдийн засаг, санхүүгийн салбарын нөхцөл байдал, цаашдын төлөвт үнэлгээ, дүгнэлт хийсний үндсэн дээр (i) гадаад валютын орох урсгалыг нэмэгдүүлж төлбөрийн тэнцлийг сайжруулах, (ii) улсын төсвийн зохистой бодлого хэрэгжүүлж төсвийг алдагдалгүй байлгах, (iii) эдийн засгийн бүтцийн шинэчлэлийг эрчимжүүлэх, (iv) төлбөрийн тэнцлийн 2013-2014 оны хүндрэлийн сөрөг нөлөөгөөр санхүүгийн салбарт эрсдэл хуримтлагдахаас сэргийлэх зорилго бүхий Макро бодлогын өөрчлөлтийн нэгдсэн төлөвлөгөө (СМАР)-г боловсруулахаар шийдвэрлэсэн. Засгийн газар, Монголбанкнаас хамтран боловсруулж өргөн мэдүүлсэн баримт бичгийн төсөлд үндэслэн Улсын Их Хурлаас 2015 оны 2 дугаар сард “Эдийн засгийн хүндрэлээс гарах арга хэмжээний хөтөлбөр батлах тухай” 41 дүгээр тогтоолыг баталсан юм.

Энэхүү тогтоолыг хэрэгжүүлж байгаагийн нөлөөгөөр болон мөнгөний бодлогын төлөвийг 2014 оны 2 дугаар хагасаас эхлэн макро эдийн засгийн гадаад тэнцвэрийг дэмжих чиглэлд өөрчилсөнтэй уялдан 2015 оны эхний 7 сарын урьдчилсан гүйцэтгэлээр Монгол Улсын төлбөрийн нийт тэнцэл алдагдалгүй гараад байна.

Гэхдээ Монгол Улсын эдийн засагт цэвэр дүнгээр орж ирсэн гадаадын шууд хөрөнгө оруулалт (ГШХО) сэргээгүй хэвээр, 2015 оны эхний хагас жилийн урьдчилсан гүйцэтгэлээр ГШХО 44 сая ам.доллар буюу ДНБ-ий 1 хувьтай тэнцэх хэмжээнд болж буураад байна. Макро эдийн засгийн шинэ тэнцвэрийг ханган бэхжүүлж, эдийн засгийн урт хугацааны тогтвортой, “эрүүл” өсөлтийн суурийг хангахад гадаадын шууд хөрөнгө оруулалтыг дор хаяж ДНБ-ий 15-20 хувьтай тэнцэх хэмжээнд хүргэж нэмэгдүүлэх, энэ түвшинд тогтвортой байлгахын зэрэгцээ гадаадын шууд хөрөнгө оруулалтын бүтцийг төрөлжүүлэх шаардлагатай гэж үзэж байна. Нөгөө талаар гадаадын шууд хөрөнгө оруулалт сэргэх хүртэлх хугацаанд макро эдийн засгийн тэнцвэрийг хангахад хэрэгцээтэй байгаа гадаад валютын эх үүсвэрийг гадаад зээллэг, багцын (портфолио) хөрөнгө оруулалт зэрэг бусад арга замыг оновчтой ашиглах замаар бүрдүүлэх нь чухал байна.

Эдийн засгийн гадаад орчин таагүй, тодорхой бус байдал үргэлжилсэн, хөрөнгө оруулалтын орчинд үүссэн сөрөг хүлээлт арилаагүй хэвээр, гадаад орчны таагүй нөхцөл байдал 2016 онд ч үргэлжлэхээр байна. Тухайлбал, БНХАУ-ын эдийн засгийн бодит өсөлт 7 хувиас бага болж буурах, ДНБ-ий өсөлтийн хурдац нь саарч байгаа хандлага цаашид үргэлжлэх, дэлхийн зах зээлд эрдэс түүхий эдийн эрэлт сул, үнэ нь өсөхөөргүй байх төлөвтэй байна. Хятадын хөрөнгийн зах зээлд огцом уналт /тохиргоо/ гарч, аж үйлдвэрлэлийн Caixin PMI индекс энэ оны 8 дугаар сард 2009 оноос хойших хамгийн доод түвшин буюу 47.3 болсон нь тус улсын төдийгүй худалдааны гол түнш орнуудын эдийн засгийн өсөлтөд ч сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй гэж олон улсын судалгааны байгууллагууд үзэж байгаа юм. ОХУ-ын эдийн засаг 2015 оны 2 дугаар улиралд 4.6 хувиар агшсан бөгөөд цаашид хүлээгдэж байснаас ч илүү хэмжээгээр буюу оны сүүлийн хагаст 3.5-3.6 хувиар агших эрсдэлтэй болоод байна. АНУ, Евро бүс, Японы эдийн засгийн суурь асуудал шийдвэрлэгдээгүй хэвээр, тодорхой бус байдал нь улам нэмэгдэхээр байна.

Хэрэв гадаад эдийн засгийн орчин сайжирч гадаад эрэлт нэмэгдэхгүй, Монгол Улсын эдийн засагт орж ирэх гадаад валютын урсгал, тэр дундаа гадаадын шууд хөрөнгө оруулалт сайжрахгүй, улсын төсөв алдагдалтай хэвээр байх, улмаар төсвийн алдагдлын хэмжээ цаашид өсөх зэргээр сөрөг өөрчлөлтүүд үргэлжлэх тохиолдолд улсын төсөв, мөнгөний бодлогын орон зай улам хязгаарлагдаж, макро эдийн засгийн тэнцвэрийг хангахад хүндрэлтэй болох эрсдэлтэй байна.

Дунд хугацаанд гадаад валютын орох урсгалыг нэмэгдүүлэх замаар төлбөрийн тэнцлийг алдагдалгүй хэвээр байлгах, төсвийн нэгдмэл байдлыг хангасан зохистой бодлого хэрэгжүүлж улсын төсвийг алдагдалгүй болгох, улсын өрийн зохистой удирдлагыг хэрэгжүүлж ажиллах нь эдийн засгийн гадаад, дотоод шинэ тэнцвэр (new normal equilibrium)-ийг бүрэн хангаж, инфляцийг дунд хугацаанд 5-7 хувьд байлгах нөхцөл бүрдүүлэн цаашид эдийн засаг тогтвортой өсөх нөхцөлийг бүрдүүлнэ гэж үзэж байна. Ийм учраас 2016 оны мөнгөний бодлогын үндсэн зорилт нь эдийн засгийн урт хугацааны тогтвортой өсөлтийн суурь болох макро эдийн засгийн тэнцвэрийг хангаж, банк, санхүүгийн тогтвортой байдлыг хадгалахад чиглэх болно.

1. МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД:

1.1. Хэрэглээний үнийн индексээр хэмжигдэх инфляцийг 2016 оны эцэст 7 хувьд, 2017-2018 онд 5-7 хувьд тогтворжуулсны үндсэн дээр эдийн засгийн гадаад, дотоод тэнцвэрийг ханган эдийн засаг тогтвортой өсөх нөхцөл бүрдүүлнэ.

Төв банк инфляцийг нам тогтвортой түвшинд байлгах замаар иргэдийн бодит орлогыг хамгаалах, эдийн засгийн тогтвортой өсөлтийн суурь орчинг бүрдүүлэхийг зорьж байна. Монголбанкнаас 2016 онд хэрэгжүүлэх мөнгөний бодлогын стратегийг дараах хүрээнд тодорхойлж байна. Үүнд:

1. Монголбанк дунд хугацааны буюу 2016-2018 онуудад хэрэглээний үнийн индекс (ХҮИ)-ээр илэрхийлсэн инфляцийн зорилтыг 5-7 хувь (2016 онд 7 хувь, 2017-2018 онд 5-7 хувь) хэмээн тодорхойлж байна. Инфляцийн зорилтыг ийнхүү дунд хугацаагаар тодорхойлж байгаа нь нэгд, 2015 оны эцэст инфляцийн зорилт хангагдахаар хүлээгдэж байгаатай, хоёрт, Монгол Улсын эдийн засагт шинэ тэнцвэр тогтоож, эдийн засгийн дунд хугацааны тогтвортой өсөлтийн суурь нөхцөл нь инфляцийн 5-7 хувийн зорилтыг хангах гэж үзсэнтэй, гуравт, мөнгөний бодлогын үр нөлөө нь тодорхой хугацааны хоцролттойгоор илэрдэгтэй тус тус холбоотой юм. Монголбанк инфляцийн дунд хугацааны зорилтот түвшнийг тодорхойлохдоо дэлхийн зах зээл дэх түүхий эдийн үнийн мөчлөг, хөрөнгийн урсгалын төлөв байдалтай уялдаж улсын төсөв, төрийн санхүүгийн бодлогод төрөөс шаардлагатай тохиргоог хийж төсөв, төлбөрийн тэнцлийг алдагдалгүй байлгах, санхүүгийн салбарын болзошгүй эрсдэлээс сэргийлэх, шинэ макро тэнцвэр бүхий эдийн засгийг 2016 оноос эхлэн тогтвортой, эрүүл хурдаар тэлэх суурь нөхцөлүүдийг бүрдүүлэх зэрэг хүчин зүйлсийг харгалзан үзэв. ХҮИ-ээр илэрхийлсэн инфляци нь дундаж айл өрхийн хэрэглээний сагсны өртөг хэрхэн хувьсаж буйг илтгэх ба хүн амын амьжиргаанд гарч буй өөрчлөлтийг үнэлэхэд хамгийн тохиромжтой үзүүлэлт билээ. 2015 оны 8 дугаар сарын эцэст улсын инфляци жилийн 6.6 хувь, Улаанбаатар хотын инфляци 5.9 хувьтай байна.

2. Урьдчилж таамаглах боломжгүй гэнэтийн хүчин зүйлсийн улмаас инфляцийн түвшин зорилтот түвшнээс хазайсан тохиолдолд Төв банкны зүгээс авах хариу арга хэмжээ нь уг гэнэтийн сөрөг хүчин зүйлийн мөн чанар, шалтгаан, түүний үргэлжлэх хугацаа (түр зуурын үзэгдэл үү, эсвэл байнгын шинжтэй удаан хугацааны нөлөөлөл үү?), инфляцийн хүлээлт дэх нөлөөлөл зэргээс хамаарч харилцан адилгүй байна.

3. Монголбанк мөнгөний бодлогыг төгрөгийн гадаад валюттай харьцах ханш нь эдийн засгийн суурь нөхцөлтэй нийцтэйгээр уян хатан тогтох зарчмыг үргэлжлүүлэн баримтлах буюу хөвөгч ханшийн дэглэмтэйгээр хэрэгжүүлэх болно. Монголбанк валютын захад ханшийн огцом хэлбэлзлийг зөөлрүүлэх, валютын зах дахь зохисгүй хүлээлтийг зохицуулах зорилгоор оролцдог зарчмаа үргэлжлүүлэн баримтална. Валютын уян хатан, хөвөгч ханшийн дэглэм нь зах зээлд оролцогчдод ханшийн өөрчлөлтөд дасан зохицох

боломжийг олгож, гадаад орчны таагүй өөрчлөлтөөс дотоодын эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг зөөлрүүлэхэд чухал үүрэгтэйгээс гадна хүүний түвшинг үр ашигтай удирдах угтвар нөхцөлийг бүрдүүлнэ.

4. Мөнгөний бодлого аль чиглэлд өөрчлөгдөж (суларч, эсвэл чангарч) буйн дохио нь Монголбанкны мөнгөний бодлогын үндсэн хэрэгсэл болох Бодлогын хүү байх болно. Монголбанк бодлогын хүүний түвшинд өөрчлөлт оруулах замаар нийт эрэлтэд нөлөөлөх ба инфляцийн зорилтот түвшинг хангаж ажиллана. Санхүүгийн захын үнэ бүрдэх үйл явцад шууд оролцохоос зайлсхийхийн тулд Монголбанкны мөнгөний бодлогын хүү нь (Төв банкны 7 хоногтой үнэт цаасны хүүгээр илэрхийлэгддэг) өгөөжийн муруйн зөвхөн эхний хэсгийг тодорхойлно. Инфляцийн зорилтыг хангаж ажиллахын тулд Монголбанкны Мөнгөний бодлогын зөвлөл (МБЗ) нь улирал бүр макро эдийн засгийн төлөв байдал, таамаглалыг иж бүрэн үнэлж, хэлэлцсэний үндсэн дээр бодлогын хүүнд өөрчлөлт оруулах эсэхийг шийдвэрлэнэ. МБЗ-ийн сүүлийн 4 шийдвэрийг авч үзвэл 2014 оны 7 дугаар сард мөнгөний бодлогын хүүг 1.5 нэгж хувиар нэмэгдүүлэх, 2015 оны 1 дүгээр сард 1.0 нэгж хувиар нэмэгдүүлэх, 4 болон 7 дугаар сарын хурлаар өөрчлөлгүй хэвээр хадгалах шийдвэр гаргасан билээ. Бодлогын хүү нь банк хоорондын захын хүүг тодорхойлох ба хүүний корридорыг 2013 оны 2 дугаар сараас нэвтрүүлснээр банк хоорондын захын хүү бодлогын хүүний ойролцоо хэлбэлзэх болсон. Ийнхүү мөнгөний захын үнийг тодорхойлж буй бодлогын хүү, банк хоорондын захын хүү нь эдийн засаг дахь бусад хүү, санхүүгийн активуудын үнэ болон валютын ханшинд нөлөөлснөөр иргэд, аж ахуйн нэгжүүдийн хэрэглээ, хуримтлал, хөрөнгө оруулалт, улмаар инфляцийн түвшинд нөлөөлнө.

5. Монголбанк мөнгөний бодлогыг хэрэгжүүлэхдээ санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангах, банкны салбарын тогтвортой байдлыг бэхжүүлэх зорилттой нягт уялдуулна. Санхүүгийн салбарын тогтвортой байдал нь урт хугацаанд үнийн тогтвортой байдлыг хангахад чухал үүрэг гүйцэтгэнэ. Нөгөө талаас банкны салбарын тогтвортой байдал нь мөнгөний бодлогын шилжих механизмыг хэрэгжүүлэх зайлшгүй нөхцөл нь болох билээ.

6. Монголбанк эрсдэлийн үнэлгээнд суурилсан макро/микро зохистой бодлогын арга хэрэгслийг мөнгөний бодлоготой нягт уялдуулснаар санхүүгийн салбарт эрсдэл хуримтлагдахаас сэргийлж ажиллана. Ялангуяа валютын зээлийн эрсдэлийг зөв үнэлэх, орон сууцны ипотекийн зээлийн өсөлтийг зохистой түвшинд байлгах, зээлийн төвлөрлийг сааруулж, зээлийн багцын чанарыг сайжруулах, банкуудын валютын ханшийн эрсдэлийг удирдах чадавхийг сайжруулахад макро/микро зохистой бодлогын арга хэмжээг чиглүүлнэ. Ийнхүү макро/микро зохистой бодлогыг мөнгөний бодлогын уламжлалт арга хэрэгсэлтэй нягт уялдуулах замаар эдийн засгийн дотоод, гадаад тэнцвэртэй орчинг бий болгон бэхжүүлэх, банк, санхүүгийн тогтвортой байдлыг хадгалах боломж бүрдэнэ гэж үзэж байна.

7. Монголбанк мөнгөний бодлогын хэрэгслүүд, барьцааны төрөл зүйлийг санхүүгийн захад гарч болзошгүй өөрчлөлт, хөдөлгөөнтэй уялдуулан тухай бүр зохицуулах болно. Мөнгөний бодлогын арга хэрэгслүүдийн уян хатан байдлыг хангах нь мөнгөний бодлогын


шилжих механизмын үр ашгийг дээшлүүлэхийн сацуу санхүүгийн болон макро эдийн засгийн тогтвортой байдлыг дэмжсэнээр урт хугацаанд үнийн тогтвортой байдлыг хангахад чухал үүрэг гүйцэтгэх болно.

8. Монголбанк эдийн засгийг зөөлөн газардуулах, нийлүүлэлтийн гаралтай инфляцийн дарамтыг бууруулах зорилгоор *“Гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах дунд хугацааны хөтөлбөр”*-ийг Засгийн газартай хамтран хэрэгжүүлсэн. Хөтөлбөрийн үр дүнд нийлүүлэлтийн гаралтай инфляцийн нийт инфляцид эзлэх хувь хэмжээ 2010-2012 онд 1/3-тэй тэнцэж байсан бол 2013 онд 1/6, 2014 онд 1/20-тэй тэнцэх хэмжээнд болж бууран, 2015 оны эхнээс нийлүүлэлтийн инфляцийн дарамт арилсан. Өөрөөр хэлбэл, хөтөлбөрийн үр дүнд мах, гурил, жижиглэнгийн худалдааны шатахуун зэрэг гол нэрийн бүтээгдэхүүний үнийн нийт инфляцид үзүүлэх нөлөө мэдэгдэхүйц буурсан. Тухайлбал, 2010-2012 онуудад жил бүр дунджаар 34 хувиар өсдөг байсан махны үнэ хөтөлбөр хэрэгжсэн 2013 онд дунджаар 5.6 хувиар, 2014 онд дунджаар 1.0 хувиар өссөн байна. Харин 2015 оны эхний хагас жилд махны үнэ өмнөх оны мөн үеэс буурчээ. Энэхүү хөтөлбөр нь шатахуун, мах, улаан буудайны жижиглэнгийн үнийг тогтворжуулж, агуулахын үлдэгдлээр баталгаажсан сертификатын санхүүжилтийн тогтолцоог санхүүгийн зах зээлд шинээр бий болгов. Монголбанк 2013-2015 онд анх төлөвлөсний дагуу хөтөлбөрөөс үе шаттай гарснаар цаашид хөтөлбөрийн схем, тогтолцоог Монголбанкны оролцоогүйгээр Засгийн газар, хувийн хэвшил үргэлжлүүлэх боломжтой болсон. УИХ-ын 2015 оны 41 дүгээр тогтоолоор баталсан *“Эдийн засгийн хүндрэлээс гарах арга хэмжээний хөтөлбөр”*-ийн 2.1 дэх заалтын дагуу Засгийн газар хөтөлбөрийн зээлийн үлдэгдлийг Монголбанкнаас Хөгжлийн банкинд шилжүүлэх үйл ажиллагаа хэрэгжиж байна. Энэ хүрээнд *“Үнэт цаасаар зээлийн авлага шилжүүлэх арилжааны гэрээ”*, *“Гэрээний эрх, үүрэг шилжүүлэх гэрээ”*, *“Засгийн газрын санхүүгийн зуучлагчийн гэрээ”*, *“Засгийн газрын үнэт цаас худалдах, худалдан авах гэрээ”* гэсэн 4 гэрээг байгуулахаар ажиллаж байна. Ийнхүү *“Гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах дунд хугацааны хөтөлбөр”*-ийн өмчлөл, зээлийн үлдэгдлийг Засгийн газар Монголбанкнаас шилжүүлэн авч байна. Харин *“Орон сууцны ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бүрдүүлэх хөтөлбөр”*-ийн өмчлөлийг Засгийн газар өөрт шилжүүлэн авах хүртэлх хугацаанд Монголбанк Засгийн газартай гэрээ байгуулсны үндсэн дээр уг хөтөлбөрийг үргэлжлүүлнэ.

Шигтгээ 1. Инфляцийн зорилтыг дунд хугацаагаар томъёолох шаардлага

Төв банкны тухай хуулийн дагуу Монголбанк төрөөс мөнгөний бодлогын талаар дараа онд баримтлах үндсэн чиглэл, түүний дотор инфляцийн зорилтыг (2015 онд 7%) жил бүрийн 10 дугаар сарын 1-ний дотор УИХ-д өргөн барьж батлуулдаг билээ. Инфляцийн зорилтыг жил бүр томъёолох нь хэр оновчтой бөгөөд зохистой вэ? Аливаа бодлогын нөлөө нь эдийн засагт тэр дороо шууд бус, харин тодорхой хугацааны дараа нөлөөлдөг. Мөнгөний бодлого ч ялгаагүй мөнгөний бодлогын шилжих механизмаар дамжин инфляцид нөлөөлөхөд хугацаа шаардагддаг бөгөөд тэрхүү хугацаа нь “удаан бөгөөд хувьсамтгай” (Friedman, 1972) байдаг байна.

Зураг 1. Мөнгөний бодлогын шилжих механизмын бүдүүвч



Эх сурвалж: Монголбанк

2012 онд Navranek болон Rusnak нар өмнө нь нийтлэгдсэн 67 судалгаа шинжилгээний ажлыг нэгтгэн 30 орны мөнгөний бодлогын нөлөөллийн хугацааны хоцролтыг задлан шинжилж үзэхэд дунджаар 33.5 сар буюу 2 жил 9 сар байгааг тогтоожээ. Тэд хөгжингүй улс орнуудад бодлогын нөлөө нь 25-50 сарын дараа, харин Зүүн-Европын орнуудад 10-20 сарын дараа буюу харьцангуй хурдан хугацаанд бүрэн илэрдэг хэмээн дүгнэсэн байна. Судалгааны үр дүнгээр Монгол Улсад зээл, мөнгөний агрегатад өөрчлөлт орсноос хойш түүний инфляци, ДНБ-д бүрэн нөлөөлөх хугацаа нь хамгийн багадаа 12 сар буюу 1 жил байна. Ийм нөхцөлд инфляцийн зорилтыг жил бүр өөрчлөн томъёолох нь бодлогын хэрэгсэл мэдрэгдэх хугацааны орон зайг хумих сөрөг үр дагавартай байж болзошгүй юм.

Хүснэгт 1. Мөнгөний бодлогын нөлөө эдийн засагт бүрэн мэдрэгдэх хугацаа

Хөгжингүй орнууд		Зүүн Европын орнууд	
Улс	Хугацаа, сар	Улс	Хугацаа, сар
АНУ	42.2	Польш	18.7
Евробүс	48.4	Чех	14.8
Япон	51.3	Унгар	17.9
Герман	33.4	Словак	10.7
Их Британи	40.4	Словени	17.6
Франц	51.3		
Итали	26.6		

Иймд, инфляцийн зорилтыг дунд хугацаагаар томъёолохын ач холбогдлыг харгалзан үзэж Монголбанк сүүлийн жилүүдэд инфляцийн зорилтыг дунд хугацаагаар тодорхойлж ирсэн бөгөөд 2016 онд инфляцийг 7%-д, 2017-2018 онд 5-7% түвшинд тогтвортой байлгах нь эдийн засаг “эрүүл” хурдаар, тогтвортой өсөх суурь нөхцөл болно гэж үзэж байна.

1.2. Төгрөгийн гадаад валюттай харьцах ханш нь эдийн засгийн суурь нөхцөлтэй нийцтэйгээр уян хатан тогтох зарчмыг баримтална.

2013-2015 онд экспортын голлох бүтээгдэхүүний эрэлт, гадаад худалдааны нөхцөл үргэлжлэн муудаж, гадаадын шууд хөрөнгө оруулалт огцом буурсан. Монголбанкнаас эдийн засгийг зөөлөн газардуулах бодлогын хүрээнд гадаад секторын нэн таагүй өөрчлөлтийн дотоодын эдийн засаг дахь сөрөг нөлөөллийг нэгд, макро эдийн засгийн нөхцөлтэй нийцтэйгээр уян хатан тогтох ханшаар, хоёрт, гадаад валютын улсын нөөцийн аль алианаар нь дамжуулан зөөлрүүлэх бодлогыг хэрэгжүүлсэн билээ.

Макро бодлогын нэгдсэн өөрчлөлтөөр эдийн засгийн тэнцвэрийг хангах бодлогыг хэрэгжүүлж, төгрөгийн гадаад валюттай харьцах ханш нь эдийн засгийн суурь нөхцөл байдалтай нийцтэйгээр уян хатан тогтож байх зарчмыг үргэлжлүүлэн баримталсны нөлөөгөөр төлбөрийн тэнцэл 2015 оны эхнээс алдагдалгүй гарах нөхцөл бүрдэж байна.

Удаан эдэлгээтэй хэрэглээний бараа, бүтээгдэхүүний импорт энэ оны эхний 8 сард 27 хувиар, түүний дотор автомашины импорт 31 хувиар, гэр ахуйн цахилгаан хэрэгсэл, тавилгын импорт 26 хувиар, гутал, хувцас, цүнхний импорт 18 хувиар тус тус буурчээ. Харин хэрэглээний импорт 21 хувиар, нийт импорт 30 орчим хувиар тус тус буураад байна. Ингэснээр гадаад худалдааны ашиг 2014 оны 10 дугаар сараас хойш 11 сарын турш тогтвортой хадгалагдаж, төлбөрийн урсгал тэнцлийн алдагдал 2015 оны эхний 7 сарын урьдчилсан гүйцэтгэлээр өмнөх оны мөн үеэс 912 сая ам.доллараар буурч 410 сая ам.долларт хүрсэн буюу ДНБ-ий 6 хувьд хүртэл буураад байна. Ийнхүү урсгал тэнцлийн алдагдал буурч, гадаадын шууд хөрөнгө оруулалтаас бусад санхүүгийн хөрөнгө оруулалт буюу багцын хөрөнгө оруулалт нэмэгдсэн нь төлбөрийн нийт тэнцэл оны эхний 7 сарын урьдчилсан гүйцэтгэлээр 82 сая ам.долларын ашигтай гарахад эергээр нөлөөллөө.

Төлбөрийн тэнцэлд шаардлагатай тохиргоо сүүлийн 3 жилийн турш хийгдэж, 2015 оноос эхлэн алдагдалгүй болж байгаатай уялдан оны эхнээс валютын зах харьцангуй тогтвортой, валютын ханшийн дундаж хэлбэлзэл өмнөх онуудтай харьцуулахад буурах хандлагатай байв. Гадаад валютын улсын нөөц 2015 оны 7 дугаар сарын байдлаар 1.7 тэрбум ам.доллар буюу сүүлийн 3 сарын дунджаар тооцсон импортын 5.3 сарын хэрэгцээг хангах түвшинд байлаа.

Монголбанк төгрөгийн гадаад валюттай харьцах ханш нь эдийн засгийн суурь нөхцөлтэй нийцтэйгээр уян хатан тогтох зарчмыг цаашид үргэлжлүүлэн баримтлах бөгөөд энэ нь дунд болон урт хугацаанд дотоодын үйлдвэрлэл, экспорт, нийт эдийн засгийн өрсөлдөх чадварыг сайжруулахад эергээр нөлөөлнө гэж үзэж байна. Банкуудын гадаад зах зээлээс урт хугацаатай эх үүсвэр татах үйл ажиллагаа нь макро эдийн засгийн гадаад тэнцвэр болон Монгол Улсын гадаад активт эерэг нөлөөтэй учраас уг үйл ажиллагааг дэмжих бодлого, зохицуулалтыг Монголбанк үргэлжлүүлнэ.

2. БАНКНЫ САЛБАРЫН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫГ БЭХЖҮҮЛЭХ ХҮРЭЭНД:

2.1. Банкуудын төлбөрийн чадварыг хадгалж, санхүүгийн тогтвортой байдлыг хангах, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ.

Банкуудын үйл ажиллагаа нь Банкны тухай хууль тогтоомж, Монголбанкнаас баталсан журам, заавар, зохистой харьцааны хэм хэмжээтэй нийцэж байгаа эсэхэд зайнаас тогтмол хяналт тавьж ажиллана. Үүний зэрэгцээ банкуудын өөрийн хөрөнгийн хүрэлцээ, төлбөрийн чадвар, үйл ажиллагааны эрсдэлийн түвшинг газар дээр нь иж бүрэн, хэсэгчилсэн, гэнэтийн хяналт шалгалт хийж гүйцэтгэн илэрсэн зөрчлийг арилгах хүрээнд холбогдох арга хэмжээг эдийн засгийн нөхцөл байдал, тухайн банкны санхүүгийн чадвар, онцлог, системд үзүүлэх эрсдэлийг харгалзсаны үндсэн дээр авч хэрэгжүүлэх болно.

Банкуудад учирч болзошгүй алдагдлыг барагдуулах, эрсдэл даах чадварыг нэмэгдүүлэх зорилгоор хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг шинэчлэн тогтоож, 2017 онд багтаан биелүүлэх хугацаатай үүргийг Монголбанкнаас өгсөн бөгөөд банкуудаас ирүүлсэн хувь нийлүүлсэн хөрөнгийг нэмэгдүүлэх төлөвлөгөөнд банкны актив хөрөнгийн хэмжээ, үйл ажиллагааны онцлогийг харгалзан дүн шинжилгээ хийж, төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана.

Санхүүгийн тогтвортой байдлыг хангах хүрээнд макро-зохистой хяналт шалгалтын үндсэн арга хэрэгсэл болдог шинжилгээг нийт систем болон банк тус бүрийн үйл ажиллагааны онцлог, системд үзүүлэх нөлөөлөлд нийцүүлэн гүйцэтгэнэ. Шинжилгээ тус бүрийн үр дүнд дүгнэлт хийж, шаардлагатай тохиолдолд бодлогын холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

Санхүүгийн тайлагналын олон улсын стандарттай нийцүүлэн “Банкны нягтлан бодох бүртгэлийн багц материал”-ыг 2016 оноос эхлэн мөрдүүлж байгаатай уялдан банкууд санхүүгийн тайлан мэдээг шинэ багц материалын дагуу, үнэн зөв тусгаж байгаа эсэхэд хяналт тавьж ажиллана.

2.2. Олон улсад мөрдөгдөж байгаа хяналт шалгалтын зарчим, зохицуулалтын арга хэрэгслийг банкны салбарын үйл ажиллагааны онцлогтой уялдуулан эрсдэлийн үнэлгээнд суурилсан хяналт шалгалтын шинэчлэлийг үргэлжлүүлнэ.

Монголбанкнаас боловсруулсан “Банкны хяналт шалгалтын дунд хугацаанд баримтлах стратеги”-д тусгасан ажлын төлөвлөгөөний дагуу хяналт шалгалтын аргачлалын үндсэн зарчмууд, өөрийн хөрөнгө болон бусад зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдэд тавигдах нэгдсэн стандартыг шат дараатайгаар нэвтрүүлэх ажлыг үргэлжлүүлнэ.

Монголбанкны хяналт шалгалтын аргачлалыг боловсронгуй болгох хүрээнд гүйцэтгэлд суурилсан аргачлалыг эрсдэлд суурилсан шинэ аргачлалтай хослуулж хэрэгжүүлэхээс гадна, хяналт шалгалтын үйл ажиллагааны бүтэц, зохион байгуулалтыг илүү оновчтойгоор өөрчлөн зохион байгуулах боломжийг судална.

Банкуудын төлбөрийн чадварыг илэрхийлэх өөрийн хөрөнгийн хүрэлцээ, эрсдэлээр жигнэсэн актив, хөрвөх чадварын харьцаа зэрэг санхүүгийн үндсэн үзүүлэлтүүдийг

олон улсад мөрдөгдөж буй шаардлагатай нийцүүлэн оновчтой тооцоолох, банкин дахь эрсдэлийн үнэлгээний үнэн зөв, бодит байдлыг хангах зорилгоор одоогоор мөрдөгдөж байгаа өөрийн хөрөнгийн зохистой харьцааны аргачлал, үр ашигтай байдалд дүн шинжилгээ хийж, аргачлалыг шинэчлэх ажлыг эхлүүлнэ.

Монголбанкны зээлийн мэдээллийн санд төвлөрөх мэдээллийн бүтцийг өөрчилж, төвлөрүүлэх ажлыг үргэлжлүүлнэ. Ингэснээр банкууд дотооддоо зээлийн эрсдэлээ зохистой, оновчтойгоор үнэлэх боломж бүрдэхээс гадна цаашид Базел стандартын зээлийн эрсдэлийг тооцох дотоод үнэлгээний суурь аргачлалд шаардагдах үзүүлэлтүүдийг олон улсын стандартад нийцүүлэн тооцох боломжийг бүрдүүлэх юм.

Зээл, бусад актив хөрөнгийн чанарт сөргөөр нөлөөлж буй хүчин зүйлс, эрсдэлийг бууруулах, эргэн төлөлтийн хугацааны шалгуураас гадна зээлдэгчийн төлбөрийн чадвар, ирээдүйд төлбөрөө эргэн төлөх боломж, цаашдын төлөв зэрэг чанарын бусад хүчин зүйлсийг давхар харгалзан үзэж зээл, активын зохих үнэлгээ, ангиллыг хийх иж бүрэн аргачлалыг боловсруулах ажлыг үргэлжлүүлэх болно.

2.3. Санхүүгийн тогтвортой байдлыг хангах, үр нөлөөтэй хяналт шалгалтыг боловсронгуй болгох чиглэлээр дотоод, гадаадын эрх бүхий байгууллагуудтай хамтын ажиллагааг өргөжүүлнэ.

Олон улсын санхүүгийн байгууллагуудаас системийн хяналт шалгалт ба болзошгүй эрсдэл, хямралаас сэргийлэх чадварыг сайжруулах хүрээнд хийсэн техник туслалцааны хөтөлбөрийн үр дүнд гаргасан санал, зөвлөмжийн дагуу санхүүгийн тогтвортой байдлыг сайжруулах арга хэмжээний талаарх төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана.

Гадаадын байгууллагуудтай хамтран ажиллах харилцан ойлголцлын санамж бичгийн хүрээнд, хянан шалгагчдын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, харилцан туршлага солилцох, хил дамнасан банкинд хийх хяналт шалгалт, зохицуулалтын бодлогыг боловсронгуй болгох, харилцан мэдээлэл солилцох арга хэмжээг үргэлжлүүлж, хамтын ажиллагааг цаашид өргөжүүлнэ.

3. САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ДЭД БҮТЭЦ, ТҮҮНИЙ ИНСТИТУЦИЙГ БЭХЖҮҮЛЭХ ХҮРЭЭНД:

3.1. Монгол Улсын төлбөрийн системийн найдвартай, тасралтгүй ажиллагааг ханган, төлбөрийн системийн шинэчлэлийг эрчимжүүлж, эрх зүйн орчныг сайжруулна.

Монгол Улсын эдийн засгийн тогтвортой өсөлтийг дэмжих, мөнгөний эргэлтийг хурдасгах, санхүүгийн тогтвортой байдлыг хангахад төлбөр тооцооны системийн тогтвортой ажиллагаа нэн чухал тул Монголбанк төлбөрийн системийн найдвартай, тасралтгүй ажиллагааг тогтмол ханган ажиллаж ирлээ.

Монгол Улсын эдийн засгийн мөчлөг, санхүүгийн зах зээлийн төлөв байдлаас хамаарч төлбөр тооцооны системээр дамжин хийгдэж буй банк хоорондын гүйлгээний тоо, дүн хэлбэлзэн өөрчлөгдөж байна. Төлбөрийн системийн оролцогч хооронд 2015 оны эхний

хагас жилийн байдлаар 27.3 их наяд төгрөгийн 11.2 сая ширхэг гүйлгээ хийгдсэн нь өнгөрсөн оны мөн үеэс гүйлгээний дүн 3.6 хувиар буюу 1 их наяд төгрөгөөр буурч, гүйлгээний тоо 16.7 хувиар буюу 1.6 сая ширхгээр өссөн үзүүлэлттэй байна.

Төлбөрийн картаар 2015 оны эхний хагас жилд нийт 962.5 тэрбум төгрөгийн, 19.7 сая ширхэг гүйлгээ хийгдэж, өмнөх оны мөн үеэс картын гүйлгээний дүн 244.8 тэрбум төгрөг буюу 34.1 хувиар, картын гүйлгээний тоо 5.3 сая ширхэг буюу 36.8 хувиар тус тус өсчээ. Төлбөрийн системийн оролцогч хооронд 2015 оны 8 дугаар сарын эцсийн байдлаар 39.3 их наяд төгрөгийн 20.4 сая ширхэг гүйлгээ, төлбөрийн картаар нийт 1.7 их наяд төгрөгийн 31.4 сая ширхэг гүйлгээ тус тус хийгдсэн байна.

Монгол Улсын төлбөрийн системийн найдвартай, үр ашигтай ажиллагааг дэмжих, хууль эрх зүйн орчныг сайжруулах, төлбөрийн системийн хяналтын чадавхыг бэхжүүлэх зорилгоор Дэлхийн банктай хамтран техник туслалцааны төсөл хэрэгжүүлэхээр баталсан. Дэлхийн банкны ажлын хэсэг манай улсын төлбөрийн системийн өнөөгийн байдалтай танилцаж, төлбөрийн системийн шинэчлэлийн хүрээнд цаашид авах арга хэмжээний талаар харилцан тохиролцоод байна. Монголбанк энэхүү төслийн хүрээнд төлбөрийн системийн эрх зүйн үндсийг тодорхойлон зохицуулах “*Үндэсний төлбөрийн системийн тухай хууль*”-ийн төслийг Дэлхийн банк болон холбогдох бусад байгууллагатай хамтран боловсруулна.

Монголбанк Азийн хөгжлийн банкны зээлийн санхүүжилтээр “*Төлбөрийн системийн шинэчлэл*” төслийг 2015 оноос эхлэн 3 жилийн хугацаанд хэрэгжүүлэхээр болсон. Уг төслийг хэрэгжүүлснээр өндөр технологид суурилсан төлбөр тооцооны системүүдийн харилцан уялдаа бүхий нэгдсэн дэд бүтэцтэй болж, банкны үйлчилгээний хүртээмж нэмэгдэн, одоогийн ашиглаж буй төлбөрийн системийг боловсронгуй болгож, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн түвшинд хүргэнэ.

3.2. Санхүүгийн салбарын активын удирдлагын бүтцийг төрөлжүүлэх, хоёрдогч зах зээлийг хөгжүүлэх ажлыг эхлүүлнэ.

Эдийн засгийн гадаад, дотоод таагүй нөхцөл байдлаас шалтгаалан санхүүгийн салбарын активын хөрвөх чадвар, чанар муудах эрсдэлтэй байна. Хөрвөх чадвар багатай, чанаргүй активуудын хэмжээ нэмэгдэхийн хэрээр банк, санхүүгийн байгууллагуудын хэвийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх, төлбөр түргэн гүйцэтгэх болон төлбөрийн чадварыг бууруулах, цаашлаад санхүүгийн салбарын хэмжээнд тогтворгүй байдал үүсгэх эрсдэлтэй байдаг. Иймд, санхүүгийн салбарт эрсдэл хуримтлагдахаас урьдчилан сэргийлэх зорилгоор бодлогын холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлага үүссэн. Тухайн нөхцөл байдалд үндэслэн Монголбанк активыг удирдах чиглэлээр ажлын хэсэг байгуулан улс орнуудын туршлага, одоогийн хууль эрх зүйн орчин болон активын удирдлагын институци байгуулах талаар судалгааны ажил хийсэн бөгөөд тус судалгааны хүрээнд хоёрдогч зах зээл дээр активыг үр ашигтай, мэргэжлийн түвшинд удирдах зохицуулалтыг бий болгосноор чанаргүй активаас үүсэх зардлыг оновчтойгоор бууруулж, системийн шинжтэй эрсдэлээс сэргийлж чадсан туршлагауд түгээмэл байгааг тогтоосон болно. Түүнчлэн гадны улс орнууд, ялангуяа Азийн орнуудаас зөвхөн манай улсад активын удирдлагын чиглэлээр мэргэшсэн үйл ажиллагаа төдийлөн явуулахгүй байгаа бөгөөд банк, санхүүгийн байгууллагуудын хурдацтай шинэчлэгдэж байгаа өнөөгийн нөхцөлд

активын удирдлагын бүтцийг төрөлжүүлж, хоёрдогч зах зээлийг хөгжүүлэх арга хэмжээ авах шаардлагатай болж байна.

Эдгээр туршлагаудад үндэслэн Монголбанк системийн хэмжээнд чанаргүй активын хэмжээг бууруулах, банкны салбарын эрсдэл даах чадварыг хадгалах зорилгоор санхүүгийн салбарын чанаргүй активыг хоёрдогч зах зээлд борлуулах, цаашид тэдгээрийг зөв зохистой удирдах боломжийг бүрдүүлж, урт хугацаанд уг үйл ажиллагааны оновчтой тогтолцоог хөгжүүлэх суурийг бүрдүүлэх ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран эхлүүлнэ.

3.3. Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөрийг холбогдох байгууллагатай хамтран үе шаттай хэрэгжүүлнэ.

Санхүүгийн тогтвортой байдал нь иргэдээс санхүүгийн зах зээлд итгэх итгэлийг бататгах, бүх нийтийн санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх, санхүүгийн зах зээлд оролцогчдын хууль ёсны эрх ашгийг хамгаалах, санхүүгийн гэмт хэрэг, зөрчлийн гаралтыг багасгах гэсэн хоорондоо нягт уялдаа бүхий зорилтуудыг хэрхэн хангаж байгаагаар мөн тодорхойлогддог. Санхүүгийн тогтвортой байдлыг дунд, урт хугацаанд хангах, санхүүгийн зах зээлийг хөгжүүлэхэд иргэдийн санхүүгийн суурь мэдлэг, боловсролыг дээшлүүлэх асуудал ач холбогдол өндөртэй хэвээр байна. Зах зээл өргөжин тэлж, дэвшилтэт технологи олноор нэвтэрч, банк, санхүүгийн салбар хөгжин, санхүүгийн зуучлал гүнзгийрэхийн хэрээр санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээний төрөл төрөлжин олширсоор байна.

Хөгжиж буй орнуудад иргэд нь санхүүгийн суурь мэдлэг сайтай байвал энэ нь урт хугацаанд эдийн засгийн өсөлт тогтвортой байх, улмаар ядуурал буурахад эерэг нөлөөтэй байдаг гэсэн олон улсын судалгаа бий. Харин олон нийтийн санхүүгийн суурь мэдлэг дутмаг, санхүүгийн бүтээгдэхүүний талаар ойлголт бага байх нь иргэд санхүүгийн оновчгүй шийдвэр гаргах, өрхийн төсөв санхүүгээс эхлээд нийт санхүүгийн системд хүртэл сөрөг үр дагавар үүсгэдэг байна. Ийм учраас олон нийтийн санхүүгийн суурь мэдлэг (ОНССМ)-ийг дээшлүүлэхэд чиглэсэн тусгайлсан хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлж буй орнуудын тоо сүүлийн жилүүдэд эрчимтэй нэмэгдэж байгаа бөгөөд 2011 оны байдлаар 26 орон уг хөтөлбөрийг хэрэгжүүлэх шатанд байсан бол 2013 онд 45 болж өсчээ.

Манай улсад иргэн, өрх гэрийн түвшинд санхүүгийн суурь мэдлэг хангалттай бус байгаагаас санхүүгийн буруу шийдвэр гаргаж эрсдэлд орох, энэ нь санхүүгийн салбарт сөрөг нөлөөлөл үүсгэх эрсдэлтэй байна. Харин хувь хүний санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлбэл зөвхөн тухайн хүний санхүүгийн эрсдэлийг бууруулаад зогсохгүй нийт санхүүгийн салбартаа урт хугацаанд эергээр нөлөөлнө гэж үзэж байна. Ийм учраас Монголбанк сүүлийн жилүүдэд Сангийн яам, Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, Санхүүгийн зохицуулах хороо, Монголын банкны холбоо, санхүүгийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг төрийн бус байгууллага, холбоод, их дээд сургуулиудтай хамтран, Дэлхийн банкны тусламжтайгаар олон нийтийн эдийн засаг, санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх суурь судалгааг хийж, “ОНССМ-ийг дээшлүүлэх дунд хугацаа /3-5 жил/-ны хөтөлбөр”-ийг боловсруулаад байна. Энэхүү хөтөлбөрийг үндэсний хэмжээнд хэрэгжүүлнэ.

**II. ТӨРӨӨС МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ТАЛААР 2015 ОНД БАРИМТЛАХ
ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙГ БАТЛАХ ТУХАЙ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2014 ОНЫ 69 ДҮГЭЭР ТОГТООЛЫН ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦ**
(2015 оны 8 дугаар сарын байдлаар)

3.1 Эдийн засгийн тогтвортой өсөлтийн суурийг бэхжүүлэх, дотоодын хуримтлалыг нэмэгдүүлэх, санхүүгийн зах зээлийн хөгжлийг дэмжих зорилгоор нийгмийн даатгал, тэтгэврийн сангийн тогтолцооны шинэчлэлийг эрчимжүүлэх, баялгийн сангийн эрх зүйн орчныг бүрдүүлэх, хөрөнгө оруулалтын сангуудыг бий болгох тэдгээрийг үе шаттай хөрөнгөжүүлэх [Засгийн газар, Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо].

Нийгмийн даатгал, тэтгэврийн даатгалын тогтолцооны шинэчлэлийг эрчимжүүлэх, урт хугацааны хуримтлалын тогтолцоог бий болгох, орон сууцны ипотекийн зээлийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоог тэтгэврийн даатгалын тогтолцоотой уялдуулах чиглэлээр судалгаа хийх, санал боловсруулах үүрэг бүхий Монгол Улсын Ерөнхий сайдын захирамжаар байгуулагдсан Ажлын хэсэгт Монголбанкны төлөөлөл 2015 оны 1 дүгээр сараас эхлэн ажилласан. Ерөнхий сайдын 2015.03.30-ны өдрийн 82 дугаар захирамжаар Ажлын хэсгийн бүтцийг өөрчилж, БХБЯ, СЯ, СЗХ зэрэг холбогдох байгууллагуудын төлөөллийг нэмж оруулсан. Тайлант хугацаанд ажлын хэсэг бүрэн бүрэлдэхүүнээр 4 удаа, дэд ажлын хэсгийн бүрэлдэхүүнээр 3 удаа хуралдсан болно.

Энэ хүрээнд тэтгэврийн даатгалын: (i) цалинд суурилсан хуваарилалтын тогтолцоо /defined benefit plan, unfunded/, (ii) хийсвэр нэрийн дансанд суурилсан хуваарилалтын тогтолцоо /notional defined contribution plan, unfunded/, (iii) бүрэн хуримтлалын тогтолцоо /defined contribution plan, fully funded/ гэсэн 3 хувилбарыг авч үзэн, хуваарилалтын тогтолцооноос хуримтлалын тогтолцоонд шилжих шилжилтүүд, үе шатууд, тэдгээрийн эерэг, сөрөг талуудыг оны эхний улиралд Монголбанкнаас ХАХНХЯ-тай хамтран судалж санал боловсруулан Ажлын хэсэгт танилцуулсан.

Монголбанкны эзэмшиж буй орон сууцны ипотекийн зээлээр баталгаажсан давуу эрхтэй бонд (ИЗББ)-ыг нийгмийн даатгалын сангийн активт үе шаттай шилжүүлэх (худалдах) санал, схемийг боловсруулж, ИЗББ-ын үнэлгээг хийж Ажлын хэсэгт оны эхний улиралд танилцуулав. Түүнчлэн, Монголбанк, Засгийн газар хооронд байгуулах Засгийн газрын санхүүгийн зуучлагчийн хувиар “Орон сууцны ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бүрдүүлэх хөтөлбөр”-ийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх гэрээний төслийг Монголбанкнаас боловсруулж, Сангийн яам, Ажлын хэсэгт хүргүүлсэн бөгөөд гэрээний төсөлд Засгийн газраас санал авах шатанд байна.

Баялгийн сангийн эрх зүйн орчныг бүрдүүлэх чиглэлээр гадаад орнуудын баялгийн сангийн эрх зүйн зохицуулалт, тэр дундаа Сингапур улсын төрийн өмчит “Темасек Холдинг” лимитед компанийн загвар жишигт үндэслэн, ОУВС-аас гаргасан судалгааны ажлуудад тодорхойлсон баялгийн сангийн үйл ажиллагааны зарчим, чиглэл, онцлог зэргийг харгалзаж хуулийн төслийн суурь судалгааг хийж гүйцэтгэсэн.

2015 оны 4 дүгээр сарын 9-ний өдөр Монгол Улсын Ерөнхийлөгчөөс өргөн мэдүүлсэн Ирээдүйн өв сангийн болон холбогдох бусад хуулийн төслүүдийг Төсвийн байнгын хороо, УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн зөвлөгөө үзүүлэх, судалгаа, тооцоо хийх дэд ажлын хэсгийн бүрэлдэхүүнд Монголбанкнаас оролцон ажиллав. Төсвийн байнгын хороогоор өргөн мэдүүлсэн хуулийн төслийг хэлэлцэж, хэлэлцүүлгийн явцад гарсан зарчмын зөрүүтэй саналд үндэслэн хуулийн төслийг буцаан татаж, 2015 оны 6 дугаар сарын 12-ны өдөр Монгол Улсын Ерөнхийлөгчөөс дахин өргөн мэдүүлсэн. Ирээдүйн өв сангийн тухай хуулийн төсөл болон холбогдох бусад хуулийн төслүүдийг УИХ-аас хэлэлцэхээр шийдвэрлэсэн тохиолдолд баялгийн сангийн үйл ажиллагааны зарчим, удирдлага болон тус сангаас корпорацийн данс, төлбөр тооцоог гүйцэтгэхтэй холбоотойгоор Монголбанкнаас шаардлагатай саналыг өгч ажиллана.

3.2. 2015-2017 онд санхүүгийн салбарт зээлийн тасалдал үүсэх, системийн шинжтэй тогтворгүй байдал бий болохоос сэргийлэх зорилгоор “Эдийн засгийн идэвхжилийг нэмэгдүүлэх зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их хурлын 2014 оны 34 дүгээр тогтоолд заасан арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлэх [Засгийн газар, Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо].

34-р тогтоолын хавсралтын 1.10 дахь заалт: Монгол Улсын Засгийн газар, Монголбанкны хооронд 2012 оны 10 дугаар сарын 22-ны өдөр байгуулсан “Гол нэрийн бараа бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах дунд хугацааны хөтөлбөрийг хамтран хэрэгжүүлэх харилцан ойлголцлын санамж бичиг”-ийн хүрээнд хэрэгжүүлж байгаа хөтөлбөрт иж бүрэн дүн шинжилгээ хийж 2014 оны 6 дугаар сарын 01-ний дотор Улсын Их Хуралд танилцуулан, цаашид уг хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх эсэхийг шийдвэрлүүлэх (Засгийн газар, Монголбанк)

Хэрэгжсэн: Монголбанк анх 2012 оны 11 дүгээр сараас уг хөтөлбөрийг Засгийн газартай хамтран хэрэгжүүлэхдээ: (i) хөтөлбөр нь нийлүүлэлтийн гаралтай инфляцийн дарамтыг бууруулж, хэрэглээний үнийн индексээр хэмжигдэх инфляцийг нам, тогтвортой түвшинд байлгах, улмаар жилийн инфляцийг дунд хугацааны зорилтот түвшинд хүргэж бууруулах суурь нөхцөлийг хангах, (ii) хөтөлбөрийг дунд хугацаа/3 жил/-нд хэрэгжүүлж, Монголбанк 3 жилийн дотор хөтөлбөрөөс үе шаттай гарах, ингэхдээ санхүүгийн салбарт сөрөг нөлөөлөл үүсгэхгүй байх, (iii) хөтөлбөрийн үр дүнд гол нэрийн бараа, бүтээгдэхүүний нийлүүлэлтийн зах зээлийн зарчимд суурилсан байнгын бөгөөд тогтвортой тогтолцоог бүрдүүлэх, (iv) хөтөлбөрийг Засгийн газар өөрт шилжүүлэн авах, зайлшгүй шаардлагатай гэж үзсэн дэд хөтөлбөрүүдийг цаашид Засгийн газар, Хөгжлийн банкнаас хувийн хэвшилтэй хамтран хэрэгжүүлэх гэсэн үндсэн зорилт, чиглэлийг баримталсан билээ.

Монголбанк “Гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах дунд хугацааны хөтөлбөр”-т иж бүрэн дүн шинжилгээ хийж, холбогдох тайланг саналын хамт УИХ-ын Эдийн засгийн байнгын хороонд 2014 оны 5 дугаар сард хүргүүлсэн. УИХ-ын 2014 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн 69-р тогтоол, 2015 оны 2 дугаар сарын 18-ны өдрийн 41 дүгээр тогтоолоор Монголбанкийг уг хөтөлбөрөөс үе шаттай гарах оновчтой арга замыг сонгож хэрэгжүүлэх, хөтөлбөрийн зээлийн үлдэгдлийг Засгийн газарт шилжүүлэхийг тус тус даалгасан. Энэ дагуу 2014-2015 онд Монголбанк уг хөтөлбөрөөс үе шаттай гарах, ингэхдээ санхүүгийн салбарт сөрөг нөлөөлөл үүсгэхгүй байлгах оновчтой арга замыг сонгож хэрэгжүүлэн, хөтөлбөрийн зээлээс Монголбанкны тэнцэлд үлдэх хэсгийг Засгийн газарт шилжүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж байна.

34-р тогтоолын хавсралтын 2.6 дахь заалт: Үндэсний үйлдвэр, дотоодын аж ахуйн нэгжийн тогтвортой үйл ажиллагааг хангах зорилгоор бизнесийн үйл ажиллагааны өртөг, зардлыг нэмэгдүүлж байгаа хүчин зүйлсийн нөлөөллийг саармагжуулах, зээл, зээлийн даатгалд хамруулах болон гадаад, дотоодын үнэт цаасны зах зээлд оролцоход нь дэмжлэг үзүүлэх (Засгийн газар, Монголбанк)

Хэрэгжсэн: Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2014 оны МН-47/21 дүгээр тэмдэглэл, Төв банкны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, 28 дугаар зүйл, 23 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт, УИХ-ын 2014 оны 34-р тогтоол, 2014 оны 69-р тогтоолоор тус тус үүрэг болгосны дагуу Монголбанк дотоод актив чанаргүйдэх эрсдэлийг бууруулах, банкны тогтолцооны тогтвортой байдлыг хангах, банкны салбарт эрсдэл хуримтлагдахаас сэргийлэхэд чиглэсэн арга хэмжээг дотоодын аж ахуйн нэгжийн тогтвортой үйл ажиллагааг дэмжих, гадаад валютын орох урсгалыг нэмэгдүүлэх замаар макро эдийн засгийн гадаад тэнцвэрийг дэмжихтэй харилцан уялдаатайгаар хэрэгжүүлээ. Энэхүү арга хэмжээний үр дүнд Монгол Улсын дотоод активын чанар эрс муудах, банкны салбарт чанаргүй зээлийн хэмжээ огцом өсөх, системийн шинжтэй тогтворгүй байдал бий болох, бодит секторт ажилгүйдэл огцом нэмэгдэх зэрэг эрсдэлээс урьдчилан сэргийлж, санхүүгийн тогтвортой байдлыг үргэлжлүүлэн хадгаллаа.

Банкуудын гадаад зах зээлээс валютын эх үүсвэр оруулж ирэх үйл ажиллагааг дэмжих хүрээнд Монголбанк банкуудтай гадаад валют-төгрөгийн урт хугацаат своп хэлцлийг холбогдох журмын дагуу байгуулан ажиллаж байна. Монголбанк 2015 оны 1 дүгээр улиралд 47.5 сая ам.доллар, 2 дугаар улиралд 500.0 сая ам.долларын урт хугацаат своп хэлцлийг банкуудтай байгуулсан. Ингэснээр гадаад валют-төгрөгийн урт хугацаат своп хэлцлийн нийт үлдэгдэл 2015 оны 9 сарын 16-ны өдрийн байдлаар 1064.8 сая ам.доллар болов. Энэхүү арга хэмжээ нь: (i) гадаад валютын орох урсгал, гадаад активын хэмжээг нэмэгдүүлэх, (ii) төлбөрийн тэнцлийн тогтвортой байдал, макро эдийн засгийн гадаад тэнцвэрийг дэмжих, (iii) санхүүгийн салбарын төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг сайжруулах, (iv) гадаад валютын ханшийн эрсдэлийг бууруулах, (v) валютын захын тогтвортой байдлыг хангахад тус тус эергээр нөлөөлж байна.

34-р тогтоолын хавсралтын 2.8 дахь заалт: Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хуулийн төслийг боловсруулж, өргөн мэдүүлэх (Засгийн газар, Монголбанк)

Хэрэгжсэн: Хуулийн төсөл боловсруулах Ажлын хэсэгт Монголбанкны төлөөлөл орж ажилласан. Энэхүү хуулийн төслөөр хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийг гэрээний болон гэрээний бус үүргийн гүйцэтгэлийг хангах эх сурвалж болгон барьцаалах, уг барьцааны эрхийг бүртгэх, барьцааны шаардлагыг хангахтай холбогдсон харилцааг зохицуулахаар боловсруулсан болно. Хууль зүйн яамнаас хуулийн төслийг 2015 оны 5 дугаар сарын 26-ны өдөр УИХ-д хэлэлцүүлэн батлуулахаар өргөн мэдүүлсэн билээ. Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хууль 2015 оны 7 дугаар сарын 2-ны өдөр батлагдсан бөгөөд 2016 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр дагаж мөрдөгдөнө.

3.3 Монголбанк, Засгийн газар хооронд макро эдийн засгийн нэгдсэн мэдээллийн тогтолцоог бий болгох, макро зохистой бодлого хэрэгжүүлэх хүрээнд төсөв, мөнгөний бодлогын уялдаа холбоог сайжруулах [Засгийн газар, Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо].

Монголбанк “Макро бодлогын өөрчлөлтийн нэгдсэн төлөвлөгөө” (Comprehensive Macro Adjustment Plan - CMAP)-ний төслийг боловсруулж, Сангийн яаманд хүргүүлэн, Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл (СТБЗ)-ийн 2015 оны 1 дүгээр сарын 13-ны өдрийн ээлжит хуралдаанаар эдийн засгийн 2015 оны төлөв хандлага, авч хэрэгжүүлэх арга хэмжээний саналын хамтаар хэлэлцүүлсэн. Үүний үндсэн дээр СТБЗ-өөс дараах дүгнэлтийг хийсэн болно. Үүнд:

1. Уул уурхайн салбараас хэт хамаарсан манай эдийн засагт сүүлийн 3 жилийн дотор гадаад валютын орох урсгал ДНБ-ий 72 хувьтай тэнцэх хэмжээгээр дутагдсанаас эдийн засгийн өнөөгийн хүндрэл бий болсон. Тухайлбал, 2011 онтой харьцуулбал 2012-2014 онуудад гадаадын шууд хөрөнгө оруулалт -6.8 тэрбум, экспортын орлого -2.2 тэрбум ам.доллараар тус тус буурсан байна.
2. Гадаад валютын орох урсгалыг нэмэгдүүлэх арга хэмжээ нь 2015 онд эдийн засгийг агшуулахгүй байлгах, хувийн хэвшилд ирэх ачаалал, дарамтыг бууруулах, Монгол Улсын иргэн, аж ахуйн нэгжийн дотоод актив, хуримтлал, хадгаламжийг үнэгүйдлээс сэргийлэх, ажлын байрыг хамгаалах, эдийн засгийг дунд, урт хугацаанд тогтвортой тэлэх нөхцөлийг бүрдүүлэх үндсэн шийдэл хэвээр байсаар байна.
3. Эдийн засгийн нөхцөл байдалд нийцүүлэн харилцан уялдаа бүхий макро бодлогын цогц өөрчлөлт хийх нь төлбөрийн тэнцлийг ашигтай болгох, Монгол Улсын гадаад активыг нэмэгдүүлэх, эдийн засгийг 2015 онд дахин тогтворжуулахад дэмжлэг үзүүлэхээр байна.

Дээрх дүгнэлтэд үндэслэн СТБЗ-өөс дараах зөвлөмжийг Засгийн газарт хүргүүлсэн. Үүнд:

Гадаад валютын орох урсгалыг нэмэгдүүлэх, улсын төсвийн зохистой бодлого хэрэгжүүлэх, эдийн засгийн бүтцийн шинэчлэлийг эрчимжүүлэх арга хэмжээ авах агуулга бүхий Макро бодлогын өөрчлөлтийн нэгдсэн төлөвлөгөө (CMAP)-г боловсруулан хэрэгжүүлэх.

Дээрх арга хэмжээг нэгдсэн байдлаар хэрэгжүүлсний үр дүнд санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хадгалж, нийгэм-эдийн засагт тогтворгүй байдал үүсэхээс сэргийлэн, эдийн засаг тогтвортой өсөх нөхцөлийг хангах боломж бүрдэнэ гэж СТБЗ-өөс үзсэн болно. Энэхүү дүгнэлт, зөвлөмж болон Монголбанкнаас боловсруулсан “Макро бодлогын өөрчлөлтийн нэгдсэн төлөвлөгөө” (CMAP)-ний төсөлд үндэслэн Засгийн газраас “Эдийн засгийн хүндрэлээс гарах арга хэмжээний хөтөлбөр”-ийг боловсруулсан. Энэхүү хөтөлбөрийн төсөл, УИХ-ын тогтоолын төслийг боловсруулах Ажлын хэсэгт Монголбанк орж ажилласан болно. Улмаар УИХ-ын 2015 оны 41 дүгээр тогтоолоор уг хөтөлбөрийг баталсан бөгөөд Засгийн газар, холбогдох байгууллагууд хөтөлбөрийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Ийнхүү “Эдийн засгийн хүндрэлээс гарах арга хэмжээний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэн, макро бодлогын өөрчлөлтийг цогц байдлаар хийж, улсын төсөв, мөнгөний бодлогыг эдийн засгийн гадаад тэнцвэрийг дэмжихэд чиглүүлж байгаагаас төсөв, мөнгөний бодлогын уялдаа илүү сайжирлаа. Бодлогын үр дүн нь оны эхнээс нийт эрэлт буурах, оны эхний 8 сард импорт хүлээгдэж байснаас илүү хурдацтайгаар, жилийн өмнөх үетэй харьцуулахад 1053 сая ам.доллар буюу 29.2%-аар агших, гадаад худалдааны тэнцэл 705 сая ам.долларын ашигтай болж өмнөх оны мөн үеэс 728 сая ам.доллараар сайжрах, хэрэглээний үнийн индексээр тооцсон улсын жилийн инфляци үргэлжлэн буурч, оны эхнээс 4.4 нэгж хувиар бууран 6.6%-д хүрэх, оны эхний 7 сарын урьдчилсан гүйцэтгэлээр төлбөрийн тэнцлийн урсгал дансны алдагдал 410 сая ам.доллар болж, 2014 оны мөн үеийн гүйцэтгэлээс 912 сая ам.доллараар буюу 3.2 дахин буурч, валютын зах тогтворжих, төгрөгийн гадаад валюттай харьцах ханш болон гадаад валютын улсын нөөцөд ирэх дарамт, ачаалал буурах зэргээр илэрч байна.

Макро бодлогын уялдааг хангах, эдийн засаг, санхүүгийн салбарт учирч буй асуудлыг хэлэлцэж шийдвэрлэх чиглэлээр тайлант хугацаанд СТБЗ энэ оны 1 дүгээр сарын 13, 3 дугаар сарын 13-ны өдрүүдэд тус тус хуралдсан. Эдгээр хуралдаанаар СМАР-аас гадна дор дурдсан асуудлыг хэлэлцэж, хуралдаанаас гарсан шийдвэрийн дагуу СТБЗ-өөс холбогдох газруудад хариуцсан чиглэлээр тодорхой үүрэг даалгавар өгсөн болно:

- Үнэ тогтворжуулах хөтөлбөрийг Засгийн газарт шилжүүлэх төлөвлөгөөний тухай;
- Дэлхийн банкны хөгжлийн бодлогын зээл (DPL package)-ийг авах нөхцөл, авах арга хэмжээний тухай;
- Монгол Улсын 2015 оны эдийн засгийн төлөв байдлын тухай;
- Инфляцийн төлөв байдлын тайлан (2015 оны 1-р улирал);
- Гадаад валютын дотоод захын тойм;
- Хөгжлийн банкны зарцуулалт, засаглалыг боловсронгуй болгох тухай;
- Монгол Улсын 2015 оны төсвийн тодотголын төслийн тухай;
- Хэвийн зээлийн эрсдэлийн сантай холбогдох татварын эрх зүйн зохицуулалтын тухай;
- Засгийн газрын үнэт цаасны арилжааны тухай;
- Ханшийн өөрчлөлтөөс шалтгаалж улсын төсөвт үүсч буй алдагдлыг багасгах, хэджинг хийх тухай;
- Төрийн сангийн нэгдсэн дансны тухай;
- Иргэдийн эзэмшиж буй 1072 хувьцааны бүртгэлийн тухай;
- Үнэт цаасны арилжааны төлбөр, тооцооны үйл ажиллагааны тухай;
- ТУЗ-ийн хараат бус гишүүнийг нэр дэвшүүлэх, томилох, чөлөөлөх журамд өөрчлөлт оруулах тухай;
- Монголбанкны Санхүүгийн мэдээллийн албаны 2014 оны үйл ажиллагааны тайлан;
- Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн 2015 оны ээлжит хуралдааны товыг тогтоох тухай.

2006 онд Монголбанк, Сангийн яам, Санхүүгийн зохицуулах хорооны хамтарсан “Мэдээлэл харилцан солилцох тухай” харилцан ойлголцлын санамж бичгийг шинэчлэх хүрээнд холбогдох судалгааг хийж, санал боловсруулан ажиллаж байна. Тухайлбал, Монголбанк төсвийн сар бүрийн гүйцэтгэлийг тухай бүрт нь бичгээр болон цахим шуудангаар хүлээн авч байгаа бол Засгийн газрын цэвэр зээлийн тайланг улирал бүр Монголбанкнаас Сангийн яаманд хүргүүлж байна.

Монголбанк, Засгийн газар хамтран харилцан уялдаатай макро зохистой бодлого хэрэгжүүлэх хүрээнд Мөнгөний бодлогын зөвлөлийн гишүүнээр Сангийн дэд сайд ажиллаж байгаа бол Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн хурлыг тогтсон хуваарийн дагуу зохион байгуулж, гишүүдээр Сангийн сайд, Монголбанкны ерөнхийлөгч, Санхүүгийн зохицуулах хорооны дарга ажиллаж, хуралдаанд гурван байгууллагын бусад удирдах албан тушаалтнууд, бодлогын чиг үүрэг бүхий газрууд тогтмол оролцоотой ажиллаж байна.

Монголбанк 1 болон 4 долоо хоногийн хугацаатай Төв банкны үнэт цаас арилжаалж байгаа бөгөөд Засгийн газрын 12, 28, 52 долоо хоног болон 1-ээс дээш жилийн хугацаатай ЗГҮЦ-ыг Монголбанкны платформоор дамжуулж арилжаалж байна. Мөн уг платформыг ашиглан Засгийн газраас 3, 5, 10 жилийн хугацаатай ЗГҮЦ-ыг арилжаалж эхлээд байна. Энэ нь санхүүгийн зах зээлийг хөгжүүлэх, Засгийн газрын мөнгөн хөрөнгийн удирдлагыг сайжруулах, томоохон төсөл, хөтөлбөрүүдийг санхүүжүүлэх, Засгийн газрын үнэт цаасны хөрөнгө оруулагчдыг нэмэгдүүлэх зэрэгт чухал үүрэгтэй юм. 2015 оны 9 дүгээр сарын 10-ны өдрийн байдлаар Сангийн яамтай хамтран нийт 929 тэрбум төгрөгийн Засгийн газрын богино хугацаат үнэт цаас болон 130 тэрбум төгрөгийн Засгийн газрын урт хугацаат бондыг арилжаалсан байна. Мөн Монголбанк дахь СТБЗ-ийн Ажлын албанаас Сангийн яам, Санхүүгийн зохицуулах хороотой хамтран хагас жил тутамд “*Санхүүгийн тогтвортой байдлын тайлан*” гаргаж буй бөгөөд одоогоор нийт 4 дугаар гаргаад байна. Санхүүгийн тогтвортой байдлын тайлангийн 5 дахь дугаарыг 2015 оны 3 дугаар улиралд СТБЗ-өөр хэлэлцүүлсний үндсэн дээр олон нийтийн хүртээл болгоно.

Макро эдийн засгийн статистик, мэдээллийн нэгдмэл байдлыг хангах зорилгоор Монголбанк, Сангийн яам, Санхүүгийн зохицуулах хорооны дунд статистик мэдээллийн нэгдсэн санг бий болгохоор Монголбанк дахь СТБЗ-ийн Ажлын албанаас холбогдох журмын төслийг боловсруулсан. Уг журмын төслийг 2015 оны 3 дугаар улиралд СТБЗ-өөр хэлэлцүүлж батлуулах, улмаар статистик мэдээллийн нэгдсэн санг үүсгэх чиглэлээр ажиллаж байна.

4. Төгрөгийн тогтвортой байдлыг хангах зорилгоор макро эдийн засгийн гадаад тэнцвэрийг дэмжих, банкны салбарт эрсдэл хуримтлагдахаас сэргийлэхэд чиглэсэн арга хэмжээ авах.

Макро бодлогын өөрчлөлтийн нэгдсэн төлөвлөгөө (СМАР)-ний хүрээнд улсын төсөв, мөнгөний бодлого нь 2015 онд эдийн засгийн гадаад тэнцвэрийг дэмжихэд чиглэж байна. Ингэснээр төлбөрийн тэнцэл сайжирч 2015 оны эцэст алдагдалгүй гарах, валютын зах тогтворжих, төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийн инфляци дахь сөрөг нөлөөлөл үргэлжлэн буурах, улмаар төгрөгийн тогтвортой байдал буюу төгрөгөөр илэрхийлэгдсэн бараа, үйлчилгээний үнийн тогтвортой байдал хангагдах нөхцөл бүрдэнэ.

Эдийн засгийг зөөлөн газардуулах, тогтворжуулах, гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлтийг нам, тогтвортой түвшинд байлгах зорилгоор 2012 оны 4 дүгээр улирлаас эхлэн хэрэгжүүлсэн бодлогын арга хэмжээний үр дүнд хөтөлбөрт хамрагдах барааны үнийн өсөлтийн инфляцид үзүүлэх шууд нөлөөлөл эрс буурч, 2010-2012 оны дунджаар нийлүүлэлтийн гаралтай инфляци нийт инфляцийн 1/3-ийг эзэлдэг байсан бол 2013 онд

1/6, 2014 онд 1/20 болж буурсан. 2015 оны эхний 8 сард хөтөлбөрт хамрагдах барааны инфляци жилийн инфляцийг дунджаар -0.7 нэгж хувиар бууруулах нөлөө үзүүллээ.

2014 оны эхний хагаст гадаадын шууд хөрөнгө оруулалт, гадаад цэвэр актив буурсан хандлага үргэлжилж, төсөвтэй адилтгах хөрөнгө оруулалтын зарцуулалтууд буурахгүй, гадаад валютын орох урсгал, төлбөрийн тэнцлийг сайжруулах арга хэмжээний үр дүн хангалттай бус байсан тул Монголбанк 2014 оны 7 дугаар сараас эхлэн мөнгөний бодлогын төлөвийг алгуур чангаруулах чиглэлд өөрчилж, мөнгөний бодлогын хүүг 1.5 нэгж хувиар нэмэгдүүлэн 12% болгосон. Мөнгөний бодлогын зөвлөл 2015 оны 1 дүгээр сард мөнгөний бодлогын хүүг 1.0 нэгж хувиар нэмэгдүүлэн 13% болгосон бөгөөд 2015 оны 4 болон 7 дугаар сарын зөвлөлийн ээлжит хурлаар мөнгөний бодлогын хүүг өөрчлөлгүй хэвээр хадгалах шийдвэрийг тус тус гаргасан.

Мөнгөний бодлогын төлөвийг ийнхүү 2014 оны сүүлийн хагасаас эхлэн үе шаттай, алгуур чангаруулсан нь гадаад худалдааны нөхцөл сайжирч, гадаад валютын орох урсгал нэмэгдэх хүртэл макро эдийн засгийн гадаад тэнцвэрийг дэмжих зорилгоор төгрөгийн өгөөжийг нэмэгдүүлсэн бодлогын арга хэмжээ байв. Эдийн засгийг зөөлөн газардуулах зорилгоор 2013-2014 онуудад хэрэгжүүлсэн мөнгөний уламжлалт бус бодлогын үр дүнд нийлүүлэлтийн гаралтай инфляцийн дарамт эрс буурсны зэрэгцээ мөнгөний уламжлалт арга хэрэгслээр эдийн засгийн гадаад тэнцвэрийг дэмжсэн нь нийт эрэлтийг хумих, төлбөрийн тэнцлийн урсгал дансны алдагдал 2015 оны эхний 7 сарын урьдчилсан гүйцэтгэлээр өмнөх оны мөн үеэс 912 сая ам.доллараар буюу 3.2 дахин буурах, жилийн инфляци 2015 оны 8 дугаар сарын байдлаар 6.6% болж 2014 оны эцсийн гүйцэтгэлээс 4.4 нэгж хувиар буурах, санхүүгийн болон макро эдийн засгийн тогтвортой байдлыг хадгалахад тус тус эергээр нөлөөлж байна.

Алт олборлолт, Төв банкинд тушаах алтны хэмжээг нэмэгдүүлэх замаар гадаад валютын улсын нөөцийг өсгөх, макро эдийн засгийн гадаад тэнцвэрийг дэмжих зорилгоор Монголбанк алтны экспортын санхүүжилтийг судалж, ирээдүйд хийх алтны экспортын урьдчилгаа санхүүжилт болох 60 сая ам.долларын эх үүсвэрийг 2014 оны 9 дүгээр сард Samsung C&T corporation болон Bank of Tokyo-Mitsubishi UFJ-тэй гэрээ байгуулсны үндсэн дээр бүрдүүлсэн. Үүнээс 2015 оны эхний хагас жилд нийт 4 удаагийн эргэн төлөлтийг гүйцэтгэсэн бөгөөд үлдсэн 1 удаагийн төлбөрийг энэ оны 8 дугаар сарын 28-ны өдөр гүйцэтгэснээр хэлцэл дуусгавар болсон. Ийнхүү гэрээ дуусгавар болсонтой холбоотойгоор харилцагч талуудын хүсэлтээр гэрээг шинэчлэн байгуулах замаар 100 сая ам.долларын урьдчилсан санхүүжилтийн гэрээг нэг жилийн хугацаатай 2015 оны 7 дугаар сарын 10-ны өдөр байгуулж, гадаад валютын улсын нөөцийг тус дүнгээр нэмэгдүүлсэн. Гэрээний дагуу санхүүжилтийн төлбөрийг 2015 оны 10 дугаар сараас эхлэн 2 сар тутамд дотоодын аж ахуйн нэгж, байгууллагуудаас худалдан авсан алтаар төлж барагдуулна. Түүнчлэн гадны “Apache Asia Limitada, “BB Capital Partners Pte Ltd”, “TDB capital”-ийн хамтарсан нэгдэл болон дотоодын “УБ капитал ББСБ”-тай алтны урьдчилгаа санхүүжилтийн хүрээнд хамтран ажиллах гэрээг байгуулахаар тохиролцож байна.

Түүнчлэн дотоодын алт олборлолтыг нэмэгдүүлэх, алтны санхүүжилтийн оновчтой тогтолцоог бүрдүүлэх зорилгоор Монголбанк алтны санхүүжилтийн схем боловсруулж,

СТБЗ-ийн 2015 оны 3 дугаар сарын 28-ны өдрийн хурлаар танилцуулан, саналыг СЯ, УУЯ, Хөгжлийн банкинд тус тус хүргүүлсэн боловч Хөгжлийн банкны зүгээс алтны салбарт аливаа санхүүжилт, баталгаа гаргах боломжгүй тухай 6 дугаар сарын эхээр мэдэгдсэн. Улмаар 2015 оны 6 дугаар сарын 7-ны өдөр Уул уурхайн яам болон Алт үйлдвэрлэгчдийн холбоо, 6 дугаар сарын 8-ны өдөр банкуудтай зөвшилцсөний үндсэн дээр санхүүжилтийг гадаад зах зээлээс татан төвлөрүүлсэн эх үүсвэрээр Монголбанк шийдвэрлэж, зээлийн нийт дүнгийн тодорхой хувьд Засгийн газар баталгаа гаргах, зээлийг зөвхөн банкаар дамжуулах нь оновчтой гэсэн дүгнэлтэд хүрч, уг схемийн саналыг Сангийн яаманд 2015 оны 6 дугаар сарын 8-ны өдөр танилцуулсан. Алтны дотоод санхүүжилтэд баталгаа гаргах саналыг Засгийн газар дэмжиж, 2015 оны 7 дугаар сарын 27-ны өдрийн 311 тоот Засгийн газрын тогтоолоор санхүүжилтийн нийт дүн, баталгааны хувь хэмжээг тодорхойлсон. Улмаар уг тогтоолын заалтуудад нийцүүлэн Монголбанк нь СЯ, УУЯ, МБ-ны хамтарсан тушаал, арга хэмжээний төслийг холбогдох бусад санхүүжилтийн гэрээ, баталгааны гэрээний төслийн хамтаар боловсруулж Сангийн яаманд 8 дугаар сарын 4-ний өдөр хүргүүлсэн. 2015 оны 8 дугаар сарын 25-ны өдөр СЯ, УУЯ болон Алт үйлдвэрлэгчдийн холбооны төлөөллүүд, 2015 оны 8 дугаар сарын 28-ны өдөр СЯ, арилжааны банкуудын төлөөллүүдтэй тус тус уулзалт зохион байгуулж санхүүжилтийн схемийн талаар зөвшилцөж, гэрээний төслүүдэд санал авсан. Санхүүжилтийн схем, гэрээний төслүүдэд Арилжааны банкуудаас өгсөн саналд Монголбанкны байр суурийг илэрхийлж, Монголбанкнаас СЯ-тай эцэслэн тохиролцох шаардлагатай зарчмын 4 асуудлын талаар СЯ-нд 9 дүгээр сарын 4-ний өдөр мэдэгдээд байна.

Монголбанк төлбөрийн тэнцлийн 2013 оны хямралыг санхүүгийн салбарын тогтворгүй байдалд хүргэхээс урьдчилан сэргийлсэн макро болон микро зохистой бодлогын арга хэмжээг 2013-2014 оны туршид авч хэрэгжүүлсэн билээ. Үүний үр дүнд банкууд системийн хэмжээнд зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг хангаж, банкны салбарын тогтвортой байдал хадгалагдан, эрсдэл даах чадвар нь дээшилсэн.

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2014 оны МН-47/21 дүгээр тэмдэглэл, Төв банкны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, 28 дугаар зүйл, 23 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт, УИХ-ын 2014 оны 34-р тогтоол, 2014 оны 69-р тогтоолоор тус тус үүрэг болгосны дагуу Монголбанк дотоод актив чанаргүйдэх эрсдэлийг бууруулах, банкны салбарын тогтвортой байдлыг хангах, банкны салбарт эрсдэл хуримтлагдахаас сэргийлэхэд чиглэсэн арга хэмжээг дотоодын аж ахуйн нэгжийн тогтвортой үйл ажиллагааг дэмжих, гадаад валютын орох урсгалыг нэмэгдүүлэх замаар макро эдийн засгийн гадаад тэнцвэрийг дэмжихтэй харилцан уялдаатайгаар хэрэгжүүлсэн. Энэхүү арга хэмжээний үр дүнд Монгол Улсын дотоод активын чанар эрс муудах, банкны салбарт чанаргүй зээлийн хэмжээ 2009 оных шиг огцом өсөх, системийн шинжтэй тогтворгүй байдал бий болох, бодит секторт ажилгүйдэл үлэмж нэмэгдэх зэрэг эрсдэлээс урьдчилан сэргийлж, санхүүгийн тогтвортой байдлыг үргэлжлүүлэн хадгаллаа.

2015 оны 1 дүгээр сарын 13-ны өдрийн Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн ээлжит хуралдаанаар “Банкуудын хэвийн зээлд байгуулах эрсдэлийн сангийн зардлыг банкуудын татвар ногдуулах орлогоос хасч тооцуулах” тухай асуудлыг хэлэлцэж, татварын багц хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд өгөх саналаа Сангийн сайдад хүргүүлэн, төсөлд тусгуулахаар тогтсон. Мөн банкны системд эрсдэл хуримтлагдахаас сэргийлэх

ажлын хүрээнд банкуудын төлбөр түргэн гүйцэтгэх чадварт дэмжлэг үзүүлэх, ханшийн эрсдэлээс хамгаалах зорилгоор 2015 оны 1 дүгээр улиралд нийт 900.3 сая ам.доллар, 2 дугаар улиралд 1663.5 сая ам.доллар, оны эхнээс 9 дүгээр сарын 10-ны өдрийг хүртэлх хугацаанд 4245.1 сая ам.долларын богино хугацаат ам.доллар болон төгрөгийн своп хэлцэл, мөн гадаад валютын зээлийн өсөлтийг бууруулах, ханшийн эрсдэлээс хамгаалах тогтолцоог бий болгох зорилгоор оны эхнээс нийт 642.5 сая ам.долларын урт хугацаат своп хэлцлийг тус тус банкуудтай байгуулаад байна.

Монголбанкнаас банкуудын томоохон зээлдэгч аж ахуйн нэгжийн зээлийг банктай хамтран дахин санхүүжүүлж банкны активын чанарыг сайжруулах, банкуудын эрсдэл даах чадварыг нэмэгдүүлэх үүднээс банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг 50 тэрбум төгрөг болгон нэмэгдүүлж шинэчлэн тогтоох, энэхүү шаардлагыг 2017 онд багтаан хангуулахаар шийдвэрлэсэн. Монголбанкны Ерөнхийлөгчийн 2015 оны А-20 дугаар тушаалаар санхүүгийн салбарын чанаргүй активыг барагдуулах үүрэг бүхий Актив удирдлагын тусгай нэгжийн үйл ажиллагааг зохицуулах боломжийг судалж, санал боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулан ажиллуулж байна.

5. Гол нэрийн бараа бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах дунд хугацааны хөтөлбөрийг зах зээлийн зарчимд шилжүүлэх замаар иргэдийн хэрэглээний гол нэрийн бараа, бүтээгдэхүүний нийлүүлэлтийн тогтвортой тогтолцоог бий болгож, хөтөлбөрөөс үе шаттай гарах арга замыг сонгож хэрэгжүүлэх [Засгийн газар, Монголбанк].

УИХ-ын 2012 оны 57 дугаар тогтоол, 2013 оны 62 дугаар тогтоол, Төрөөс мөнгөний бодлогын талаар 2013, 2014 онд баримтлах үндсэн чиглэл, Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тус тус заасны дагуу Монголбанк, Засгийн газар хамтран “Гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах дунд хугацааны хөтөлбөр”-ийг 2012 оны 10 дугаар сараас эхлэн хэрэгжүүлсэн.

Монголбанк уг хөтөлбөрийг Засгийн газартай хамтран хэрэгжүүлэхдээ дараах зорилт, чиглэлийг үзэл баримтлал болгосон билээ:

- Хөтөлбөр нь төлбөрийн тэнцлийн хүндрэлийн үед эдийн засгийг зөөлөн газардуулах, тогтворжуулах бодлогын нэг чухал хэсэг байдлаар хэрэгжинэ;
- Хөтөлбөр нь нийлүүлэлтийн гаралтай инфляцийн дарамтыг бууруулж, инфляцийг нам, тогтвортой түвшинд хүргэж бууруулах, улмаар дунд хугацааны зорилтот түвшин (7%)-д байлгахад эергээр нөлөөлнө;
- Хөтөлбөрийг дунд хугацаа /3 жил/-нд хэрэгжүүлж, Монголбанк 3 жилийн дотор хөтөлбөрөөс үе шаттай гарах, ингэхдээ санхүүгийн салбарт сөрөг нөлөөлөл үүсгэхгүй байна;
- Хөтөлбөрийн үр дүнд гол нэрийн бараа, бүтээгдэхүүний нийлүүлэлтийн зах зээлийн зарчимд суурилсан байнгын бөгөөд тогтвортой тогтолцоог бүрдүүлнэ;
- Хөтөлбөрийг Засгийн газар өөрт шилжүүлэн авах, зайлшгүй шаардлагатай гэж үзсэн дэд хөтөлбөрүүдийг цаашид Засгийн газар, Хөгжлийн банкнаас хувийн хэвшилтэй хамтран хэрэгжүүлнэ.

Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр дараах үр дүнд хүрсэн. Үүнд:

1. Хөтөлбөрт хамрагдсан барааны үнийн өсөлт нь 2010-2012 онуудад нийт инфляцийн дунджаар 33.4%-ийг эзэлдэг байсан бол 2013 онд 18.0%, 2014 онд 4.5% болж буурсан бөгөөд нийлүүлэлтийн гаралтай инфляци сүүлийн 2 жилийн туршид нам, тогтвортой түвшинд байсан. Жилийн инфляци 2012 оны эцэст 14.0% байсан бол 2013 оны эцэст 11.9%, 2014 оны эцэст 11.0%, 2015 оны 8 дугаар сарын байдлаар улсын хэмжээнд 6.6%, Улаанбаатар хотод 5.9% болж буурсан. Ингэснээр бага, дундаж орлоготой иргэдийн бодит орлогод ирэх ачааллыг зөөлрүүлэв.
2. Төлбөрийн тэнцлийн 2013-2014 оны хямралт нөхцөл байдлын үед эдийн засгийг тогтворжуулах, улмаар зөөлөн газардуулах (soft-landing)-ад эергээр нөлөөлөв. Хөтөлбөр нь хөдөө аж ахуйн салбарын бодит өсөлтийг 2013 онд 19%, 2014 онд 14.4%, барилгын салбарын бодит өсөлтийг 2013 онд 8%¹, тээвэр ба агуулахын үйл ажиллагааны салбарын бодит өсөлтийг 2014 онд 23.5%-д тус тус хүргэхэд эергээр нөлөөлсөн болно. Ингэснээр ДНБ-ий бодит өсөлт 2013 онд 11.6%, 2014 онд 7.8% гарсан бөгөөд эдийн засаг огцом уналтад орж агших (crash-landing), нийт мөнгөний нийлүүлэлт огцом буурах, банкны системд зээл тасалдах, дотоод активууд үнэгүйдэх, санхүү-эдийн засгийн хямрал 2013 онд бий болох эрсдэлээс сэргийлэв.
3. Ажилгүйдэл эрс нэмэгдэх эрсдэлийг бууруулах, хөдөө аж ахуй, барилга, агуулахын үйл ажиллагааны салбарт ажлын байрыг хадгалахад эергээр нөлөөлөв. Тухайлбал, 2013-2014 онуудад барилгын салбарт ажиллагсдын тоо 15.3 мянгаар өсч 77 мянгад, тээвэр ба агуулахын үйл ажиллагааны салбарт ажиллагсдын тоо 10.1 мянгаар өсч 70 мянгад тус тус хүрчээ. Хөтөлбөр нь 2013 онд нийт ажиллагсдын тоо 20,024 хүнээр, 2014 онд 2479 хүнээр нэмэгдэх, улмаар ажилгүйдлийн түвшинг 2012 оны эцсийн 7.9%-аас хэтрүүлэхгүй байлгахад тус тус эерэг нөлөө үзүүлсэн.

Монголбанк 2013 оноос эхлэн хөтөлбөрийг дараах арга замаар зах зээлийн зарчимд үе шаттай шилжүүлэн ажиллав. Үүнд:

- Хөтөлбөрийн зээлийн эх үүсвэрийг анх 2012 оны 10 дугаар сард 100% Монголбанкнаас банкинд олгосон зээлээс гаргаж байсан бол 2013 онд 80%-ийг Монголбанкнаас, үлдсэн 20%-ийг банкууд өөрийн эх үүсвэрээс, 2014 онд 60%-ийг Монголбанкнаас, үлдсэн 40%-ийг банкууд өөрийн эх үүсвэрээс гаргасан. Ингэснээр 2015 оноос хөтөлбөрийг Засгийн газрын (улсын төсөв, Хөгжлийн банк) болон банкуудын өөрсдийн эх үүсвэрээр санхүүжүүлэх боломж бүрдсэн.
- Хөтөлбөрийн зээлийн үлдэгдлийг хуваарийн дагуу төлүүлж, хөтөлбөрийн зээлийн өрийн үлдэгдлийг макро эдийн засгийн төлөв байдал, санхүүгийн салбарын нөхцөл байдалтай харилцан уялдаатайгаар, үе шаттай бууруулан, зээлийн гэрээний зарим нөхцөлүүдийг зах зээлийн зарчимд шат дараатай шилжүүлэв.
- Гол нэрийн бараа, бүтээгдэхүүний нийлүүлэлтийн тогтвортой схем, агуулахын үлдэгдлийг санхүүжүүлэх хувийн хэвшилд суурилсан оновчтой механизм, санхүүгийн дэд бүтцийг бий болгож, тэдгээрийг цаашид Засгийн газраас хувийн хэвшилтэй хамтарч үргэлжлүүлэн хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэв.

¹ 2010 суурьтай тооцсон. Харин 2005 оны суурьтай тооцвол барилгын салбар 2013 онд 66%-ийн бодит өсөлт үзүүлсэн.

Гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах дунд хугацааны хөтөлбөр нь зорьсон үр дүндээ хүрсэн, хөтөлбөрийг анх эхлүүлэхдээ дунд хугацаанд зах зээлийн зарчимд суурилсан тогтвортой тогтолцоо бүрдүүлэх, улмаар Монголбанк хөтөлбөрөөс үе шаттай гарахаар төлөвлөсөн билээ. УИХ-ын 2014 оны 69-р тогтоолоор хөтөлбөрөөс үе шаттай гарах оновчтой арга замыг сонгож хэрэгжүүлэхийг, 2015 оны 41-р тогтоолоор хөтөлбөрийн зээлээс Монголбанкны тэнцэлд үлдэх хэсгийг Засгийн газарт 2015 оны эхний хагаст багтаан шилжүүлэхийг тус тус даалгасан.

Энэ дагуу Монголбанкнаас 2015 оны 3 дугаар сарын 3-ны өдөр СЯ, ХХААЯ, УУЯ, БХБЯ, ЭХЯ, ЗТЯ, ГТГ-тай уулзалт хийж, дэд хөтөлбөр тус бүрийн хэрэгжилтийг дүгнэж, Монголбанк хөтөлбөрөөс гарах схем, цаашид энэхүү хөтөлбөрийн хүрээнд Засгийн газраас хэрэгжүүлэх чиг үүргийг харилцан тохиролцсон. Энэхүү уулзалтын мөрөөр Монголбанк “Гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах дунд хугацааны хөтөлбөрийн үнэлгээ, дүгнэлт, зөвлөмж” баримт бичгийг боловсруулж, 3 дугаар сарын 13-ны өдөр Сангийн яаманд хүргүүлсэн болно.

Гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах дунд хугацааны хөтөлбөрийн хүрээнд Монголбанк, Засгийн газар хамтран 5 дэд хөтөлбөрийг хэрэгжүүлсэн бөгөөд хөтөлбөрийн зээлийн нийт үлдэгдэл 2013 оны эцэст 714.1 тэрбум төгрөг байсан бол 2014 оны эцэст зээлийн эргэн төлөлтөөрөө 633.8 тэрбум төгрөг болж буурсан.

Хөтөлбөрийн зээлийн үлдэгдэл 2015 оны эхний хагас жил дуусахад 475.4 тэрбум төгрөг байсан бөгөөд 8 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 386.7 тэрбум төгрөг байна. Хөтөлбөрийн зээлийн үлдэгдэл нь зээлийн гэрээнд заасан хуваарийн дагуу эргэн төлөгдсөөр 2015 оны эцэст 232.3 тэрбум, 2016 оны эцэст 27.3 тэрбум, 2017 оны эцэст 0.3 тэрбум төгрөг болж буурахаар хүлээгдэж байна.

Хүснэгт 2: Гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах дунд хугацааны хөтөлбөрийн зээлийн үлдэгдэл, хугацааны эцэст (тэрбум төгрөгөөр)

		2013	2014	2015.06.30	2015.08.31	2015 оны эцэст	2016 оны эцэст
Хүнсний гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах хөтөлбөр	Махны нөөц бүрдүүлэх, үнийг тогтворжуулах	61.6	17.3	30.2	0.0	0.0	0.0
	Гурилын үнийг тогтворжуулах	12.5	47.0	21.2	2.6	0.0	0.0
	Хүнсний бүтээгдэхүүний зоорь, агуулахыг нэмэгдүүлэх эрчимжсэн аж ахуйг хөгжүүлэх	99.0	132.2	111.1	102.1	82.2	7.6
Шатахууны жижиглэнгийн худалдааны үнийг тогтворжуулах дэд хөтөлбөр		192.0	176.1	92.2	86.2	0.0	0.0
Өргөн хэрэглээний импортын бараа, бүтээгдэхүүний өртгийг бууруулах дэд хөтөлбөр		12.0	15.9	7.7	5.0	1.3	0.0
Барилгын салбарыг дэмжих, улмаар орон сууцны үнийг тогтворжуулах дэд хөтөлбөр	Барилгын гол нэр төрлийн материалын дотоодын үйлдвэрлэлийг дэмжих	169.7	211.7	200.8	184.6	148.5	19.7
	Зайлшгүй импортлох шаардлагатай барилгын материалын улирлын шалтгаантай нийлүүлэлтийн хязгаарлалтыг арилгах	99.4	0.0	0.0	0.0	0.0	0.0
	Дэвшилтэт технологи бүхий, байгаль орчинд ээлтэй барилгын материал үйлдвэрлэх төслүүдийг дэмжих	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Нүүрсний аюулгүйн нөөц бүрдүүлэх, түлш, эрчим хүчний салбарын өвөлжилтийн бэлтгэл хангах, эрчим хүчний үнэ тарифыг тогтворжуулах дэд хөтөлбөр		67.9	33.6	12.2	6.2	0.3	0.0
НИЙТ		714.1	633.8	475.4	386.7	232.3	27.3

Эх сурвалж: Монголбанк

Хөтөлбөрийн зээлийн үлдэгдлийг Засгийн газарт шилжүүлэх хүрээнд дараах 4 гэрээний төслийг боловсруулж, Сангийн яам болон Хөгжлийн банкинд 2015 оны 6 дугаар сарын 22-ны өдөр хүргүүлсэн. Үүнд:

- Монголбанкнаас банкуудад олгосон хөтөлбөрийн зээлийн үлдэгдлийг Хөгжлийн банкнаас гаргах үнэт цаасаар солих үйл ажиллагааг зохицуулсан *“Үнэт цаасаар зээлийн авлага шилжүүлэх арилжааны гэрээ”*;
- Монголбанк болон банкууд хооронд байгуулсан хөтөлбөрийн зээлийн гэрээний Монголбанкны эрх, үүргийг Хөгжлийн банкинд шилжүүлэх үйл ажиллагааг зохицуулсан *“Гэрээний эрх, үүрэг шилжүүлэх гэрээ”*;
- Хөтөлбөрийг Засгийн газарт шилжүүлсний дараа 2015 оны 7 ба 9 дүгээр сард хугацаа нь дуусах *“Махны нөөц бүрдүүлэх, үнийг тогтворжуулах”* болон *“Турилын үнийг тогтворжуулах”* дэд хөтөлбөрүүдийг Засгийн газрын өмнөөс хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохицуулсан *“Засгийн газрын санхүүгийн зуучлалын гэрээ”*;
- *“Махны нөөц бүрдүүлэх, үнийг тогтворжуулах”* болон *“Турилын үнийг тогтворжуулах”* дэд хөтөлбөрүүдийн зээлийн үлдэгдлийг Засгийн газрын үнэт цаасаар солих үйл ажиллагааг зохицуулсан *“Засгийн газрын үнэт цаас худалдах, худалдан авах гэрээ”*.

2015 оны 6 дугаар сарын 26-ны өдөр УИХ-ын 2015 оны 41 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангах үүднээс дэд хөтөлбөрийг шилжүүлж авах ажлыг түргэвчлэхийг Засгийн газарт зөвлөсөн. Гэвч уг тогтоолын хэрэгжилтийг хангах Засгийн газрын тогтоол 2015 оны 7 дугаар сарын 7-ны өдөр гарсан тул хөтөлбөр шилжүүлэх хугацаа хойшилсон. Эдгээр гэрээг байгуулж, хэрэгжүүлснээр хөтөлбөрийн зээлийн үлдэгдэл Монголбанкны тэнцлээс Засгийн газарт бүрэн шилжиж дуусна.

_____ ооо _____


III. ТӨРӨӨС МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ТАЛААР 2015 ОНД БАРИМТЛАХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ХЭРЭГЖИЛТ (2015 оны 8 дугаар сарын байдлаар)

1 МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД:

1.1 Хэрэглээний үнийн индексээр хэмжигдэх инфляцийг 2015 оны эцэст 7 хувьд, 2015-2017 онд энэ түвшинд тогтворжуулах бодлогын оновчтой хувилбарыг сонгон иргэдийн бодит орлогыг хамгаалж, эдийн засаг тогтвортой өсөх нөхцөлийг бүрдүүлнэ.

Жилийн инфляци 2015 оны 8 дугаар сарын байдлаар улсын хэмжээнд 6.6%, Улаанбаатар хотод 5.9% болж, оны эхнээс харгалзан 4.4, 4.8 нэгж хувиар буураад байна. Үнийн өндөр хэлбэлзэлтэй бараа, бүтээгдэхүүнийг хасч тооцсон суурь инфляци 2014 оны эцэст 12.6% байсан бол 2015 оны эхний хагаст 9.6%, 7 дугаар сард 7.3%, 8 дугаар сард 7.2% болж буурчээ. Ийнхүү 2015 оны 8 дугаар сарын байдлаар инфляцийн түвшин улсын болон Улаанбаатар хотын хэмжээнд буурч, зорилтот түвшинд гарлаа.

Зураг 2: Улаанбаатар хотын сарын ба жилийн инфляци




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

2015 оны 8 дугаар сарын Улаанбаатар хотын жилийн инфляци (5.9%)-ийг бүтцээр нь задлан үзвэл мах, махан бүтээгдэхүүн -0.78, махнаас бусад хүнсний бүтээгдэхүүн 1.49, төрийн зохицуулалттай бараа, үйлчилгээ 1.77, бусад бараа, үйлчилгээ 3.46 нэгж хувийг тус тус бүрдүүлж байна. Өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүний үнийн ерөнхий төлөвийг харвал 2015 он гарсаар махны үнэ өмнөх оноос буурч инфляцийг бууруулах эерэг нөлөө үзүүлж байгаа бол бусад бараа бүтээгдэхүүний үнийн өсөлт бүрэлдэхүүн тус бүрээр саарч байгаа хандлага үргэлжилсээр байна.

Улсын хэмжээнд жилийн инфляци 2015 оны 8 дугаар сард 6.6% болж бууран, зорилтот түвшнээс 0.4 нэгж хувиар бага буюу зорилтот түвшинг хангаад байна. Инфляци цаашид бага зэрэг буурах хандлагатай байгаа тул инфляцийн дунд хугацааны зорилтот 7%-ийн түвшинг 2015 оны эцэст хангахаар байна. Инфляцийн зорилтыг ийнхүү хангах боломжтой болсон нь нэг талаас “Гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах дунд хугацааны хөтөлбөр”-ийн үр дүнд нийлүүлэлтийн гаралтай инфляцийн дарамт


2013-2014 онуудад эрс буурч, 2015 оны эхнээс дарамт нь арилсантай холбоотой юм. Тухайлбал, хүнсний бараа, үйлчилгээний инфляци 2012 онд 19.9% байсан бол 2013 онд 14.0%, 2014 онд 6.9%, 2015 оны 8 дугаар сарын байдлаар 2.3% болж буурсан бол 2012 онд 44% байсан махны үнийн өсөлт, 2013 онд 10.5%, 2014 онд -0.5%, 2015 оны 8 дугаар сард -6.2% болж буураад байна. Нөгөө талаар макро бодлогын өөрчлөлтийг эдийн засгийн гадаад тэнцвэрийг дэмжих чиглэлд хийж байгаа нь нийт эрэлтийг бууруулахын зэрэгцээ төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийн инфляци дахь сөрөг нөлөөллийг саармагжуулж, инфляци буурахад эергээр нөлөөлж байна.

Зураг 3: Жилийн инфляци (голлох 4 ангиллаар)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Зураг 4: Улаанбаатар хотын жилийн инфляци (бүтцээр)



Монголбанкны Мөнгөний бодлогын зөвлөл 2015 оны 1 дүгээр сард мөнгөний бодлогын хүүг 1 нэгж хувиар нэмэгдүүлэн 13% болгосон. Улмаар 2015 оны 4 болон 7 дугаар саруудад мөнгөний бодлогын хүүг одоогийн түвшинд хэвээр хадгалах шийдвэрийг тус тус гаргасан. Ийнхүү мөнгөний бодлогын төлвийг 2014 оны 2 дугаар хагасаас эхлэн алгуур чангаруулж, мөнгөний хатуу бодлого баримталж байгаа нь гадаад худалдааны нөхцөл сайжирч, гадаад валютын орох урсгал, тэр дундаа гадаадын шууд хөрөнгө оруулалт нэмэгдэх хүртэл макро эдийн засгийн гадаад тэнцвэрийг дэмжих, инфляцийг нам, тогтвортой түвшинд байлгах, санхүүгийн болон макро эдийн засгийн тогтвортой байдлыг тус тус хангахад чиглэсэн арга хэмжээ байв.


1.2 Төгрөгийн гадаад валюттай харьцах ханш нь санхүүгийн болон макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, эдийн засгийн гадаад тэнцвэрийг дэмжихүйц уян хатан тогтож, улмаар дунд хугацаанд дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, ажлын байрыг хамгаалахтай нийцтэй байх зарчим баримтална.

Монголбанкнаас төгрөгийн гадаад валюттай харьцах ханш нь санхүүгийн болон макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, эдийн засгийн гадаад тэнцвэрийг дэмжихүйц уян хатан тогтож байх зарчмыг үргэлжлүүлэн баримталж, төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийн огцом хэлбэлзлийг бууруулах зорилгоор валютын захад шаардлагатай үед тухай бүр тогтмол оролцоотой ажиллалаа.

Төлбөрийн тэнцлийн урсгал дансны алдагдал 2011-2012 онд ДНБ-ий -27%-тай тэнцэж байсан ч, түүнийг хөрөнгө ба санхүүгийн дансны ашгаар бүрэн нөхөж байсан тул төлбөрийн нийт тэнцэл 2011 онд 28 сая ам.доллар, 2012 онд 1705 сая ам.долларын ашигтай гарч байв. Урсгал дансны алдагдал 2013 онд ДНБ-ий -25.5%, 2014 онд -11.6%-тай тэнцэх хэмжээнд болж буурсан ч, түүнийг хөрөнгө ба санхүүгийн дансны ашгаар нөхөж чадаагүй бөгөөд төлбөрийн нийт тэнцэл 2013 онд -1867 сая ам.доллар, 2014 онд -471 сая ам.долларын алдагдалтай гарсан билээ. Энэ нь 2013-2014 онуудад төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийг сулруулах чиглэлд нөлөөлсөн суурь хүчин зүйл байв.

Гэвч төгрөгийн гадаад валюттай харьцах ханш нь макро эдийн засгийн суурь нөхцөлтэй нийцтэйгээр уян хатан тогтох зарчмыг Монголбанк үргэлжлүүлэн баримталснаар төлбөрийн тэнцлийн 2013 оны хямралын эдийн засаг дахь сөрөг нөлөөллийг уян хатан тогтох ханш болон гадаад валютын улсын нөөцийн аль алинаар дамжуулан зөөлрүүлж, эдийн засагт зарчмын суурь тохиргоо хийгдэх, эдийн засгийг зөөлөн газардуулах нөхцөлийг бүрдүүлсэн.

Зураг 5: Монгол Улсын төлбөрийн тэнцэл (сая ам.доллараар)



Эх сурвалж: Монголбанк

2015 оны эхний 7 сарын урьдчилсан гүйцэтгэлээр төлбөрийн урсгал данс -410 сая ам.долларын алдагдалтай гарч, алдагдлын хэмжээ өмнөх оны мөн үеэс 3.2 дахин буурчээ. Үүнд барааны гадаад худалдааны ашиг (F.O.V нөхцөлөөр) өмнөх оны мөн үеэс 12 дахин өссөн нь шууд нөлөө үзүүлэв. Харин хөрөнгө ба санхүүгийн дансны ашиг 661 сая ам.доллар болж өмнөх оны мөн үеэс 58%-иар өссөн байна. Үүнд гадаадын шууд хөрөнгө оруулалт цэвэр дүнгээр 144 сая ам.доллар болж өмнөх оны мөн үеэс 283 сая ам.доллараар буурсан ч, багцын (санхүүгийн) хөрөнгө оруулалт 623 сая ам.долларт хүрч өмнөх оны мөн үеэс 63%- иар нэмэгдсэн нь нөлөөллөө. Багцын хөрөнгө оруулалт ийнхүү өсөхөд 2015 оны 5 дугаар сард ХХБанк 500 сая ам.долларын бондыг, 2015 оны 6 дугаар сард Засгийн газар 1 тэрбум юанийн Dim-Sum бондыг тус тус олон улсын зах зээлд амжилттай арилжаалсан нь нөлөөлөв.

Ийнхүү 2015 оны эхний 7 сард нэг талаас төлбөрийн урсгал тэнцлийн алдагдал буурсан бол нөгөө талаас хөрөнгө ба санхүүгийн дансны ашиг нэмэгдсэн нь төлбөрийн нийт тэнцэл 82 сая ам.долларын ашигтай гарч, 2014 оны мөн үеэс 1017 сая ам.доллараар сайжрахад нөлөөлөв. Төлбөрийн нийт тэнцэл -321 сая ам.долларын алдагдалтай байсан оны эхний 4 сард гадаад худалдааны эргэлтээр жигнэж тооцсон төгрөгийн нэрлэсэн ханш (NEER) оны эхнээс 5.2%-иар, төгрөгийн бодит ханш (REER) 4.3%-иар, төгрөгийн ам.доллартай харьцах Монголбанкнаас зарласан ханш 71.97 төгрөгөөр буюу 3.8%-иар тус тус суларч байв. Харин төлбөрийн тэнцэл алдагдалгүй гарсан оны эхний 7 сарын байдлаар төгрөгийн нэрлэсэн ханш (NEER) оны эхнээс 0.8%-иар суларсан, оны 4 дүгээр сарын эцэстэй харьцуулахад² 2.0%-иар чангарсан үзүүлэлттэй байна. Төгрөгийн бодит ханш (REER) энэ оны 6 дугаар сарын байдлаар оны эхнээс 0.3%-иар, оны 4 дүгээр сарын эцэстэй харьцуулахад 4.8%-иар чангарчээ. Төгрөгийн ам.доллартай харьцах Монголбанкнаас зарласан ханш энэ оны 8 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар оны 4 дүгээр сарын эцэстэй харьцуулахад 31.08 төгрөгөөр буюу 1.6%-иар суларч, ханш сулрах хурдац төлбөрийн тэнцлийн алдагдалтай байсан үетэй харьцуулахад мэдэгдэхүйц саарсан байна. Өөрөөр хэлбэл төлбөрийн нийт тэнцэл ашигтай гарахын хэрээр валютын


² 2015 оны эхний 4 сард төлбөрийн тэнцэл -321 сая ам.долларын алдагдалтай байсан бөгөөд 5 дугаар сараас эхлэн төлбөрийн тэнцэл ашигтай гарах болсон.

захад эерэг хүлээлт бий болж, төгрөгийн гадаад валюттай харьцах ханш тогтворжихыг харуулж байна.

Төгрөгийн гадаад валюттай харьцах ханш ийнхүү эдийн засгийн суурь нөхцөлтэй нийцтэйгээр уян хатан тогтож байгаа нь үнийн тогтвортой байдлыг хангах Монголбанкны үндсэн зорилттой нийцтэй бөгөөд 2015 онд эдийн засгийн гадаад тэнцвэр буюу төлбөрийн тэнцлийн тогтвортой байдлыг дэмжих нэг суурь нөхцөл болж байна. Улмаар энэ нь дунд болон урт хугацаанд дотоодын үйлдвэрлэлийг дэмжих, экспортыг урамшуулах, ажлын байрыг нэмэгдүүлэх, эдийн засгийн өрсөлдөх чадварыг сайжруулахад эергээр нөлөөлнө.

Монголбанк валютын захад оролцох оролцоогоо хадгалан, 2015 оны 9 дүгээр сарын 10-ны өдрийн байдлаар оны эхнээс нийт 68 удаа гадаад валютын дуудлага худалдаа зохион байгуулж, 603.9 сая ам.доллар, 2281.8 сая юань буюу 364.8 сая ам.доллартай тэнцэх юанийг валютын захад тус тус нийлүүлэв. Мөн банкны системд эрсдэл хуримтлагдахаас сэргийлэх хүрээнд банкуудын төлбөр түргэн гүйцэтгэх чадварт дэмжлэг үзүүлэх, ханшийн эрсдэлээс хамгаалах зорилгоор 2015 оны 9 дүгээр сарын 10-ны өдрийн байдлаар нийт 4245.1 сая ам.долларын богино хугацаат ам.доллар болон төгрөгийн своп хэлцэл хийж, гадаад валютын зээлийн өсөлтийг бууруулах, ханшийн эрсдэлийг бууруулах, гадаад активыг нэмэгдүүлэх зорилгоор нийт 642.5 сая ам.долларын урт хугацаат своп хэлцлийг тус тус банкуудтай байгуулаад байна.

Зураг 6: Гадаад худалдааны эргэлтээр жигнэж тооцсон төгрөгийн нэрлэсэн (NEER) ба бодит (REER) ханшийн индексийн жилийн өөрчлөлт*




Эх сурвалж: Монголбанк

*Индексийн өөрчлөлт эерэг утгатай байх нь ханш чангарсныг, сөрөг утгатай байх нь ханш суларсныг тус тус илэрхийлнэ. Төгрөгийн бодит үйлчилж буй ханшийн жилийн өөрчлөлт 2015 оны 6 сарын байдлаарх мэдээлэл

Монголбанкны оролцооны үр дүнд 2015 оны 9 дугаар сарын 10-ны байдлаар төгрөгийн ам.доллартай харьцах ханш нэг өдөрт хамгийн ихдээ 0.68%-аар чангарч, 0.87%-аар суларч, нэг өдөрт ногдох дундаж хэлбэлзэл нь 0.15%-тай тэнцүү байна. Мөн энэ хугацаанд ханшийн өдрийн хэлбэлзэл нийт өдрийн 90%-д нь $\pm 0.4\%$ дотор, үлдсэн 10%-д нь хамгийн ихдээ 0.87%-иар хэлбэлзжээ. Ханшийн нэг өдөрт ногдох дундаж хэлбэлзэл 0.15% байгаа нь 2014 оны мөн үетэй харьцуулбал 0.05 нэгж хувиар буурсан, 2013 оны мөн үетэй харьцуулбал 0.03 нэгж хувиар өссөн үзүүлэлт юм.

Зураг 7: Төгрөгийн ам.доллартай харьцах Монголбанкнаас зарласан ханшийн өөрчлөлт (хувиар илэрхийлсэн интервалаар)



Эх сурвалж: Монголбанк

Монгол Улсын гадаад валютын нөөц 2015 оны 7 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 1707.2 сая ам.доллар буюу сүүлийн гурван сарын дунджаар тооцсон импортын 5.3 сарын хэрэгцээг хангах түвшинд байсан нь олон улсын жишиг доод түвшнээс 2.3 сараар илүү үзүүлэлт юм.

Зураг 8: Гадаад валютын улсын нөөц (сая ам.доллар) ба импортын хэрэгцээг хангах түвшин (сараар)




Эх сурвалж: Монголбанк


Хэдийгээр гадаадын шууд хөрөнгө оруулалтын хэмжээ ДНБ-ий 1%-иас бага болж буурсан боловч, 2015 оны эхнээс гадаад худалдаа, төлбөрийн тэнцэлд макро эдийн засгийн гадаад тэнцвэрийг дэмжих чиглэлд эерэг өөрчлөлт гарсаар байна. Тухайлбал, барааны гадаад худалдааны тэнцэл (С.I.F. нөхцөлөөр) оны эхний 8 сард 705 сая ам.долларын ашигтай гарч, өмнөх оны мөн үеэс 728 сая ам.доллараар, 2011-2014 оны мөн үеийн дунджаас 1882 сая ам.доллараар тус тус сайжирчээ. Энэ нь төлбөрийн урсгал дансны алдагдал үлэмж буурахад шууд нөлөөлөв. Оны эхний 7 сард төлбөрийн урсгал тэнцэл -410 сая ам.долларын алдагдалтай болж, алдагдлын хэмжээ нь өмнөх оны мөн үеэс 912 сая ам.доллараар, 2011-2014 оны мөн үеийн дунджаас 1242 сая ам.доллараар тус тус буурчээ.

Ингэснээр төгрөгийн гадаад валюттай харьцах ханш огцом сулрах дарамт буурч, гадаад валютын нөөцөд ирэх ачаалал багасч байна.

Зураг 9: Гадаад худалдааны тэнцэл, жил бүрийн эхний 8 сард (сая ам.доллар)



Зураг 10: Төлбөрийн урсгал тэнцэл, жил бүрийн эхний 7 сард (сая ам.доллар)



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар, Монголбанк

Цаашид төлбөрийн тэнцлийн урсгал дансны алдагдал үргэлжлэн буурах, хөрөнгө ба санхүүгийн дансны ашиг нэмэгдэх хандлага 2015 оны сүүлийн хагаст үргэлжилбэл оны эцэст төлбөрийн нийт тэнцэл алдагдалгүй хэвээр байх, ингэснээр макро эдийн засгийн гадаад тэнцвэр хангагдах, улмаар төлбөрийн тэнцэл, улсын төсвийн хосолмол алдагдал (twin deficit)-аас ангижрах боломж бүрдэнэ. Ингэснээр валютын зах бүрэн тогтворжих, санхүүгийн болон макро эдийн засгийн тогтвортой байдал хадгалагдах, улмаар дунд хугацаанд эдийн засгийн тогтвортой өсөлтийн суурь нөхцөл хангагдана гэж үзэж байна.

2. БАНКНЫ САЛБАРЫН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫГ БЭХЖҮҮЛЭХ ХҮРЭЭНД:


2.1 Банкуудын төлбөрийн чадварыг хадгалах хүрээнд өөрийн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх замаар системийн болзошгүй эрсдэлээс хамгаалах чадварыг нэмэгдүүлж, санхүүгийн салбарын дархлааг сайжруулна.

Монголбанк 2015 оны 8 дугаар сарын 31-ний байдлаар нийт 9 банкинд иж бүрэн, 6 банкинд хэсэгчилсэн шалгалтыг Төв банк (Монголбанк)-ны тухай хууль, Банкны тухай хууль болон бусад хууль тогтоомж, Монголбанкнаас баталсан журам, заавруудын хүрээнд хийж, илэрсэн зөрчилд улсын байцаагчийн акт тогтоох, шийтгэвэр ногдуулах зэрэг арга хэмжээг авч ажиллав. Шалгалтын мөрөөр гарсан Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалын биелэлтэд тогтмол хяналт тавьж байна.

Банкны тухай хууль, Монголбанкны Ерөнхийлөгчийн 2010 оны 7 дугаар сарын 30-ны өдрийн 460 дугаар тушаалаар батлагдсан “Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих журам”, Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн сайдын 2010 оны 8 дугаар сарын 11-ний өдрийн 475/182 дугаар тушаалаар батлагдсан “Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам” болон холбогдох бусад хууль, тогтоомжуудын хүрээнд банкуудын үйл ажиллагаанд зайнаас тогтмол хяналт тавин ажиллаж байна.

2015 оны 8 дугаар сарын эцсийн байдлаар банкны салбарын I-р зэрэглэлийн өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн активын харьцаа 12.2%, өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн активын харьцаа 16.7 % байгаа нь Монголбанкнаас тогтоосон шалгуур үзүүлэлтүүдээс харгалзан 3.2 ба 4.7 нэгж хувиар тус тус өндөр байна. Банкны системийн төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцаа 39.3 % байгаа нь Монголбанкнаас тогтоосон доод хязгаараас 14.3 нэгж хувиар өндөр байна.

Зураг 11: Банкны системийн өөрийн хөрөнгийн хүрэлцээ (CAR)




Зураг 12: Банкны системийн төлбөр түргэн гүйцэтгэх чадвар (LR)



Эх сурвалж: Монголбанк

Банк нь гадаад валютын нээлттэй позиц, өөрийн хөрөнгийн харьцааг нэг валютын хувьд +/-15%-ийн дотор, нийт нээлттэй позицийн тухайд +/-40%-ийн дотор барьж байх шаардлагатай. Тайлант хугацаанд банкны салбарын гадаад валютын зохистой харьцааны үзүүлэлт хамгийн өндөр нэгж валютын хувьд 0.4%, нийт валютын хувьд 2.9% байгаа нь Монголбанкнаас тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг бүрэн хангаж байна.

Зураг 13: Банкны салбарын чанаргүй зээл ба нийт зээлийн харьцаа (NPL Ratio)



Эх сурвалж: Монголбанк

2015 оны 8 дугаар сарын 31-ний байдлаар банкны салбарын чанаргүй зээлийн хэмжээ 865 тэрбум төгрөг байгаа нь нийт зээлийн 7.3%-ийг эзэлж байна. Үүнээс татан буугдсан Анод, Зоос, Хадгаламж банкуудыг хасч тооцвол чанаргүй зээлийн хэмжээ 627 тэрбум төгрөг байгаа бөгөөд энэ нь татан буугдсан банкуудыг хассан зээлийн өрийн үлдэгдлийн 5.4%-тай тэнцүү түвшинд байна. Чанаргүй зээлийн хэмжээ өсөхөд эдийн засгийн хүндрэлтэй байдал шууд нөлөөлж байна. Гэвч төлбөрийн тэнцлийн хямралын үед санхүүгийн салбарт тогтворгүй байдал бий болох, системийн шинжтэй эрсдэл үүсэхээс 2013-2015 оны туршид урьдчилан сэргийллээ.

Монголбанкнаас санхүүгийн салбарыг болзошгүй эрсдэлээс сэргийлэхэд чиглэсэн мөчлөг

сөрсөн бодлого хэрэгжүүлж, дотоод актив чанаргүйдэх эрсдэлийг бууруулах арга хэмжээ авч ажиллаж байна.

Банкуудын төлбөрийн чадварыг хадгалж, системийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор Монголбанкны Ерөнхийлөгчийн 2015 оны 4 дүгээр сарын 1-ний өдрийн А-58 дугаар тушаалаар банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээ 16 тэрбум төгрөг байсныг 50 тэрбум төгрөг байхаар шинэчлэн тогтоож, энэхүү шаардлагыг бүх банкуудаар 2017 онд багтаан хангуулахаар шийдвэрлэсэн. Банкны хувь нийлүүлсэн хөрөнгийг ийнхүү нэмэгдүүлснээр банкны салбарын эрсдэл даах чадвар сайжрахын зэрэгцээ томоохон төслүүдийг бие даан санхүүжүүлэх банкуудын чадавхыг нэмэгдүүлэх, эдийн засгийн бодит өсөлтийг санхүүжүүлэх хүртээмжийг сайжруулах, хувь нийлүүлэгчдийн санхүүгийн хариуцлагыг дээшлүүлэх, цаашлаад жижиг банкуудын үйл ажиллагааг идэвхжүүлэн банкны салбарт өрсөлдөөнийг нэмэгдүүлэх зэрэг олон давуу талыг бий болгоно гэж үзэж байна.

Монголбанк 2015 оны 1-2 дугаар сард “Системийн хяналт болон болзошгүй хямралаас урьдчилан сэргийлэх чадварыг сайжруулах” чиглэлээр ОУВС-гаас техник туслалцаа авсан. ОУВС-гийн техник туслалцааны зөвлөмж, Дэлхийн банкны Ажлын хэсгийн Хөгжлийн бодлогын зээл (DPL)-ийн матрицын төсөлд тусгагдсан зөвлөмжүүдэд үндэслэн Монголбанк “Санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх, Базель-III стандартыг хангахад чиглэсэн эхний шатны арга хэмжээ”-ний төслийг боловсруулаад байна.

2.2 Олон улсад мөрдөгдөж байгаа хяналт шалгалтын зарчим, зохицуулалтын арга хэрэгслийг банкны салбарын үйл ажиллагааны онцлогтой уялдуулан эрсдэлийн үнэлгээнд суурилсан хяналт шалгалтыг үргэлжлүүлнэ.

Банкны хяналт шалгалтын Базелийн хорооноос тогтоосон зарчим, олон улсад мөрдөгддөг жишгийн дагуу банкны нэгдсэн хяналт шалгалтыг хэрэгжүүлэхэд Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөж байгаа Банкны тухай хууль болон бусад хууль тогтоомжтой нийцэж байгаа эсэх талаар Монголбанкнаас нэгдсэн хяналт шалгалтын зарчим, шалгуур үзүүлэлт тус бүрээр судалж урьдчилсан дүгнэлтийг гаргаад байна. Монголбанк нь энэхүү ажлын хүрээнд Азийн хөгжлийн банкны олон улсын зөвлөхтэй хамтран ажилласан бөгөөд энэ хүрээнд Банкны тухай хуулийн 3 болон 43 дугаар зүйлд тодорхойлсон банкны нэгдэл, банкны нэгдсэн хяналт шалгалт, түүнийг хэрэгжүүлэх журмын зохицуулалтуудыг сайжруулах, банкны нэгдлийн хэмжээнд санхүүгийн зохистой шалгуур үзүүлэлт тогтоох, нэгдсэн хяналт шалгалтын дагуу Банкны нэгдэлд авах албадлагын арга хэмжээ, хянан шалгагчийн бүрэн эрхтэй холбоотой хууль эрх зүйн зохицуулалтыг судалсан. Банкны нэгдсэн хяналт шалгалтын талаарх судалгааны эцсийн үр дүнд үндэслэн хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээг Банкны хууль тогтоомжийн хүрээнд судлан, хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай эсэхийг тогтоохоор ажиллаж байна.

Олон улсын жишгээр хяналт шалгалтын аргачлал нь гүйцэтгэлд суурилсан аргачлалаас эрсдэлийн үнэлгээнд суурилсан хяналт шалгалтын аргачлалд шилжих хандлагатай болсон тул банкуудын ирээдүйд хүлээж болзошгүй эрсдэлийг урьтаж илрүүлэх, оновчтой тооцоолох, хяналт шалгалтын нөөц, чадавхыг эрсдэл өндөртэй гэж үзсэн үйл ажиллагааны чиглэлд түлхүү хуваарилах, улмаар системийн эрсдэл үүсэх сөрөг үр дагаврын далайцыг

бууруулах зохицуулалтын дэвшилтэт аргачлалыг нэвтрүүлэхэд Монголбанкны зүгээс онцгой анхааран ажиллаж байна. Тус ажлын хүрээнд шинэ аргачлалыг хэрэгжүүлэхэд шаардлагатай журам, гарын авлага боловсруулахаар тус асуудлаар мэргэшсэн олон улсын зөвлөхтэй хамтран ажиллаж, эрсдэлд суурилсан хяналт шалгалтын журмын төслийг урьдчилсан байдлаар боловсруулаад байна.

ОУВС-гийн мэргэжилтнүүдийн өгсөн техник туслалцаа, зөвлөмжийн дагуу банкны хяналт шалгалт хийх бүтэц зохион байгуулалтыг сайжруулан, эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг хэрэгжүүлэхэд тохиромжтой байдлаар шинэчлэх асуудлыг хэлэлцэж байна.

“Банкны хяналт шалгалтын дунд хугацаанд хэрэгжүүлэх стратеги”-ийн төслийг баталж, ойрын 5 жилд банкны хяналт шалгалтын хүрээнд хийгдэх онцлох арга хэмжээнүүдийг шат дараатайгаар авч хэрэгжүүлэхээр дунд хугацааны төлөвлөгөөнд тусгасантай холбогдуулан Базель стандартад шилжих стратеги хөтөлбөрийн анхны хувилбарыг олон улсын зөвлөх боловсруулан, ойрын 5 жилийн хугацаанд Базель III стандартад шилжихэд Монголбанкны зүгээс баримтлах бодлого, авах арга хэмжээг энэхүү хөтөлбөрт тусгалаа. Энэхүү цуврал стандартыг нэвтрүүлснээр нийт банкны салбарын эрсдэл даах чадварыг сайжруулахын зэрэгцээ хяналт шалгалтын олон улсад мөрдөгдөх стандартад нийцсэн хяналт, зохицуулалтын аргачлалыг ашиглах боломж бүрдэнэ.

Түүнчлэн банкуудад мөрдөгдөж буй нягтлан бодох бүртгэлийн багц материалыг санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн шинэчлэн боловсруулж, 2015 оны 2 дугаар сарын 6-ны өдрийн А35/20 дугаар тушаалаар Сангийн яамтай хамтран баталж, банкуудаас тайлан хүлээн авах програм хангамжийг шинэчилсэн болно. Банкуудын олон нийтэд тайлагнадаг мэдээллийн стандарт загвар, зөвлөмжийг шинэчлэх ажлын хүрээнд Монголбанк, Нидерландын хөгжлийн банк, Олон улсын санхүүгийн корпораци болон Монголын банкны холбооноос хамтран зохион байгуулсан “Компанийн засаглалын хэлэлцүүлэг”-ийн үр дүнд холбоотой этгээдийн зээл болон хувьцаа эзэмшигчдийн ашиг сонирхлын зөрчилдөөний асуудлуудыг хэрхэн амжилттай удирдан шийдвэрлэх талаар олон улсын шилдэг туршлагад нийцүүлсэн зөвлөмжийн төслийг боловсруулаад байна.

2.3 Банкны үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийг төрөлжүүлэн олгох эрх зүйн орчныг сайжруулах боломжийг судалж, дотоод, гадаадын эрх бүхий байгууллагатай хамтран үр нөлөөтэй хяналт шалгалтыг боловсронгуй болгох чиглэлд ажиллана.

Монголбанкнаас Банкны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан банкны үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийг тухайн банкны онцлог, үйл ажиллагааны чиглэлээс хамааруулан төрөлжүүлэн олгох талаар судалгаа хийж, түүнд үндэслэн журам боловсруулахаар ажиллаж байна. Тухайлбал, гадаадын хөрөнгө оруулалттай банк Монгол Улсад үйл ажиллагаа явуулах бол банкны үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийг хязгаарлалттай олгох болон эдийн засгийн тухайлсан салбараас хамааруулж банкинд зөвхөн тухайн салбарт үйл ажиллагаа явуулах хязгаарлалт тогтоох зэрэг олон улсад хэвшсэн жишиг, загваруудыг судлаад байна. Банкны тусгай зөвшөөрлийг төрөлжүүлэн олгох давуу болон сул талуудыг тодорхойлсны үндсэн дээр банкны хууль тогтоомжид нийцүүлэн холбогдох эрх зүйн баримт бичгийн төслийг боловсруулсан.

Гадаад орнуудын хяналт шалгалтын эрх бүхий байгууллагуудтай хяналт шалгалтын

үр нөлөөтэй аргачлалыг хэрэгжүүлэх, боловсронгуй болгох талаар хамтран ажиллаж байна. Тухайлбал, Япон улсын хяналт шалгалтын төв байгууллага болох Санхүүгийн үйлчилгээний агентлагтай тогтоосон хамтын ажиллагааны хүрээнд 1 хянан шалгагч тус байгууллагад очиж туршлага судалсан бөгөөд цаашид хамтын ажиллагааг улам өргөжүүлэх чиглэлээр хоёр байгууллагын удирдлагууд харилцан санал солилцож байна.

Төрөлжсөн үйл ажиллагаатай банкны зөвшөөрөл олгохтой холбоотой эрх зүйн зохицуулалтыг “Банкны зөвшөөрлийн журам”-ын шинэчилсэн найруулгын төсөлд тусгахаар ажиллаж байна.

3. САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ДЭД БҮТЭЦ, ТҮҮНИЙ ИНСТИТУЦИЙГ БЭХЖҮҮЛЭХ ХҮРЭЭНД:

3.1 Монгол Улсын төлбөр тооцооны системийн найдвартай, тасралтгүй ажиллагааг хангаж, дэвшилтэт технологид суурилсан банкны шинэлэг үйлчилгээг олон нийтэд хүртээмжтэй болгох чиглэлээр ажиллана.

3.1.1 Их болон бага дүнтэй төлбөр тооцооны систем, картын нэгдсэн сүлжээ, үнэт цаасны төлбөр тооцооны найдвартай, тасралтгүй ажиллагааг хангаж ажиллах, Төлбөрийн системийн хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр холбогдох байгууллагатай хамтран ажиллах

Монгол Улсын төлбөрийн системийн хууль, эрх зүйн орчныг сайжруулах, хяналтын чадавхыг бэхжүүлэх зорилгоор Дэлхийн банкны техник туслалцаа авах төслийг баталж, хоёр жилийн хугацаанд хамтран ажиллах төлөвлөгөөг боловсруулсан. Үүний дагуу Монгол Улсын төлбөрийн системийн өнөөгийн байдалтай танилцаж, үнэлгээ өгөх зорилгоор 3 зөвлөхийн бүрэлдэхүүнтэй Дэлхийн банкны ажлын хэсэг 2015 оны 3 дугаар сарын 3-11-ний хооронд хүрэлцэн ирж, хамтын ажиллагааг эхлүүлсэн. Энэ үеэр төлбөрийн системийн оролцогч болох Сангийн яам, Санхүүгийн зохицуулах хороо, ҮЦГТТХТ болон банкуудтай уулзалт хийж, төлбөрийн системийн өнөөгийн байдал, Монголбанкны зүгээс бодлогын хүрээнд ойрын үед хэрэгжүүлбэл зохих арга хэмжээний талаар санал солилцсон болно. Ажлын хэсгээс ирүүлсэн тайлангийн төсөлтэй танилцаж, нэмэлт мэдээлэл болон тайлбар бэлтгэж Дэлхийн банкинд хүргүүлсэн бөгөөд ажлын хэсгийн дараагийн уулзалтыг 9 дүгээр сард хийхээр тохиролцоод байна.

Мөн дээрх ажлын хүрээнд 2015 оны 6 дугаар сарын 25-ны өдөр төлбөрийн системийн шинэчлэлийн зээлийн гэрээг соёрхон баталсан бөгөөд энэ дагуу Азийн хөгжлийн банктай байгуулсан төслийн гэрээнд /Ажлын төлөвлөгөө/ төлбөрийн системийн хууль, эрх зүйн орчныг сайжруулж, шинээр хуулийн төсөл боловсруулах ажлыг тусгасан. Төлбөрийн системийн хуулийн төслийг боловсруулах ажлын хэсэг байгуулах, боловсруулсан төслийг УИХ-д өргөн мэдүүлэх ажлыг зохион байгуулах саналыг Хууль зүйн яаманд 2015 оны 7 дугаар сарын 10-ны өдрийн А-1/718 дугаар албан бичгээр хүргүүлээд байна.

Тайлант хугацаанд их дүнтэй төлбөр тооцооны “Банксүлжээ” систем, бага дүнтэй төлбөр тооцооны систем, картын нэгдсэн сүлжээ болон үнэт цаасны төлбөр тооцооны найдвартай, тасралтгүй ажиллагааг ханган ажилласан. 2015 оны 9 дүгээр сарын 10-ны

өдрийн байдлаар 1.1 их наяд төгрөгийн дүнтэй 14.5 сая ширхэг бага дүнтэй гүйлгээ, 1.4 их наяд төгрөгийн дүнтэй 28.5 сая ширхэг картын гүйлгээ, 40.5 их наяд төгрөгийн дүнтэй 931.7 мянган ширхэг их дүнтэй гүйлгээг тус тус боловсруулсан байна.

Төлбөрийн системийн тасралтгүй ажиллагааг хангах зорилгоор төлбөр тооцооны системүүдийн үйл ажиллагааны тайланг 7-14 хоногийн давтамжтайгаар гаргуулан, хяналт тавин ажиллаж байна. Тайлант хугацаанд бага дүнтэй төлбөр тооцооны системээр дамжин хийгдсэн, үндэсний боловсруулах үйлдвэрт ноос, арьс, шир бэлтгэн тушаасан хоршооны гишүүн малчин, мал бүхий этгээдэд мөнгөн урамшуулал олгох үйл ажиллагаанд шалгалт хийлээ.

Олон улсын төлбөр тооцооны банк болон Үнэт цаасны хороодын олон улсын байгууллагаас гаргасан “Санхүүгийн зах зээлийн дэд бүтцийн зарчмууд: Үнэлгээний аргачлал ба ил тод байдлын тайлан” баримт бичгийн дагуу ҮЦТТХТ-ийн үйл ажиллагаа болон их, бага дүнтэй төлбөрийн системийн үйл ажиллагаанд тус тус үнэлгээ хийсэн. Энэхүү үнэлгээг хийснээр “Санхүүгийн зах зээлийн дэд бүтцийн зарчмууд”-ын хэрэгжилт үнэт цаасны төлбөр тооцооны системийн түвшинд хэрхэн хангагдаж байгааг тодорхойлж, хэрэгжилтийн түвшинг ахиулан, түүнийг тогтмол хангуулахад дэмжлэг үзүүлэх юм.

3.1.2 Банк хоорондын төлбөр тооцоонд цахим нэхэмжлэлийн системийг нэвтрүүлэх боломжийг судалж танилцуулах

Монгол Улсын Засгийн газар, Азийн хөгжлийн банк хооронд байгуулсан “Төлбөрийн системийн шинэчлэл төсөл”-ийн зээлийн хэлэлцээр УИХ-ын 2015 оны 6 дугаар сарын 25-ны өдрийн нэгдсэн чуулганаар батлагдсан.

Төслийн хүрээнд нэвтрүүлэх системүүдийн жагсаалтад банк хоорондын цахим нэхэмжлэлийн системийг агуулсан АСН (Automated Clearing House)-г нэвтрүүлэхээр тусгасан болно.

3.2 Санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн банкны зах зээлд оролцогчдын эрх ашгийг хамгаалах, олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх цогц арга хэмжээг эрчимжүүлнэ.

“Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөр”-ийн төслийг Дэлхийн банкны зөвлөмж, олон улсын туршлагад үндэслэн Сангийн яам, Санхүүгийн зохицуулах хороо холбогдох бусад байгууллагатай хамтран боловсруулсан. Түүнчлэн “Олон нийтийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх нь” сэдэвт семинарыг 2015 оны 1 дүгээр сарын 27-ны өдөр Дэлхийн банктай хамтран зохион байгуулснаас гадна иргэдийн санхүүгийн мэдлэг, боловсролыг дээшлүүлэх чиглэлээр төрийн холбогдох байгууллагатай уулзалт зохион байгуулж, цаашид хамтран ажиллах талаар санал солилцсон бөгөөд оролцогч байгууллагуудын хэрэгжүүлж байсан болон хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа ажлуудын талаар мэдээлэл авч, судалгаа хийсэн.

“Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөр”-ийг холбогдох

байгууллагуудтай хамтран боловсруулж, Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлөөр хэлэлцүүлсний үндсэн дээр баталж хэрэгжүүлэхээр байна.

3.3 Мөнгөний бодлогын шийдвэр гаргах үйл ажиллагааг улам боловсронгуй болгон, мөнгөний бодлогын үндсэн зорилт, хэрэгжилтийг олон нийтэд тогтмол тайлагнах ажлыг үргэлжлүүлж, Төв банкны нээлттэй, ил тод байдлыг хадгална. Энэ хүрээнд инфляцийн төлөв байдлын илтгэлийг улирал бүр, санхүүгийн тогтвортой байдлын тайланг хагас жил тутам Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлөөр хэлэлцүүлж, Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороонд хүргүүлнэ.

Монголбанк мөнгөний бодлогын шийдвэрийг оновчтой гаргах, шийдвэр гаргах үйл ажиллагааг улам боловсронгуй болгох зорилгоор олон улсын жишигт нийцүүлсэн Мөнгөний бодлогын зөвлөл (МБЗ)-ийг 2012 оны 10 дугаар сард шинээр байгуулсан билээ. Тайлант хугацаанд МБЗ нь Монголбанкны 6 гишүүн, төрийн байгууллага, их дээд сургуулийн багш, судлаачдыг төлөөлсөн хараат бус 5 гишүүн буюу нийт 11 гишүүний бүрэлдэхүүнтэй ажиллаж байна.

Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар МБЗ-ийн хурлын товыг жил бүрийн эхэнд баталж, жилд 4-өөс доошгүй удаа хуралдахаар тогтоодог. МБЗ-ийн 2015 оны хурлын товыг Монголбанкны Ерөнхийлөгчийн 2015 оны 1-р сарын 20-ны өдрийн А-10 дугаар тушаалаар баталж, Монголбанкны цахим хуудаст байршуулсан бөгөөд зөвлөлийн хурлыг хуваарийн дагуу зохион байгуулж байна.

МБЗ нь байгуулагдсан цагаас хойш урьдчилан товлосон хурлын товын дагуу макро эдийн засгийн төлөв байдал, инфляцийн төсөөллийг агуулсан мөнгөний бодлогын саналыг 2-3 удаагийн хуралдаанаар хэлэлцэж, асуудлыг тал бүрээс нь авч үзсэн мэтгэлцээний үр дүнд бодлогын шийдвэрийг гаргаж ирлээ. Тайлант хугацаанд МБЗ нь 2015 оны 1 дүгээр сарын 14, 4 дүгээр сарын 10, 7 дугаар сарын 2-ны өдрүүдэд буюу нийт 3 удаа мөнгөний бодлогын шийдвэрийг гаргасан. Гарсан шийдвэрийг хэвлэлийн хурал, мөнгөний бодлогын мэдэгдлээр олон нийтэд мэдээлж, хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан шийдвэрийн үндэслэл, шалтгааныг тайлбарлан, хуралдааны товч тэмдэглэлийг цахим хуудаст байршуулав.

Мөнгөний бодлогын үндсэн зорилт, хэрэгжилтийг олон нийтэд тогтмол тайлагнах хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

- Мөнгөний бодлогын зөвлөлийн шийдвэртэй холбоотойгоор хэвлэлийн хурлыг 2015 оны 1 дүгээр сарын 14, 4 дүгээр сарын 10, 7 дугаар сарын 2-ны өдөр зохион байгуулж, “Мөнгөний бодлогын мэдэгдэл”-ийн монгол, англи хувилбарыг тухайн өдрүүдэд Монголбанкны цахим хуудаст байршуулав.
- МБЗ-ийн ажиллах журамд заасны дагуу хэвлэлийн хурал болсноос хойш 14 хоногийн дотор мөнгөний бодлогын зөвлөлийн хурлын тэмдэглэлийн товчлолыг гарган Монголбанкны цахим хуудаст байршуулав.
- Монголбанкны цахим хуудаст эрх зүйн баримт бичиг, журам, заавар, судалгааны ажил, тайлан, статистик мэдээ, хэвлэмэл бүтээгдэхүүн зэрэг цаг үеийн болон графикт 500 гаруй мэдээ мэдээллийг тухай бүр байршуулав. Түүнчлэн Монголбанкны статистикийн сарын бюллетень, мэдээллийг УИХ-ын гишүүд, арилжааны банкууд, эдийн засагчдын

цахим хаягаар тухай бүр хүргүүлэв.

- Монголбанкнаас хэрэгжүүлж байгаа бодлого, хөтөлбөрийн хэрэгжилтийн явц болон цаг үеийн асуудлаар давхардсан тоогоор хэвлэлд 300 гаруй удаа ярилцлага, тодруулга, мэдээлэл өгөв.
- Олон нийтийг Монголбанкны үйл ажиллагаатай танилцах экскурсыг тогтмол зохион байгуулан ажиллав. 2015 оны 5 дугаар сарын 25-нд Дорнод аймгийн Хаан банкны төлөөлөгч, ажилтнуудад; 2015 оны 5 дугаар сарын 19-нд “Амгалан” цогцолбор сургуулийн сурагчдын мэргэжил сонгох аяллын хүрээнд; 2015 оны 5 дугаар сарын 19-нд Баянзүрх дүүргийн 33-р сургуулийн сурагчдад; 2015 оны 6 дугаар сарын 11-нд “Дэлхийн зөн” хүүхдийн байгууллагын идэвхтэн сурагчдад; 2015 оны 6 дугаар сарын 19-нд Банк санхүүгийн академийн теллерийн сургалтад оролцогчдоод; 2015 оны 6 дугаар сарын 24-нд “Ундраа” хүүхдийн зуслангийн 150 сурагчдад Монголбанкны түүх, үйл ажиллагааны талаар богино хэмжээний сургалт зохион байгуулж лекц уншин Эрдэнэсийн сантай танилцуулж хэвлэмэл бүтээгдэхүүнийг дурсгав.
- Инфляцийн төлөв байдлын тайланг 2015 оны 4-р сарын 2-ны өдөр УИХ-ын Эдийн засгийн байнгын хороонд хүргүүлж, Монголбанкны цахим хуудаст байршуулан, УИХ-ын гишүүдийн цахим хаягаар инфографик хэлбэрээр илгээв.
- УИХ-ын гишүүд, эдийн засагчид, их дээд сургууль, иргэд, олон нийтэд Монголбанкны хэвлэмэл бүтээгдэхүүн, “*Эдийн засаг, санхүүгийн нэр томъёоны тайлбар толь*”-ийг тус тус хүргүүлэв.
- Инфляци гэж юу вэ, инфляцид нөлөөлөгч хүчин зүйлс /2015.03.18/; Эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангахад чиглэсэн мөнгөний бодлого /2015.03.20/; Валютын бодлогын асуудлууд /2015.03.25/; Төсөв, мөнгөний бодлогын харилцан уялдаа, санхүүгийн тогтвортой байдал /2015.03.27/; Монголбанкны алт худалдан авах үйл ажиллагаа /2015.04.01/ , Мөнгөний бодлогын хэрэгслүүд ба мөнгөний зах зээл дэх үйл ажиллагаа /2015.04.08/, Гадаад секторын шинжилгээ /2015.04.10/, Банкны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд, эрсдлийн үнэлгээнд суурилсан хяналт шалгалт /2015.04.15/, Санхүүгийн тогтвортой байдлын үнэлгээ /2015.04.17/, Санхүүгийн тогтвортой байдлын тайлан /2015.04.22/, Мөнгө, валютын зах зээлийн төлөв байдал /2015.04.24/, Моргейжийн зээл гэж юу вэ, орон сууцны ипотекийн зах зээлийг хөгжүүлэх асуудлууд /2015.04.29/, Төлбөрийн системийн шинэчлэл /2015.05.01/, Гадаад валютын улсын нөөцийн удирдлага /2015.05.06/, Монголбанкны статистикийг хэрхэн ашиглах вэ /2015.05.13/, Мөнгө угаах гэмт хэрэг, түүнээс сэргийлэх нь /2015.05.20/, Монгол Улсын төлбөр тооцооны систем /2015.05.27/, Макро тогтвортой байдал ба эдийн засгийн тогтвортой өсөлт /2015.06.03/, Инфляцийн эсрэг бодлогын үр дүн /2015.06.05/ зэрэг сэдвүүдийн хүрээнд эдийн засаг, санхүүгийн салбарын чиглэлээр ажилладаг хэвлэл мэдээллийн ажилтнуудад цуврал сургалтыг зохион байгуулав.

Мөнгөний бодлогын шийдвэр гаргах үйл ажиллагааг боловсронгуй болгох хүрээнд Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 27 дугаар зүйлд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар зохицуулж байгаа Мөнгөний бодлогын зөвлөлийн эрх зүйн байдал, үйл ажиллагааны журмыг тодорхойлсон хуулийн төсөл боловсруулах судалгааг хийгээд байна. Бусад улсын төв банкны туршлага, олон улсад мөрдөгдөж буй төв банкны засаглалын зарчим, жишгийг судалсан бөгөөд мөнгөний бодлогын зөвлөлийн ач холбогдол, бүтэц, шийдвэрлэх асуудлын хүрээ, шийдвэр гаргах үйл явц, тайлагнал, хариуцлагын талаар уг судалгаанд тусгасан болно. Судалгааны үр

дүнд үндэслэн Мөнгөний бодлогын зөвлөлийн талаар Төв банк (Монголбанк)-ны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл, үзэл баримтлал, танилцуулгын төслийг боловсруулж байгаа бөгөөд төлбөрийн тэнцлийн хүндрэл арилсан, эдийн засгийн нөхцөл байдал сайжирсан, макро эдийн засгийн гадаад, дотоод тэнцвэр хангагдсан буюу хэвийн нөхцөл, оновчтой цаг үед хуулийн төслийг УИХ-д өргөн барих нь зүйтэй гэж үзсэн болно.

Монголбанкнаас “*Инфляцийн төлөв байдлын тайлан*”-гийн эхний дугаарыг 2014 оны эцсийн байдлаар тоон мэдээлэлд үндэслэн анх удаа албан ёсоор боловсруулж, олон нийтийн хүртээл болгоод байна. “*Инфляцийн төлөв байдлын тайлан*”-гийн хоёр дахь дугаарыг 2015 оны 1 дүгээр улирлын тоон мэдээлэлд үндэслэн боловсруулж, 2015 оны 6 дугаар сард олон нийтэд тархаав.

Инфляцийн төлөв байдлын тайланг ийнхүү гаргаснаар мөнгөний бодлогын шийдвэр гаргасан үндэслэлийг тайлбарлах, олон нийтэд таниулах замаар мөнгөний бодлогын ил тод байдлыг нэмэгдүүлэх ач холбогдолтой. Үүний зэрэгцээ инфляцид нөлөөлж буй хүчин зүйлс, инфляцийн төсөөлөл, чиг хандлагыг олон нийтэд дэлгэрэнгүй тайлбарлаж байна. Мөн энэхүү тайлан нь гадаад болон дотоодын санхүүгийн байгууллага, хөрөнгө оруулагчдын хөрөнгө оруулалтын шийдвэр гаргах, бизнесийн төлөвлөгөөгөө боловсруулахад нь ирээдүйн төлөв байдлын талаар мэдээлэл авах нэг чухал эх сурвалж болох юм.

Монголбанк дахь Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн ажлын албанаас “*Монгол Улсын санхүүгийн тогтвортой байдлын тайлан*”-гийн эхний 4 дугаарыг нэгтгэн боловсруулж, цахим хуудсаар болон хэвлэмэл хувилбараар олон нийтэд хүргээд байгаа билээ. Үүний зэрэгцээ уг тайланг УИХ-ын ЭЗБХ-нд хүргүүлсэн болно. Тайлангийн 5 дахь дугаарыг нэгтгэн боловсруулаад байгаа бөгөөд энэ оны 9 дүгээр сард Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлөөр хэлэлцүүлсний үндсэн дээр олон нийтийн хүртээл болгоно.

3.4 Санхүүгийн зах зээлд экспортын болон давхар даатгалын оновчтой тогтолцоог бий болгох ажлыг эхлүүлнэ.

Энэ чиглэлээр Санхүүгийн зохицуулах хороотой хамтын ажиллагааг эхлүүлсэн бөгөөд Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2015 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн 123 дугаар тушаалаар батлагдсан санхүүгийн зах зээлийн бодлогыг тодорхойлох, зохицуулах, хянахтай холбогдсон үйл ажиллагаанд туслалцаа үзүүлэх чиг үүрэг бүхий Даатгалын бодлогын зөвлөлийн бүрэлдэхүүнд Монголбанкны төлөөлөл ажиллаж байна.

3.5 Хадгаламж зээлийн хоршооны гишүүдийн хадгаламжийг мөнгөн хадгаламжийн даатгалд хамруулах бэлтгэл ажлыг хангана.

Энэ чиглэлээр төлөвлөгөөнд заасан ажлыг Санхүүгийн зохицуулах хороотой хамтран боловсруулахаар бэлтгэл ажил хийгдэж байгаа бөгөөд асуудлыг Санхүүгийн зохицуулах хорооноос Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлд хэлэлцүүлэх хүлээлттэй байна.

3.6 Тогтвортой санхүүжилтийн санаачилгыг дэмжиж ажиллана.

Тогтвортой санхүүжилтийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хэсэгт Монголбанкны төлөөлөл чиг үүргийн дагуу тогтмол оролцоотой ажиллаж, тогтвортой санхүүжилтийн санаачилгыг дэмжих үүргээ биелүүлж байна. Тогтвортой санхүүжилт /ТоС/-ийн ажлын хэсэг 2015 оны эхний хагаст дараах гол ажлуудыг хийж гүйцэтгэв. Үүнд:

1. ТоС-ийн 8 зарчмын хүрээнд 2015 онд ТоС-ийн гишүүд хамтран хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийг боловсруулан ТоС-ийн удирдах хороогоор батлуулав.
2. ТоС-ийн 4 салбарын удирдамжийн хүрээнд тавих тусгай шаардлагуудыг батлав.
3. Байгаль орчин, нийгэм /БОН/-ийн эрсдлийн үнэлгээний аргачлалын дагуу үнэлсэн зээлийн тайлангийн загварыг боловсруулав.
4. ТоС-ийн гишүүд 2015 оны 3-р сарын 5-ний өдөр Хамтран хэрэгжүүлэх арга хэмжээний баримт бичигт гарын үсэг зурав.
5. ТоС-ын удирдах хорооноос 2015 оны 6-р сарын 19-нд “Монгол Улсын ТоС-ийн гишүүн байгууллага байх шалгуур, нөхцөлүүд”, “Монгол Улсын ТоС-ийн хөтөлбөрийн тайлан, маяг”-ыг батлав.
6. Байгаль орчин, нийгэмд үзүүлэх нөлөөллийн түвшнээр нь ангилсан, Монголбанкинд нэгтгэгдэх тайлангийн маягтыг шинэчлэн боловсруулж байна.
7. ТоС-ын гишүүн банкнаас ирүүлсэн хүсэлтийн дагуу Тос-ын ажлын хэсэг “Байгаль орчин, нийгмийн эрсдлийн үнэлгээний аргачлал”-ыг шинэчлэн боловсруулж байна.

_____ооо_____


IV. ТӨСЛИЙН ТООЦОО, СУДАЛГАА

4.1. ИНФЛЯЦИ

2015 оны 8 дугаар сарын байдлаар хэрэглээний үнийн индексээр хэмжсэн жилийн инфляци улсын хэмжээнд 6.6 хувь, Улаанбаатар хотын хэмжээнд 5.9 хувь байлаа. Улсын хэмжээнд тооцсон жилийн инфляци өнгөрсөн оны мөн үеэс 7.1 нэгж хувиар, Улаанбаатар хотын жилийн инфляци 7.6 нэгж хувиар тус тус буурчээ. Инфляци ийнхүү зорилтот түвшинд ирэхэд дараах хүчин зүйлс нөлөөлөв: (1) Мөнгөний бодлогоор эдийн засгийн гадаад тэнцвэрийг дэмжиж байгаагаас дотоод эрэлт хумигдаж, эрэлтийн шалтгаантай инфляцийн дарамт буурсан; (2) Нийлүүлэлтийн гаралтай инфляцийн дарамт 2013-2015 оны туршид эрс буурсан; (3) Эдийн засгийн гадаад тэнцвэрийг дэмжсэнээр төлбөрийн тэнцэл алдагдалгүй болж, валютын зах тогтворжихын хэрээр төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийн инфляци дахь сөрөг нөлөөлөл саарсан.


Хэрэглээний сагснаас өндөр хэлбэлзэлтэй бараа, бүтээгдэхүүнүүдийг хасч тооцдог суурь инфляци сүүлийн 20 сарын туршид ерөнхий инфляциас өндөр байв. Суурь инфляцийн түвшин 2015 оны 8 дугаар сарын байдлаар 7.2 хувь байсан ба энэ нь өнгөрсөн оны мөн үеэс 8.4 нэгж хувиар, энэ оны эхнээс 5.4 нэгж хувиар тус тус буурчээ.

Зураг 14. Улсын болон Улаанбаатар хотын инфляци



Эх сурвалжууд: Үндэсний Статистикийн Хороо /УСХ/

Зураг 15. Улаанбаатар хотын жилийн инфляци болон ханшийн өөрчлөлт



Хүнс, шатахуун, төрийн зохицуулалттай бараанаас бусад бараа, бүтээгдэхүүний инфляцид үзүүлэх нөлөө өмнөх оны мөн үетэй харьцуулахад 5.1 нэгж хувиар буурчээ. Ийнхүү уг бүлгийн үнийн өсөлтийн нөлөө сүүлийн 4 жилийн хамгийн бага түвшинд хүртлээ буурахад суурь үеийн өндөр өсөлтийн нөлөөнөөс гадна макро эдийн засгийн гадаад тэнцвэр 2013-2014 онтой харьцуулахад сайжирсан, дотоод эрэлт хумигдсан, төгрөгийн ханш сулрах эрч саарч, түүний инфляци дахь нөлөөлөл саармагжсан зэрэг нь нөлөөлөв. Цаашид төгрөгийн ханш огцом сулрахгүй тохиолдолд ирэх саруудад бусад бараа, үйлчилгээний үнийн өсөлт үргэлжлэн буурах төлөв ажиглагдаж байна. Иймээс инфляцийн түвшин энэ оны эцэст зорилтот түвшинд гарахаар байна.

2015 оны 8 дугаар сарын байдлаар Улаанбаатар хотын оны эхнээс тооцсон инфляци 2.8 хувь гарлаа. Үүний 0.1 нэгж хувийг мах, махан бүтээгдэхүүн, 0.7 нэгж хувийг махнаас бусад хүнсний бүтээгдэхүүн, 1.4 нэгж хувийг төрийн зохицуулалттай бараа, үйлчилгээ, 0.6 нэгж хувийг бусад бараа, бүтээгдэхүүний үнийн өөрчлөлт тайлбарлаж байна.


4.2. БОДИТ СЕКТОР

4.2.1 Нийт нийлүүлэлт

ДНБ 2015 оны эхний хагас жилд өмнөх оны мөн үеэс 3.0 хувиар өслөө. Эдийн засгийн өсөлтөд уул уурхайн салбар 16.5 хувиар өсч голлох хувь нэмэр оруулсан. Харин уул уурхайн бус салбар 2015 оны эхний хагас жилийн байдлаар 0.2 хувийн уналттай байлаа. Уул уурхайн бус салбаруудаас хөдөө аж ахуй, үйлчилгээний бусад салбар эдийн засгийн өсөлтөд голлох эерэг нөлөөг үзүүлсэн бол худалдаа, тээвэр, барилгын салбар болон бүтээгдэхүүний цэвэр татвар өсөлтийг сааруулах нөлөөтэй байв.

Уул уурхайн салбарын 2015 оны эхний хагас жилийн өсөлтөд зэсийн баяжмалын олборлолт өмнөх оны мөн үеэс 23.4 хувиар, газрын тос олборлолт 14.9 хувиар, алт олборлолт 22.3 хувиар тус тус нэмэгдэж эерэг нөлөө үзүүлсэн бол нүүрс олборлолт 2.4 хувийн, төмрийн хүдэр олборлолт 47 хувийн бууралттай байлаа. Олон улсын зах зээл дээрх түүхий эдийн үнийн бууралт нь нүүрс, төмрийн хүдэр зэрэг уул уурхайн гол нэр төрлийн бүтээгдэхүүний олборлолтод сөрөг нөлөөлсөн хэвээр байна.

Зураг 16. ДНБ-ий жилийн өсөлт



Эх сурвалжууд: УСХ

Хүснэгт 3. Салбаруудын жилийн өсөлт /2015H1-н өсөлтөд эзлэх хувиар эрэмбэлсэн/

	2014	2015H1	
	YoY %	YoY %	өсөлтөд эзлэх %
ДНБ	7.8	3.0	3.0
Уул уурхай	19.1	16.5	3.2
Хөдөө аж ахуй	13.7	9.4	1.3
Бусад үйлчилгээ	10.3	5.6	1.2
Боловсруулах	4.6	5.2	0.3
Цахилгаан, хий, уур, ус хангамж	4.3	3.9	0.1
Мэдээлэл, холбоо	7.3	1.7	0.0
Барилга	1.0	1.3	0.0
Тээвэр ба агуулах	14.1	-4.0	-0.2
Худалдаа	0.5	-7.6	-0.9
Бүт. татвар	-8.1	-14.5	-2.0

Хөдөө аж ахуйн салбарын өсөлт 2015 оны эхний хагас жилд өмнөх оноос бага зэрэг саарч 9.4 хувьтай гарлаа. 2015 оны 6-р сарын байдлаар улсын хэмжээнд нийт 66.5 сая гаруй толгой мал тоологдсон нь өмнөх оны мөн үеэс 12.3 хувиар нэмэгдсэн үзүүлэлт юм. Газар тариалангийн салбарын хувьд нийт 517.8 мянган га талбайд тариалалт хийснээс ургацын урьдчилсан балансын дагуу 265.0 мянган тонн үр тариа, үүнээс 252.3 мянган тонн улаан буудай хураан авахаар байгаа нь өмнөх оны гүйцэтгэлээс бараг 2 дахин буурчээ. Иймд хөдөө аж ахуйн салбарын өсөлт оны сүүлийн хагаст саарахаар байна.


Эдийн засгийн өсөлтийг сааруулах нөлөө үзүүлсэн салбаруудыг авч үзвэл худалдааны салбарын бууралт үргэлжлэн 2015 оны эхний хагаст 7.6 хувьд хүрчээ. Өрхийн орлогын өсөлт саарч, улмаар өрхийн эцсийн хэрэглээний зардлын өсөлт буурч байгаа, импорт 2013-2014 оны туршид харгалзан 6 хувь, 17 хувиар, харин 2015 оноос эхлэн хурдацтай буюу 30 хувиар агшсан зэрэг нь худалдааны салбарын бууралтыг голлон тайлбарлаж байна.

Сүүлийн жилүүдэд хөдөө, орон нутагт авто зам барьж байгуулах бүтээн байгуулалтууд эрчимтэй хийгдсэнээр авто замын тээврийн ачаа эргэлтийг нэмэгдүүлж тээврийн салбарын өндөр өсөлтийг голлон тайлбарлаж байсан. Харин тайлант хугацаанд төмөр зам, авто зам болон агаарын тээврийн дийлэнх үзүүлэлтүүд буурсан бөгөөд тээврийн салбар 4.0 хувиар агшжээ. Эдийн засгийн өсөлтийн сааралт, бизнесийн идэвхжилийн удаашрал үргэлжлэн, гадаад худалдааны барааны эргэлт, импорт, тээвэрлэлт буурч байгаагаас шалтгаалан дотоодод үйлдвэрлэгдсэн болон импортоор орж ирдэг бараанд ногдуулдаг татварын бодит дүн 2015 оны эхний хагаст өмнөх оны мөн үеэс 14.5 хувиар буураад байна.


4.2.2 Нийт эрэлт

Эдийн засгийн нийт эрэлт талаас тооцсон бодит ДНБ 2015 оны эхний хагас жилийн урьдчилсан гүйцэтгэлээр өмнөх оны мөн үеэс 3.1 хувиар өсчээ. Өрхийн хэрэглээний өсөлт болон гадаад худалдааны тэнцэл эдийн засгийн өсөлтөд эерэг нөлөө үзүүлсэн бол хөрөнгө оруулалт болон засгийн газрын хэрэглээ эдийн засгийн өсөлтийг бууруулах нөлөө үзүүлэв. Өрхийн хэрэглээ 2015 оны эхний хагас жилд өмнөх оны мөн үеэс 3.8 хувиар өсч, ДНБ-ий өсөлтөд 2.5 нэгж хувийн нөлөө үзүүлэв. Өрхийн хэрэглээний зардлын өсөлт саарсан нь өрхийн орлогын өсөлт буурсантай холбоотой байна.

Зураг 17. ДНБ-ий өсөлт, бүрэлдэхүүнээр



Зураг 18. Засгийн газрын хэрэглээ



Эх сурвалжууд: УСХ

Нэгдсэн төсвийн орлого тасалдаж байгаагаас 2015 оны эхний хагас жилийн байдлаар засгийн газрын хэрэглээ өмнөх оны мөн үеэс 4.2 хувиар буурч эдийн засгийн өсөлтөд -0.6 нэгж хувийн нөлөө үзүүлэв. Бүтээгдэхүүний цэвэр татвар эдийн засгийн өсөлтийг бууруулах нөлөөтэй хэвээр байна.

Нийт хөрөнгө оруулалтын хэмжээ 2015 оны эхний хагас жилд өмнөх оны мөн үеэс 36.4 хувиар буурч, эдийн засгийн өсөлтөд 11.8 нэгж хувийн бууруулах нөлөө үзүүлэв. Үндсэн хөрөнгийн хуримтлал буурахад гадаадын шууд хөрөнгө оруулалт сэргэхгүй байгаа, төсвийн хөрөнгө оруулалтын хэмжээ буурсан зэрэг нь нөлөөллөө. Оны үлдсэн хугацаанд энэ байдал үргэлжлэх хандлагатай бөгөөд нийт хөрөнгө оруулалт эдийн засгийн өсөлтийг бууруулах нөлөө үзүүлсэн хэвээр байхаар байна.

Цэвэр экспорт 2015 оны эхний хагас жилд эдийн засгийн өсөлтөд 13.1 нэгж хувийн эерэг нөлөө үзүүлсэн бөгөөд ДНБ-ий бодит өсөлтийг тодорхойлох хамгийн гол эерэг хүчин зүйл хэвээр байна. Мөнгөний агрегатууд, банкны салбарын актив, пассивын өсөлт мэдэгдэхүйц саарсан, Засгийн газрын болон хувийн хэрэглээ буурсан зэрэг үзүүлэлтүүдтэй нийцтэйгээр импорт хурдацтай агшиж байна. Тухайлбал, 2013 онд 6%-иар, 2014 онд 17%-иар буурсан нийт импорт, 2015 оны эхний 8 сард 30%-иар агшаад байна. Импортын барааг бүлгээр авч үзвэл өмнөх оны мөн үетэй харьцуулахад хэрэглээний барааны импорт 20.9 хувиар, хөрөнгө оруулалтын бараа, бүтээгдэхүүний импорт 35.9 хувиар тус тус буурчээ.


4.3 УЛСЫН ТӨСӨВ

Монгол Улс уул уурхайн салбараас хамаарал ихтэй төсөвтэй, ашигт малтмалын олборлох салбараас хэт хамаарсан эдийн засагтай байж ирсэн. Энэ нь дэлхийн зах зээлд түүхий эдийн үнийн уруудах мөчлөг тохиолдсон 2013-2015 онуудад төсвийн алдагдлыг нэмэгдүүлэх, бодлогын орон зайг хязгаарлах, улсын өрийг өсгөх шалтгаан болж, макро эдийн засгийн тэнцвэрийг хангахад бэрхшээл учруулж ирлээ.

Иймд түүхий эдийн өсөлтийн мөчлөг нэгэнт дуусгавар болсон, гадаад эдийн засгийн тодорхой бус байдал үргэлжилсэн, эдийн засаг 2013-2015 онуудад зөөлөн газардсан байгаа энэ цаг үед Монгол Улс 2016 оноос эхлэн төсвийн нэгдмэл бөгөөд зохистой бодлогоор төрийн санхүүгийн бодлого, бүтэцдээ шинэчлэл хийж, улсын төсвийг нэгдмэл, алдагдалгүй, зохистой, бодитой байлгах зайлшгүй шаардлага тулгараад байна.


2015 оны эхний 8 сарын төсвийн гүйцэтгэл: Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн 2015 оны эхний 8 сарын байдлаар 3579 тэрбум төгрөг, нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 4346 тэрбум төгрөгт хүрч, тэнцвэржүүлсэн төсвийн нийт тэнцэл 767 тэрбум төгрөгийн алдагдал хүлээгээд байна.

Зураг 19. Улсын төсвийн орлого, зардал, тэнцэл (тэрбум төгрөгөөр)



Эх сурвалжууд: УСХ, Сангийн яам

Зураг 20. Улсын төсвийн орлого, зардлын жилийн өөрчлөлт (%)



Төсвийн орлого: Төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн 3579 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үеэс 7.0 хувь буюу 263 тэрбум төгрөгөөр буурсан байна. Төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлогыг бүрэлдэхүүн хэсгүүдээр тайлбарлавал татварын орлого (орлогын 85.8 хувийг бүрдүүлсэн) 5 гаруй хувиар, татварын бус орлого 10 орчим

хувиар тус тус буурчээ. 2015 оны эхний 8 сард төсвийн орлого 679 тэрбум төгрөгөөр тасарсан. Үүний 43 хувь нь импорт агшсантай уялдан импортын бараанд ногдуулдаг гааль, НӨАТ-ын орлогын тасалдлаас шууд шалтгаалжээ.

Төсвийн орлогын гүйцэтгэлийн хувь 2013 онд 95 хувь байсан бол 2014 онд 86 хувь, 2015 оны эхний 8 сард 84 хувь болж тасралтгүй буурсаар байна. Энэ нь төсвийн зардлын гүйцэтгэл төлөвлөснөөс 2013 онд 24 хувиар, 2014 онд 25 хувиар, 2015 оны эхний 8 сард 22 хувиар тус тус тасрахад шууд нөлөөлжээ. Макро эдийн засгийн тэнцвэрийг хангахын тулд эдийн засгийн гадаад, дотоод нөхцөл байдалтай нягт уялдсан төсвийн төлөвлөлт хийж, бодитой төсөв баталж байх нь чухал байна.

Төсвийн зардал: 2015 оны эхний 8 сарын байдлаар төсвийн орлого 7 хувиар буурсан байхад төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүн өмнөх оны мөн үеэс 395 тэрбум төгрөгөөр буюу 10 хувиар өсч 4346 тэрбум төгрөгт хүрчээ. Бүрэлдэхүүн тус бүрээр нь тайлбарлавал урсгал зардал 11.4 хувь буюу 371 тэрбум төгрөгөөр өсч 3610 тэрбум төгрөг, хөрөнгийн зардал 0.7 хувь буюу 4.8 тэрбум төгрөгөөр өсч 714 тэрбум төгрөг, эргэж төлөгдөх цэвэр зээл 19.4 тэрбум төгрөгөөр өсч 23 тэрбум төгрөг байв.

Хүснэгт 4. Төсвийн орлого, зардлын тасралт (2015 оны эхний 8 сард)


Орлого, зардлын тасралт	Хэмжээ (тэрбум)	Тасралтад эзлэх хувь
1. Төсвийн орлогын тасралт	679	
1.1 Орлогын албан татвар	72	11%
1.2 АМНАТ	30	4%
1.3 Өмч хувьчлалын орлого	155	23%
1.4 Импортын гаалийн албан татвар	46	7%
1.5 Импортын барааны НӨАТ	235	35%
2. Төсвийн зарлагын тасралт	1 226	
2.1 Урсгал зардал	335	27%
2.2 Хөрөнгийн зардал		
2.2.1 Дотоод эх үүсвэрээрх	792	65%
2.2.2 Гадаад эх үүсвэрээрх	79	6%

Эх сурвалж: Сангийн яам


Төсвийн зардал өсөхөд төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй Хөгжлийн банкны хөрөнгө оруулалтыг нэгдсэн төсөвт тусгахаар заасан нь нөлөөлөв. Төсвийн орлого 679 тэрбум төгрөгөөр тасарсантай уялдан төсвийн зардал төлөвлөснөөс 1226 тэрбум төгрөгөөр тасраад байна. Үүний 65 хувийг дотоод эх үүсвэрээр санхүүжүүлэхээр төлөвлөсөн хөрөнгийн зардлын тасралт, 27 хувийг урсгал зардлын тасралт тус тус тайлбарлаж байна.

Алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэр: 2015 оны эхний 8 сарын байдлаар гадаад зээлийн үндсэн төлбөрт 71.3 тэрбум, дотоод зээлийн үндсэн төлбөрт 5.3 тэрбум, Засгийн газрын богино хугацаат дотоод бондын үндсэн төлбөрт 941.9 тэрбум, урт хугацаат дотоод бондын үндсэн төлбөрт 392.3 тэрбум төгрөгийг тус тус төлж, 87.5 тэрбум төгрөгийн гадаад төслийн зээл авч, Засгийн газрын 1023.8 тэрбум төгрөгийн богино хугацаат дотоод, 375.6 тэрбум төгрөгийн урт хугацаат дотоод, 314.4 тэрбум төгрөгтэй тэнцэх урт хугацаат гадаад бондыг тус тус арилжаалсан гүйцэтгэлтэй байв.

Зураг 21. Төсвийн нийт орлого ба тусламж



Зураг 22. Төсвийн нийт зарлага ба цэвэр зээл



Эх сурвалжууд: Сангийн яам


Хүснэгт 5. Улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэл (2015 оны эхний 8 сард, тэрбум төгрөгөөр)

	2014 I-VIII		2015 I-VIII		I-VIII 2015/2014
	Гүйцэтгэл	Хувийн жин	Гүйцэтгэл	Хувийн жин	
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	3 842	100%	3 579	100%	93%
ТОГТВОРЖУУЛАЛТЫН САН	44	1%	2	0%	5%
НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	3 798	99%	3 577	100%	94%
А. Татварын орлого	3 234	84%	3 068	86%	95%
Орлогын албан татвар	634	17%	640	18%	101%
Нийгмийн даатгалын орлого	600	16%	670	19%	112%
Хөрөнгийн албан татвар	51	1%	57	2%	111%
Нэмэгдсэн өртгийн албан татвар	884	23%	668	19%	76%
Онцгой албан татвар	300	8%	363	10%	121%
Тусгай зориулалтын орлого	7	0%	8	0%	107%
Гадаад үйл ажиллагааны орлого	244	6%	214	6%	88%
Бусад татвар, төлбөр, хураамж	514	13%	449	13%	87%
Б. Татварын бус орлого	564	15%	508	14%	90%
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3 951	100%	4 346	100%	110%
А. УРСГАЛ ЗАРДАЛ	3 239	82%	3 610	83%	111%
Бараа, ажил үйлчилгээний зардал	1 592	40%	1 737	40%	109%
Зээлийн үйлчилгээний төлбөр	245	6%	373	9%	152%
Татаас	115	3%	96	2%	83%
Урсгал шилжүүлэг	1 287	33%	1 404	32%	109%
Б. ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	709	18%	714	16%	101%
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ЦЭВЭР ЗЭЭЛ	3	0%	23	1%	670%
ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	(153)		(769)		503%

Эх сурвалж: Сангийн яам

2015 оны төсвийн хүлээгдэж буй гүйцэтгэл: Эдийн засгийн өсөлт саарч, идэвхжил нь төсөөлж байснаас муудаж, оны эхний 8 сард төсвийн тэнцвэржүүлсэн орлого 679 тэрбум төгрөгөөр дутуу гүйцэтгэлтэй гарав. Эдийн засгийн нөхцөл байдал сайжрахгүй тохиолдолд оны үлдсэн саруудад төсвийн орлого нэмж тасрахаар байна. ТТБТ хуулийн тусгай шаардлагыг хангахын тулд төсвийн орлого дутсан хэмжээгээр төсвийн зардлыг танах шаардлагатай. Хөрөнгө оруулалтын зардал их хэмжээгээр танагдсанаас гадна урсгал зардлыг ч бууруулах хэрэгцээ үүссэн. Өөрөөр хэлбэл оны эхнээс төсвийн орлого 7 хувиар буурсан байгаа өнөө үед оны эцэст хүлээгдэж буй орлогын бууралттай нийцүүлэн төсвийн зардлыг өмнөх оноос бууруулж хумих (зардлын өсөлтийг бууруулах бус зардлыг абсолют дүнгээр нь бууруулах) шаардлага үүсээд байна.

Зураг 24. Инфляцийн төсөөлөл



Эх сурвалж: Монголбанк тооцоолол

Хөрөнгө оруулалтын зогсонги байдал нь эдийн засгийн өсөлт, ажил эрхлэлтэд сөргөөр нөлөөлж өрхийн орлогыг, улмаар 2015 онд хүнсний бус инфляцийг хязгаарлах нөхцөлийг бүрдүүлж байна. Ийнхүү 2016 онд хүнсний инфляци суурь үеийн нөлөөгөөр бага зэрэг өсөхөөр хүлээгдэж байгаа бол хүнсний бус инфляци үргэлжлэн буурах төлөвтэй байна. Төсөөллийн хамрах хугацаанд хөрөнгө оруулалт буурч, ажилгүйдлийн түвшин алгуур нэмэгдэхээр байгаа нь цалингийн өсөлтийг хязгаарлахаар байна.

Хөдөлмөрийн зардал нэмэгдэхгүй, хүнсний бус инфляци үргэлжлэн саарч, төрийн зохицуулалттай болон нийлүүлэлтийн гаралтай инфляцийн дарамт нэмэгдэхгүй тохиолдолд инфляцийн түвшин 2015 онд зорилтот түвшин буюу 7 хувьтай ойролцоо байхаар байна.


4.4.2 Эдийн засгийн өсөлтийн төсөөлөл

Үйлдвэрлэлийн зөрүү 2014 оноос сөрөг болсон хандлага 2015 онд ч хадгалагдаж, эдийн засгийн өсөлт саарахаар хүлээгдэж байна. 2014 оны эдийн засгийн өсөлтийг цэвэр экспорт голлон тодорхойлж байсан. 2015 онд хөрөнгө оруулалт, төсвийн зарлага тус тус буурч худалдааны нөхцөл сайжрахгүй байгаа нь ДНБ-ий өсөлт саарах үндсэн нөхцөл болж байна.

Хөрөнгө оруулалт, дотоод эрэлт буурч, импорт хумигдаж байгаа нь худалдаа, барилга, тээвэр, үйлчилгээний салбарт сөргөөр нөлөөлж, улмаар уул уурхайн бус салбарын өсөлтийг сааруулах эрсдэл дагуулж байна.

Уул уурхайн салбарын үйлдвэрлэл эдийн засгийн өсөлтөд голлох нөлөөг үзүүлэхээр байна. Хэдий Оюу толгойн уурхайн үйлдвэрлэл 2015 оны хоёрдугаар хагаст саарахаар байгаа ч, 2016 онд далд уурхайн хөрөнгө оруулалт эхэлснээр эдийн засгийн өсөлтөд эерэгээр нөлөөлж, 2016 оны сүүл гэхэд ДНБ-ий өсөлт потенциал түвшиндээ хүрэхээр байна.

Зураг 25. ДНБ-ий жилийн өсөлтийн төсөөлөл



Эх сурвалж: Монголбанк тооцоолол

4.4.3. Төсөөллийн тодорхой бус байдал

Эдийн засгийн үнэлгээг өөрчилж болзошгүй тодорхой бус байдал хадгалагдсаар байна. Энэхүү тодорхойгүй байдлыг бий болгож буй дотоод, гадаад хүчин зүйлс, эрсдлийг хураангуйлан авч үзвэл дараах байдалтай байна. Үүнд:

- Цаг агаарын тааламжгүй нөхцөл байдал нь нийлүүлэлтийн гаралтай инфляцийн дарамтыг нэмэгдүүлж болзошгүй байна. Тухайлбал, Хүнс, хөдөө аж ахуйн яамны мэдээлснээр энэ зун бороо хур багатай, нийт нутгийн 40-50 хувь нь гандуу байснаас шалтгаалан ургацын 40 хувийг алдах магадлалтай ажээ.
- Өвөлжилт хүндэрч, зуд турхан болсон нөхцөлд энэ намар махны үнэ үлэмж буурах, харин хавар нь огцом өсөх эрсдэл дагуулж болзошгүй байна.
- Хятадын эдийн засаг саарсан тохиолдолд түүхий эдийн эрэлт буурах, худалдааны нөхцөл муудах, гадаад эрэлт болон ханшийн сулралтаар дамжин эдийн засгийн төсөөллийг муутгаж болзошгүй юм. Хятадын өсөлтийг эс тооцвол бусад гадаад хүчин зүйлсийн тодорхойгүй байдал харьцангуй бага байхаар байна.
- Дотоод тодорхой бус байдлын гол эх сурвалж нь хөрөнгө оруулалтын, тэр дундаа ДНБ-ий 1 хувьтай тэнцэх хэмжээнд болж буурсан гадаадын шууд хөрөнгө оруулалтын хүчин зүйл байхаар байна. Таван толгой төслийн ирэх оны хөрөнгө оруулалт, энэ оны төсвийн хөрөнгө оруулалт төлөвлөгөөний дагуу хийгдэх эсэх нь уул уурхайн болон уул уурхайн бус хөрөнгө оруулалтын тодорхой бус байдлыг нэмэгдүүлэхээр байна.


4.5. МӨНГӨНИЙ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

4.5.1. Мөнгөний нийлүүлэлт

Мөнгө, зээлийн өсөлт 2014 оны эхнээс саарч байна. Гадаад валютын орох урсгал, түүний дотор гадаадын шууд хөрөнгө оруулалт буурснаар гадаад актив өсөхгүй байна. Монголбанкны мөнгөний уламжлалт бус бодлогын хүрээнд дунд хугацаа (3 жил)-нд хэрэгжүүлсэн хөтөлбөрийн зээл хуваарийн дагуу эргэн төлөгдсөөр байгаа нь мөнгөний нийлүүлэлтийн өсөлт саарах, мөнгөний нийлүүлэлт буурахад нөлөөлж байна. Улсын төсөвтэй адилтгах Хөгжлийн банкны санхүүжилтүүд мөн буурч байна. Гадаад секторын эрсдэлтэй, тодорхой бус нөхцөл байдал үргэлжилсээр байгаа нь санхүүгийн зуучлалын өртөг нэмэгдэхэд нөлөөлж байна. Зээлийн эрэлт болон нийлүүлэлт хумигдаж байгаа нь мөнгө, зээлийн үзүүлэлтүүд буурах үндсэн шалтгаан болов.


Хэрэв гадаад валютын орох урсгал нэмэгдэхгүй, түүний дотор экспортын орлого, гадаадын шууд хөрөнгө оруулалт, гадаад зээллэгээний боломжууд дорвитой өсөхгүй, төлбөрийн тэнцлийн алдагдалгүй байх нөхцөлийг хадгалахгүй буюу макро эдийн засгийн гадаад тэнцвэрийг хадгалж чадахгүй, ГЦА өсөхгүй, улсын төсөв их хэмжээний алдагдалтай хэвээр байх тохиолдолд мөнгөний нийлүүлэлтийг ДЦА-аар дамжуулж нэмэгдүүлэх орон зай хязгаарлагдмал байх бөгөөд энэ нь төгрөгийн гадаад валюттай харьцах ханшин дээр нэмэлт ачаалал өгөх эрсдэл дагуулахаар байна.

Зураг 26. M2 мөнгөний өсөлт, бүрэлдэхүүнээр / актив/



Эх сурвалжууд: Монголбанк

Зураг 27. M2 мөнгөний өсөлт, бүрэлдэхүүнээр / пассив/



Хүснэгт 7. Мөнгөний үзүүлэлтүүд 2014-2016 он (тэрбум төгрөгөөр)*

Мөнгөний тойм	2014				2015				2016				
	Q1	Q2	Q3	Q4	Q1	Q2	8 сар	Q3	Q4	Q1	Q2	Q3	Q4
	Гүйцэтгэл				Гүйцэтгэл				Төсөөлөл				
M2 мөнгө	9949	10107	10074	10636	9904	10041	9964	9651	9849	9678	10258	10479	10959
M1 мөнгө	1737	1862	1836	1817	1446	1664	1682	1620	1654	1625	1722	1759	1840
Банкнаас гадуурх мөнгө	550	571	536	499	391	431	449	435	444	436	462	472	494
Харилцах ₮	1188	1291	1300	1317	1056	1234	1233	1186	1210	1189	1260	1287	1346
Бараг мөнгө	8212	8245	8238	8819	8458	8377	8282	8031	8195	8053	8536	8719	9119
Бусад цэвэр зүйл	-411	-1111	-1129	-1187	-1252	-2156	-1987	-1382	-1419	-1418	-1429	-1441	-1451
Дотоод цэвэр актив	9460	10792	11046	12338	12952	13040	13180	13246	14182	14775	15853	15924	16731
Дотоодын цэвэр зээл	11394	12698	13123	13982	14474	14104	14411	14648	15113	15706	16787	17360	17573
ЗГ-ын цэвэр зээл	-646	-257	-336	3	312	453	647	845	1123	1250	1471	1502	1507
Банк бусаас авах авлага	12040	12954	13460	13979	14162	13651	13764	13803	13990	14456	15316	15858	16066
Үүнээс зээл	11381	12302	12612	12503	12271	11948	11841	11618	11155	11641	12521	13083	13312
Бусад санхүүгийн байгууллагаас авах авлага	659	652	848	1476	1890	1704	1923	2185	2835	2815	2795	2775	2755
Үүнээс ИЗББ	282	273	465	744	1134	1108	1361	1585	2150	2130	2110	2090	2070
Бусад цэвэр зүйл	-1934	-1906	-2077	-1644	-1522	-1064	-1231	-1402	-931	-931	-933	-1436	-842
Төв банк													
Нөөц мөнгө	3127	2882	2827	3502	2469	2352	2825	2702	2789	2595	2728	2903	3053
Дотоод цэвэр актив	1380	2227	2721	3382	3652	2758	3487	3850	4576	5148	5750	5742	6192
ЗГ-ын цэвэр зээл		-853	-677	-572	-496	-542	-327	-283	-227	-196	-164	-133	-223
Хөгжлийн банкны цэвэр зээл	170	169	-133	63	165	0	0	371	232	186	127	67	27
Банкинд олгосон зээл	3020	2914	2744	2608	1797	1907	1576	972	947	559	845	1001	1559
Банк бусаас авах авлага	489	482	678	1306	1725	1704	1923	2165	2751	2744	2730	2676	2670
Хасах нь: ТБҮЦ	1103	854	602	854	385	1151	511	279	155	-828	-1178	-1087	-1108
Бусад цэвэр зүйл	53	369	711	832	846	840	826	903	1028	1027	1035	1043	1051
Меморандум үзүүлэлтүүд:													
M2 мөнгөний жилийн өөрчлөлт (%)	36.3	26.3	18.8	12.4	-0.5	-0.7	-1.7	-4.2	-7.4	-2.3	2.2	8.6	11.3
Нөөц мөнгөний жилийн өөрчлөлт (%)	26.7	-17.9	-4.0	5.0	-21.1	-18.4	0.4	-4.4	-18.6	5.1	16.0	7.4	9.4
M2 мөнгөний үржүүлэгч (нэгжээр)	3.18	3.51	3.56	3.04	4.01	4.27	3.53	3.57	3.53	3.73	3.76	3.61	3.59
(Зээл+ИЗББ) жилийн өөрчлөлт (%)	58.2	46.4	29.3	20.2	15.6	8.8	3.8	2.1	2.0	3.9	10.7	15.7	16.9
(Зээл+ИЗББ)/M2 мөнгө	1.21	1.28	1.34	1.31	1.43	1.36	1.38	1.43	1.42	1.49	1.49	1.51	1.47
(Зээл+ИЗББ)/ДНБ	0.61	0.63	0.63	0.64	0.63	0.60	0.60	0.60	0.60	0.61	0.63	0.64	0.63
Мөнгөний эргэлтийн хурд	2.25	2.17	2.21	2.16	2.20	2.26	2.29	2.30	2.33	2.39	2.44	2.49	2.55
Нэрлэсэн ДНБ /тэрбум төгрөг/	19803	20508	21476	21975	22370	22747	22950	23052	23180	23704	24239	24787	25347
Бодит ДНБ-ий өсөлт (%)	7.2	8.9	9.9	5.1	4.3	2.1		-0.6	1.3	3.1	4.5	3.2	8.6
Жилийн дундаж инфляци (%)	12.0	13.8	14.3	11.6	8.9	7.8		7.2	7.3	8.2	7.8	7.1	6.7

Эх сурвалж: Монголбанк

*Зах зээлийн хүлээлтэд сөрөг нөлөөлж болзошгүй зарим үзүүлэлтийн төсөөллийг мөнгөний үзүүлэлтүүдийн хүснэгтэд оруулаагүй болно.


Эдийн засгийн нөхцөл байдалтай уялдан банкууд зээл олголтыг цаашид хумина гэж үзвэл 2015 оны эцэст M2 мөнгө 7.4%-иар буурах, МИК рүү шилжүүлсэн орон сууцны ипотекийн зээлийг оруулж тооцвол зээлийн жилийн өсөлт 2%-д хүрч саарах төлөвтэй байна. 2015 оны эцэст M2 мөнгөний өөрчлөлтөд ДЦА +17 нэгж хувийн, харин ГЦА -25 нэгж хувийн нөлөөг үзүүлэхээр байна. 2016 онд Оюу толгойн далд уурхайн хөрөнгө оруулалт хийгдвэл ИЗББ-г оруулж тооцсон зээл 3.3%-иар, M2 мөнгөний нийлүүлэлт 11.3%-иар тус тус өсөхөөр байна.

4.5.2. Мөнгөний зах, хүүний түвшин

Мөнгөний бодлогын хүү нь банк хоорондын зах (БХЗ)-ын хүүгээр дамжин банкны зээлийн болон хадгаламжийн хүү, улмаар бодит үйлдвэрлэл, инфляцид нөлөөлдөг.


Бодлогын хүү нь ТБҮЦ-ны анхдагч захын арилжааны суурь болж, улмаар БХЗ дээрх банкуудын хөрөнгө оруулалтын хөтөч хүү болдог. Монголбанк богино хугацаат хүүний хэлбэлзлийг бууруулж хүүний сувгийн нөлөөг сайжруулах үүднээс 2013 онд хүүний тэгш хэмт коридорыг нэвтрүүлсэн бөгөөд үүнтэй холбоотойгоор БХЗ-ын хүүний хэлбэлзэл сүүлийн 3 жилд буурч, бодлогын хүүтэй ойролцоо түвшинд байна.

Зураг 28. БХЗ-ын жигнэсэн дундаж хүү



Эх сурвалжууд: Монголбанк

Зураг 29. Банк хоорондын захын арилжааны хэмжээ /тэрбум төгрөг/




БХЗ-ын жигнэсэн дундаж хүү 2015 оны 8 дугаар сард 13.7 хувь болж, оны эхнээс 1.5 нэгж хувиар өссөн нь бодлогын хүүний өсөлтөөс гадна банкны системд төгрөгийн эх үүсвэр хомсдолтой байгаатай холбоотой юм. БХЗ-ын хүүг хэлцлийн төрлөөр авч үзвэл репо санхүүжилтийн хүү 13.1, овернайт зээлийн хүү 14.3, ТБҮЦ-ны хоёрдогч захын арилжааны хүү 13.0, банк хоорондын хадгаламжийн хүү 13.6 хувь байна.

БХЗ-ын арилжааны сарын дундаж хэмжээ 2012 онд 348.1 тэрбум, 2013 онд 417.4 тэрбум, 2014 онд 1021.7 тэрбум болж нэмэгдсэн бол 2015 оны эхний 7 сарын байдлаар 931.3 тэрбум төгрөг байсан байна. Банкуудын төгрөгийн нөөц буурч байна.


Монголбанк 2014 оны дунд үеэс эхлэн макро эдийн засгийн тэнцвэрийг дэмжих чиглэлд мөнгөний бодлогын төлвийг өөрчилсөн. Монголбанкны Мөнгөний бодлогын зөвлөлөөс 2015 онд төгрөгийн өгөөжийг нэмэгдүүлэх, төлбөрийн тэнцлийн хүндрэлийг зөөлрүүлэх, инфляцийг эрчимжүүлэхгүй байлгах зорилгоор 1 дүгээр сард бодлогын хүүг 1.0 нэгж хувиар нэмэгдүүлэн 13.0%, 4 болон 7 дугаар сард энэ түвшинд нь хадгалахын зэрэгцээ банкны зохистой харьцаанд зарим өөрчлөлт оруулж шаардлагатай бодлогын арга хэмжээг авсан.

2015 оны 8 дугаар сарын байдлаар банкуудын төгрөгийн хадгаламжийн дундаж хүү 13.0%, харин зээлийн хүү 19.1% хувь байна. Оны эхнээс төгрөгийн хадгаламжийн хүү 0.5 нэгж хувиар, харин зээлийн хүү 2.2 нэгж хувиар нэмэгдсэн нь мөнгөний уламжлалт бус бодлогын хүрээнд дунд хугацаанд хэрэгжүүлсэн Монголбанкны хөтөлбөрүүдийн зээлийн хэмжээ буурч байгаатай шууд холбоотой юм. Банкуудын валютын хадгаламжийн хүү 6.5 хувь, валютын зээлийн хүү 12.3 хувь байна.

Зураг 30. Засгийн газрын үнэт цаасны хүү



Зураг 31. Хадгаламж, зээлийн хүү



Эх сурвалжууд: Монголбанк


Богино хугацаат (1 жил хүртэлх) засгийн газрын үнэт цаас (ЗГҮЦ)-ны анхдагч болон хоёрдогч зах дээрх хүү 2014 оны сүүлийн хагаст 14.7-16.7% байсан бол 2015 оны 8 дугаар сарын байдлаар эрэлт буурсантай холбоотойгоор оны эхнээс 0.7-2.4 нэгж хувиар буураад байна. Урт хугацаат (1 жилээс дээш) ЗГҮЦ-ны хэлцлүүд сүүлийн 10 сард төдийлөн хийгдээгүй нь хөрөнгийн зах дээр хөрвөх чадвар сайнгүй байгааг илтгэж байна.

4.5.3. Төгрөгийн гадаад валюттай харьцах ханш

Төлбөрийн тэнцлийн урсгал дансны алдагдал сүүлийн жилүүдэд тогтвортой буурч 2015 оны эхний 7 сарын байдлаар 410.2 сая ам.долларт хүрч, хөрөнгө, санхүүгийн дансны ашиг 661.0 сая ам.доллар болж харьцангуй нэмэгдсэнээр төлбөрийн нийт тэнцэл 82 сая ам.долларын ашигтай буюу эдийн засаг оны эхнээс валютын цэвэр орох урсгалтай байна. Энэ хугацаанд Монголбанк зах зээлд төгрөгийн гадаад валюттай харьцах ханш огцом хэлбэлзэх эрсдэл үүссэн тухай бүр валютын захад оролцох замаар ханшийн огцом хэлбэлзлийг зөөлрүүлсэн. Төгрөгийн гадаад валюттай харьцах ханш 2015 оны 8 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 1,991.49 төгрөгт хүрч, оны эхнээс 5.21 хувиар суларсан хэдий ч, ханшийн дундаж хэлбэлзэл өмнөх онтой харьцуулахад буурсан байна.


Монголбанкнаас 7 хоног бүрийн Мягмар, Пүрэв гарагт гадаад валютын дуудлага худалдаа зохион байгуулж, шаардлагатай үед валютын захад ам.доллар болон юань нийлүүлж байгаа бөгөөд Монголбанкны оролцооны үр дүнд 2015 оны 8 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар төгрөгийн ам.доллартай харьцах ханш нэг өдөрт хамгийн ихдээ 0.68%-иар чангарч, 0.87%-иар суларч, нэг өдөрт ногдох дундаж хэлбэлзэл нь 0.16%-тай тэнцүү байна. Мөн энэ хугацаанд ханшийн өдрийн хэлбэлзэл нийт өдрийн 90%-д нь $\pm 0.4\%$ дотор, үлдсэн 10%-д нь хамгийн ихдээ 0.87%-иар хэлбэлзжээ. Ханшийн нэг өдөрт ногдох дундаж хэлбэлзэл 0.16% байгаа нь 2014 оны мөн үетэй харьцуулбал 0.02%-иар буурчээ.

Зураг 32. Төгрөгийн ам.доллартай харьцах Монголбанкнаас зарласан ханш



Эх сурвалжууд: Монголбанк

Зураг 33. Ханшийн өдрийн хэлбэлзлийн хистограм




4.6. ТӨЛБӨРИЙН ТЭНЦЭЛ, ГАДААД ЗАХ ЗЭЭЛ

4.6.1. Төлбөрийн тэнцэл

2015 оны эхний 7 сарын урьдчилсан гүйцэтгэлээр төлбөрийн тэнцлийн урсгал дансны алдагдал өмнөх оны мөн үеэс 69.0 хувиар буурч -410.2 сая ам.доллар, хөрөнгө ба санхүүгийн дансны ашиг 58.0 хувиар нэмэгдэж 661.0 сая ам.долларт хүрснээр нийт төлбөрийн тэнцэл 82.3 сая ам.долларын ашигтай гарсан нь өнгөрсөн оны мөн үеэс 1017.5 сая ам.доллараар сайжирсан үзүүлэлт юм.


Урсгал данс. Урсгал дансны алдагдал буурахад барааны гадаад худалдааны ашиг 2015 оны эхний 7 сарын байдлаар өмнөх оны мөн үеэс 12 дахин буюу 748.9 сая ам.доллараар нэмэгдэж, үйлчилгээний гадаад худалдааны алдагдал 43 хувиар буюу 415.6 сая ам.доллараар буурсан нь голчлон нөлөөлжээ.

Зураг 34. Төлбөрийн тэнцэл



Эх сурвалжууд: Монголбанк

Зураг 35. Урсгал тэнцэл




Барааны экспорт энэ оны эхний 8 сард 9 хувиар буюу 324.7 сая ам.доллараар буурсан боловч импорт 29 хувиар буюу 1048.0 сая ам.доллараар хумигдсан нь барааны гадаад


худалдааны ашиг нэмэгдэх үндсэн шалтгаан болов. Тухайлбал, оны эхний 8 сард зэсийн баяжмал, боловсруулаагүй болон хагас боловсруулсан алтны экспорт нэмэгдсэн хэдий ч, түүхий эдийн үнийн бууралттай холбоотойгоор өмнөх оны мөн үетэй харьцуулахад боловсруулаагүй нефтийн экспорт 41 хувиар буюу 179.8 сая ам.доллараар, төмрийн хүдрийн экспорт 48 хувиар буюу 138.8 сая ам.доллараар, нүүрсний зах зээлийн өрсөлдөөн нэмэгдэж эрэлт буурсантай холбоотойгоор чулуун нүүрсний экспорт 32 хувиар буюу 186.8 сая ам.доллараар тус тус буурсан нь экспортын орлого буурахад нөлөөлжээ. Харин макро тэнцвэрийг хангах бодлогын нөлөө, эдийн засгийн идэвхжил саарч буй хандлага, нийт эрэлт хумигдсан нөхцөл байдал, уян хатан тогтож буй ханш, хөрөнгө оруулалтын орох урсгал татарсан, нефтийн үнэ буурсан зэрэгтэй уялдан барааны нийт импорт буурах хандлага үргэлжилж байна. Тодруулбал, оны эхний 8 сард хэрэглээний импорт өмнөх оны мөн үеэс 21 хувиар буюу 193 сая ам.доллараар, хөрөнгө оруулалтын барааны импорт 36 хувиар буюу 543 сая ам.доллараар, нефтийн импорт 36 хувиар буюу 270 сая ам.доллараар тус тус буурчээ.

Манай орны урсгал тэнцлийн алдагдал 2009 он хүртэл харьцангуй тогтвортой бага түвшинд буюу дунджаар ДНБ-ий 6 хувьтай тэнцүү хэмжээнд байсан бол 2010 оноос эхлэн огцом өсч, 2010 онд ДНБ-ий 12 хувь, 2011 болон 2012 онд 27 хувь, 2013 онд 25 хувьд тус тус хүрсэн. Харин барааны гадаад худалдаа ашигтай гарч эхэлснээс шалтгаалан урсгал тэнцлийн алдагдлын ДНБ-д эзлэх хувь 2014 онд 12 хувь, 2015 оны эхний хагас жилийн байдлаар 6 хувьд хүрч буураад байна.

Зураг 36. Барааны гадаад худалдаа



Зураг 37. Үйлчилгээний гадаад худалдаа



Эх сурвалж: Монголбанк

Үйлчилгээний гадаад худалдааны алдагдал буурлаа. Үйлчилгээний гадаад худалдааны орлого өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 10 хувиар буюу 34.4 сая ам.доллараар өсч, зардал 29 хувиар буюу 381.2 сая ам.доллараар буурснаас шалтгаалан үйлчилгээний дансны алдагдал 43 хувиар буюу 415.6 сая ам.доллараар буурав. Үүнд импортын барааны бууралтаас шалтгаалан тээврийн зардлын гарах урсгал 116.4 сая ам.доллараар, томоохон уул уурхайн компаниудын гадаадаас авсан бизнесийн удирдлагын зөвлөх үйлчилгээний зардлын бууралттай холбоотойгоор бусад үйлчилгээний зардал 227.7 сая ам.доллараар тус тус буурсан нь голчлон нөлөөлжээ.

Орлогын дансны алдагдал тогтвортой. Монгол Улсын аж ахуйн нэгж байгууллагуудад ажиллаж буй харьяат бус иргэдэд төлсөн цалин хөлс болон түүнтэй адилтгах орлого өнгөрсөн оны мөн үеэс 58 хувиар буурч 29.2 сая ам.доллар болсон хэдий ч, Монгол Улсын Засгийн газар, хувийн хэвшлийн аж ахуйн нэгж байгууллага, иргэдийн эдийн засгийн харьяат бусаас авсан гадаад зээл, өрийн бичиг болон харилцах, хадгаламжийн хүүгийн төлбөр, ногдол ашгийн төлбөр 60 хувиар буюу 277.8 сая ам.доллараар нэмэгдсэнээр орлогын дансны алдагдал цэвэр дүнгээр 48 хувиар өсч 761.3 сая ам.долларт хүрэв.

Урсгал шилжүүлгийн данс цэвэр дүнгээр буурчээ. Гадаадын улс орнууд руу шилжүүлсэн хувийн гуйвуулга, олон улсын байгууллагын гишүүнчлэлийн зардлын дүн өмнөх оны мөн үеэс 23.4 сая ам.доллараар буурсан боловч гадаад улс орнуудад ажиллаж, амьдарч буй иргэдээс хүлээн авсан гуйвуулга, гадаадын Засгийн газар, олон улсын байгууллагын шилжүүлсэн хандив тусламжийн дүн 27.1 сая ам.доллараар багассан нь урсгал шилжүүлгийн дансны ашиг цэвэр дүнгээр 4 хувиар буурч 92.5 сая ам.долларт хүрэхэд нөлөөлжээ.

Хөрөнгө, санхүүгийн дансны ашиг нэмэгдэв. 2015 оны эхний 7 сарын урьдчилсан гүйцэтгэлээр хөрөнгө ба санхүүгийн дансны ашиг өмнөх оны мөн үеэс 47 хувиар өсч 614.1 сая ам.долларт хүрэв. Үүнд гадаадын шууд хөрөнгө оруулалт үргэлжлэн буурч 143.8 сая ам.долларт хүрсэн боловч багцын хөрөнгө оруулалт өмнөх оны мөн үеэс 63 хувиар буюу 240.8 сая ам.доллараар нэмэгдсэн, бусад хөрөнгө оруулалтын дансны алдагдал мөн адил 63 хувиар буюу 284.5 сая ам.доллараар буурсан нь голчлон нөлөөлсөн байна. Гадаадын шууд хөрөнгө оруулалтын бууралт нь томоохон компаниуд гадаадын хөрөнгө оруулагчдаасаа авсан зээлийг эргэн төлсөн болон шинээр хийгдэх хөрөнгө оруулалт буурсантай холбоотой.

Монгол Улсын Засгийн газар 2015 оны 6 дугаар сард 165 сая ам.доллартай тэнцэх хэмжээний юанийн бондыг, Худалдаа хөгжлийн банк 2015 оны 5 дугаар сард 500 сая ам.долларын бондыг тус тус олон улсын зах зээлд арилжаалснаар багцын хөрөнгө оруулалт энэ оны эхний 7 сард 623.4 сая ам.долларт хүрч өмнөх оны мөн үеэс 240.8 сая ам.доллараар өссөн байна. Түүнчлэн томоохон аж ахуйн нэгжүүдийн гадаад дансны үлдэгдэл буурсан, үндэсний мөнгөн тэмдэгт харилцан солилцох своп хэлцэлтэй холбоотойгоор бэлэн мөнгө, харилцах дансны алдагдал 298.3 сая ам.доллараар буурснаас шалтгаалан бусад хөрөнгө оруулалтын дансны алдагдал өмнөх оны мөн үеэс 63 хувиар буурч 166.1 сая ам.долларт хүрсэн байна.

Зураг 38. Хөрөнгө, санхүүгийн данс



Эх сурвалж: Монголбанк

Зураг 39. Гадаад валютын нөөц



Гадаад валютын албан нөөц. 2015 оны эхний 7 сард төлбөрийн нийт тэнцэл ашигтай гарснаас шалтгаалан гадаад валютын улсын нөөцийн хэмжээ нэмэгдсэн ба 2015 оны 8 дугаар сарын эцсийн байдлаар 1728.7 сая ам.долларт хүрч, оны эхнээс 5 хувиар нэмэгдсэн байна. Энэ нь сүүлийн гурван сарын дунджаар тооцсон валютын төлбөртэй барааны импортын 5.6 сарын хэрэгцээг хангахаар байгаа нь олон улсын жишиг доод түвшин болох 3 сарын үзүүлэлтээс дээш хэвээр байна.

Шигтгээ 2. Судалгааны үр дүнгээр төлбөрийн тэнцлийн бэлэн мөнгө, харилцах дансанд тохиргоо хийх нь

Төлбөрийн тэнцлийн статистикийн бусад хөрөнгө оруулалтын дансны бэлэн мөнгө, харилцах данс (актив, пассив талд) нь Монгол Улсаас бэлэн болон бэлэн бус хэлбэрээр цэврээр орж, гарч буй бүх валютыг (албан нөөцөөр дамжин хийгдэж байгаагаас бусад) бүртгэдэг буюу капиталын урсгалыг харуулдаг чухал дансуудын нэг юм.

Хөгжиж буй улсуудын нийгэм, эдийн засгийн байдал, банк, санхүүгийн байгууллагуудын хөгжил зэргээс шалтгаалан тухайн улсын иргэд, ААНБ нь эдийн засгийн харилцаанд бэлэн валют хэрэглэх хандлагатай байдаг бөгөөд манайд ч энэ харьцаа өндөр байдаг. Тухайлбал, манай арилжааны банкуудаас зөвхөн 2013 онд гэхэд цэвр дүнгээр 991.4 сая ам.доллар буюу ДНБ-ий 8.0%-тай тэнцэх хэмжээний бэлэн мөнгө дотоодын зах буюу иргэд, ААНБ руу шилжсэн байна. Тус дүнг төлбөрийн тэнцэлд тусгахдаа бүхэл дүнгээрээ иргэд, аж ахуйн нэгжээр дамжин Монгол Улсын хилээр гардаг гэж таамагладаг хэдий ч, зарцуулалтын талаар Монгол Улсын хэмжээнд нэгдсэн судалгаа, мэдээлэлгүй байна. Өөрөөр хэлбэл, дээрх дүнгийн хэдий хэмжээ нь аялал жуулчлалын зорилгоор эсвэл үүргийн худалдааны зорилгоор гарч байгаа нь тодорхойгүй байдаг нь төлбөрийн тэнцлийн давхар бүртгэлийн зарчимд нийцдэггүйгээс шалтгаалан энэ төрлийн бүртгэлийг төлбөрийн тэнцэлд тусгахад хүндрэл үүсдэг. Түүнчлэн дотоодын валютын зах дээр тодорхой хэмжээний валют эргэлдэж байдаг тул дээрх таамаглал нь бодит байдалтай төдийлөн нийцтэй биш юм.

Зураг 40. Монгол Улсын бэлэн, бэлэн бус валютын урсгалын схем



Иймд 2012-2014 онд хийгдсэн түүвэр судалгааны өгөгдлийг ашиглан мэдээллийн эх сурвалжийг нэмэгдүүлснээр, бэлэн мөнгө ба харилцах дансны актив, пассивын гүйцэтгэл, ялангуяа бэлэн валютын урсгалд нэлээдгүй өөрчлөлт оруулах тооцоо судалгааг Монголбанкны зүгээс ОУВС-гийн “Төлбөрийн тэнцлийг боловсруулах 6 дугаар аргачлал”-ын дагуу хийж гүйцэтгэн олон нийтэд мэдээлэхэд бэлэн болоод байна.

Тус тооцоо судалгаагаар төлбөрийн тэнцлийн бараа, үйлчилгээний гадаад худалдаатай холбоотой дараах бэлэн валютын зарцуулалтуудыг тооцоолж бэлэн мөнгө харилцах дансанд тусгах нь зүйтэй гэж үзсэн. Үүнд:

- Гаалийн статистикт бүртгэгддэггүй 3 сая төгрөгөөс доош үнэлгээтэй барааг Монголбанкнаас 2012, 2013 онуудад хийсэн “Бэлэн валютын судалгаа”-нд үндэслэн төлбөрийн тэнцэл, барааны данс болон бэлэн мөнгө ба харилцах дансанд тохируулга хийх,
- 2004, 2012 онуудад хийсэн гадаадын жуулчдын Монгол Улсад зарцуулсан дундаж зардлын судалгаа, 2005, 2014 онуудад гүйцэтгэсэн Монголын жуулчдын гадны улсад зарцуулсан дундаж зардлын судалгаа, 2012, 2013 оны эмчилгээний болон боловсролын зорилготой хувийн аяллын зардлыг тооцох судалгаануудын үр дүнгээр аяллын зорилгоор зарцуулагдсан бэлэн валютын дүнг тооцоолон төлбөрийн тэнцэлд тусгах,
- 2014 онд хийсэн “Иргэд, ААНБ-ын бэлэн валютын судалгаа”-нд үндэслэн банкны системээс дотоод зах руу гарсан бэлэн валютын таамаг тооцоог шинэчлэх.


Дээрх болон үнэлгээ, хамрах хүрээг нэмэгдүүлсэн бусад тооцооллуудыг тусгаснаар бэлэн мөнгө ба харилцах дансны активын гүйцэтгэл 2011 онд 1,687 сая, 2012 онд 1,759 сая, 2013 онд 685 сая, 2014 онд 485 сая ам.доллараар тус тус буурахаар байна.

Ийнхүү тооцоо судалгаануудын үр дүн нь төлбөрийн тэнцэлд өндөр дүнгээр нөлөөлөхөөр байгаа тул тооцоо, судалгаа тогтмолжуулан, холбогдох төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтрах, улмаар Монгол Улсын хэмжээнд нэгдсэн мэдээллийн санг бүрдүүлэх шаардлагатай байгааг харуулж байна.

Зураг 41. Судалгаануудын үр дүнг ашигласнаар БМХ актив дансанд гарах өөрчлөлт (сая \$)



Зураг 42. Бэлэн валютын зарцуулалт (сая \$)



4.6.2 Монгол Улсын гадаад хөрөнгө оруулалтын позиц

Монгол Улсын гадаад хөрөнгө оруулалтын позиц (цэвэр) 2015 оны 2-р улирлын эцэст -24.3 тэрбум ам.доллар болов. Энэ нь гадаадын шууд хөрөнгө оруулалт болон бусад хөрөнгө оруулалт, ялангуяа томоохон компаниудын хөрөнгө оруулагчаасаа авсан зээлээс голлон шалтгаалж байна.

Хүснэгт 8. Монгол Улсын гадаад хөрөнгө оруулалтын позиц

/2015 оны 2-р улирлын байдлаар, тэрбум \$ /

/тэрбум ам.доллар/


А. ГАДААД АКТИВ		Б. ГАДААД ПАССИВ	
1. Шууд хөрөнгө оруулалт (гадаад руу)	0.4	6. Шууд хөрөнгө оруулалт (гадаадаас)	16.7
1.1 Хувь нийлүүлсэн хөрөнгө оруулалт	0.4	6.1 Хувь нийлүүлсэн хөрөнгө оруулалт	6.2
1.2 Бусад хөрөнгө	0.0	6.2 Бусад хөрөнгө	10.5
2. Багцын хөрөнгө оруулалт	0.3	7. Багцын хөрөнгө оруулалт	3.6
2.1 Хөрөнгийн хувьцаа	0.2	7.1 Хөрөнгийн хувьцаа	0.1
2.2 Өрийн бичиг	0.1	7.2 Өрийн бичиг	3.5
3. Санхүүгийн дериватив	0.0	8. Санхүүгийн дериватив	0.0
4. Бусад хөрөнгө оруулалт	1.3	9. Бусад хөрөнгө оруулалт	7.7
4.1 Худалдааны зээл	0.6	9.1 Худалдааны зээл	0.5
4.2 Зээл	0.1	9.2 Зээл	5.2
4.2.1 Төв банк	0.0	9.2.1 Төв банк	0.1
4.2.2 Засгийн газар	0.0	9.2.2 Засгийн газар	2.1
4.2.3 Банк санхүүгийн байгууллага	0.1	9.2.3 Банк санхүүгийн байгууллага	0.9
4.2.4 Аж ахуйн нэгж	0.0	9.2.4 Аж ахуйн нэгж	2.2
4.3 Бэлэн мөнгө ба харилцах	0.6	9.3 Бэлэн мөнгө ба харилцах	1.9
4.4 Бусад актив	0.0	9.4 Бусад пассив	0.1
5. Нөөц актив	1.7	В. ПОЗИЦ	(24.3)
5.1 Мөнгөжсөн алт	0.1	10. Шууд хөрөнгө оруулалт (цэвэр)	(16.4)
5.2 Зээлжих тусгай эрх	0.1	11. Багцын хөрөнгө оруулалт (цэвэр)	(3.3)
5.3 ОУВС-д байршуулсан хөрөнгө (цэвэр)	0.0	12. Санхүүгийн дериватив (цэвэр)	(0.0)
5.4 Бэлэн валют ба харилцах	1.3	13. Бусад хөрөнгө оруулалт (цэвэр)	(6.4)
5.5 Үнэт цаас	0.3	14. Нөөц актив	1.7
5.6 Санхүүгийн дериватив (цэвэр)	0.0		
5.7 Бусад нөөц актив	0.0		

Эх сурвалж: Монголбанк


Гадаад актив. Монгол Улсаас эдийн засгийн харьяат бус этгээдэд оруулсан хөрөнгө оруулалтын дүн 2015 оны 2 дугаар улирлын байдлаар 3.7 тэрбум ам.доллар байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад энэхүү үзүүлэлт нь 17 хувиар буюу 0.5 тэрбум

ам.доллараар нэмэгдсэн бөгөөд үүнд нөөц болон шууд хөрөнгө оруулалтын активын өсөлт голлох нөлөөг үзүүлжээ. Нийт гадаад активын 46 хувийг гадаад валютын улсын нөөц, 35 хувийг бусад хөрөнгө оруулалт, 9 хувийг багцын хөрөнгө оруулалт, үлдсэн 10 хувийг шууд хөрөнгө оруулалтын активууд тус тус бүрдүүлж байна.

Зураг 43. Гадаад актив



Зураг 44. Гадаад пассив



Эх сурвалжууд: Монголбанк

Гадаад пассив. Монгол Улсын эдийн засгийн харьяатад гадаадаас оруулсан хөрөнгө оруулалтын дүн 28.0 тэрбум ам.долларт хүрчээ. Энэ нь өнгөрсөн мөн үеэс 8 хувиар буюу 2.1 тэрбум ам.доллараар өссөн үзүүлэлт бөгөөд үүнд бусад хөрөнгө оруулалт болон багцын хөрөнгө оруулалтын өсөлт нь голлох нөлөөг үзүүлсэн. Нийт гадаад пассивын 60 хувийг гадаадын шууд хөрөнгө оруулалт, 27 хувийг бусад хөрөнгө оруулалт, үлдсэн 13 хувийг багцын хөрөнгө оруулалтын пассив тус тус эзэлж байна. Монгол Улс дахь гадаадын шууд хөрөнгө оруулалтын 63 хувь буюу 10.5 тэрбум ам.долларыг толгой компаниас авсан зээл, 37 хувийг буюу 6.2 тэрбум ам.долларыг хувь нийлүүлэгчийн дүрмийн сан дахь хөрөнгө оруулалт тус тус эзэлж байна.

4.6.3. Монгол Улсын нийт гадаад өр

Монгол Улсын нийт гадаад өрийн үлдэгдэл 2015 оны 2-р улирлын байдлаар 21.7 тэрбум ам.долларт хүрч өнгөрсөн оны мөн үеэс 9 хувиар буюу 1.8 тэрбум ам.доллараар өссөн байна. Энэхүү өсөлтөд банкны салбарын гадаад зээлийн өсөлт болон Төв банкны гадаад өглөг голчлон нөлөөлж байна. Нийт гадаад өрийн үлдэгдэл 21.7 тэрбум ам.долларын 10.5 тэрбум ам.доллар (48.4 хувь нь) нь аж ахуйн нэгж, байгууллагуудын гадаадын хөрөнгө оруулагчаас авсан зээл буюу эдийн засгийн харьяат бус толгой компаниудаас эдийн засгийн харьяат охин компаниудад оруулсан хөрөнгө оруулалт байна.

Улсын салбар. Засгийн газар 2015 оны 2-р улиралд олон улсын зах зээлд бонд гаргасан ба гадаад өрийн эргэн төлөлт хуваарийн дагуу хийгдсэнээр Засгийн газрын гадаад өр 3.7 тэрбум ам.долларт хүрч өнгөрсөн оны мөн үеэс 2 хувиар буюу 0.1 тэрбум ам.доллараар өссөн байна. Харин Монголбанкны гадаад өглөг өнгөрсөн оны мөн үеэс 0.8 тэрбум ам.доллараар нэмэгдэж 1.9 тэрбум ам.долларт хүрэхэд үндэсний мөнгөн тэмдэгт харилцан солилцох своп хэлцлийн ашиглалт голлон нөлөөлжээ. Энэхүү своп хэлцэл нь төлбөрийн тэнцлийн хүндрэлийг зөөлрүүлэх, төлбөрийн тэнцлийн алдагдлыг санхүүжүүлэх, гадаад худалдааг дэмжих, санхүүгийн болон макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангахад

тус тус эерэг нөлөө үзүүлсэн чухал хэрэгсэл бөгөөд хэлцлийн хугацааг цаашид сунгана. Хэлцлийн нийт хэмжээ нь 15 тэрбум юань байгаа бөгөөд гадаад худалдаа, хөрөнгө оруулалт, эдийн засгийн хамтын ажиллагааны нөхцөл байдалтай уялдаатайгаар цаашид нэмэгдүүлэх боломжтой юм.

Хувийн хэвшил. Банк, бусад сектор, охин компанийн толгой компаниасаа авсан зээл буюу хөрөнгө оруулагчийн зээлийг бүхэлд нь хувийн хэвшлийн салбарын гадаад өр гэж ойлгох бөгөөд өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 6 хувиар буюу 0.9 тэрбум ам.доллараар нэмэгдэж 16.1 тэрбум ам.долларт хүрсэн байна.


Банкны салбарын гадаад өр. Худалдаа хөгжлийн банк 500 сая ам.долларын бонд олон улсын зах зээлд арилжаалснаар банкны салбарын гадаад өрийн үлдэгдэл 2015 оны 2-р улирлын байдлаар 2.1 тэрбум ам.долларт хүрч, оны эхнээс 29 хувиар нэмэгджээ. Уг салбарын гадаад пассивын 46 хувийг бонд, өрийн бичиг, 34 хувийг урт хугацаат зээл, 13 хувийг богино хугацаат зээл, үлдсэн 7 хувийг оршин суугч бусын харилцах, хадгаламжийн дансны өглөг тус тус бүрдүүлж байна.

Хүснэгт 9. Гадаад өрийн үлдэгдэл /тэрбум \$/

Үзүүлэлт	6/30/2014	6/30/2015	YoY, %
Нийт гадаад өр	19.9	21.7	9%
I. Засгийн газар	3.7	3.7	2%
II. Төв банк	1.0	1.9	78%
III. Банк	1.5	2.1	44%
Богино хугацаат	0.2	0.3	29%
Урт хугацаат	1.2	1.8	47%
IV. Бусад сектор	3.0	3.5	14%
Богино хугацаат	0.5	0.4	-23%
Урт хугацаат	2.6	3.1	20%
V. Хөрөнгө оруулагч зээл	10.7	10.5	-1%

Эх сурвалж: Монголбанк

Зураг 45. Нийт гадаад өрийн үлдэгдэл



Бусад (банкны бус) салбарын гадаад өр. Бусад салбарын буюу аж ахуйн нэгж, иргэдийн гадаад пассив 2015 оны 2-р улирлын эцэст 14.0 тэрбум ам.долларт хүрч, өнгөрсөн оны эцсийн гүйцэтгэлээс 1 хувиар буюу 0.2 тэрбум ам.доллараар буурсан. Салбарын нийт зээлийн 75 хувь буюу 10.5 тэрбум ам.долларын эх үүсвэр нь аж ахуйн нэгж, байгууллагуудын гадаадын хөрөнгө оруулагчаас авсан зээл (компани хоорондын зээллэг) байна. Энэ төрлийн зээлийн эх үүсвэр нь компанийн эргэлтийн хөрөнгө, мөнгөн урсгалыг дэмжих зорилгоор олгогддог урт хугацаат санхүүжилт бөгөөд ихэнх тохиолдолд хүүгүй, хатуу мөрдөх эргэн төлөлтийн хуваарьгүй, улмаар харилцан тохиролцсоны үндсэн дээр цаашид дүрмийн санд нэмж тооцогдох боломжтой байдгаараа бусад төрлийн зээлээс ялгаатай юм.

4.6.4. Гадаад секторын 2016 оны төлөв хандлага

АНУ-ын эдийн засаг 2015 оны 1 дүгээр улиралд өмнөх улирлаас 0.6%-иар, 2 дугаар улиралд 2.3%-иар тус тус өслөө. Энэ оны эхний улиралд өнгөрсөн оны адил тус улсын зарим нутгаар эрс хүйтэрснээр бизнесийн идэвхжил суларсан, ам.долларын ханш бусад валютын эсрэг чангарсантай холбоотойгоор экспорт 6.0%-иар буурсан зэрэг нь АНУ-ын

1 дүгээр улирлын эдийн засгийн өсөлт сул байх үндсэн шалтгаан болсон. Харин 2 дугаар улиралд эдийн засгийн өсөлт эргэж сэргэхэд газрын тосны үнэ харьцангуй бага байсан, хувийн хэрэглээ нэмэгдсэн, бүтээн байгуулалт идэвхжсэн, хөдөлмөрийн зах зээл сайжирч цалин нэмэгдсэн зэрэг хүчин зүйлс нөлөөлжээ. Энэ оны эхний хагас жилийн байдлаар ажилгүйдэл 2008 оноос хойшхи хамгийн бага түвшин буюу 5.3%-д хүрч буурсан боловч уг бууралтын тодорхой хэсэг нь ажиллах хүчний оролцооны түвшин хумигдсантай холбоотой байна. Үүнээс гадна инфляци Холбооны нөөцийн банк (ХНБ)-ны урт хугацааны зорилтот 2%-ийн түвшнээс бага байгаа тул ХНБ-аас мөнгөний бодлогын хүүгээ өсгөх шийдвэрийг түр хойшлуулсан хэдий ч, энэ оны үлдсэн хугацаанд бодлогын хүү өсөх өндөр хүлээлттэй байна. Ам.долларын ханш дэлхийн бусад валютуудын эсрэг чангарсаар байгаа нь цэвэр экспортод сөрөг нөлөө үзүүлэх боловч эрчим хүчний үнэ буурсан, инфляци тогтвортой нам түвшинд байгаа, төсвийн ачаалал буурсан, орон сууцны зах зээл болон банкуудын баланс сайжирсан зэрэг нөхцөл байдал үргэлжлэх хандлагатай байгаа тул 2015 онд 2.5%, 2016 онд эдийн засаг 2.7%-ийн өсөлттэй байна хэмээн судлаачид үзэж байна.

БНХАУ-ын эдийн засаг 2015 оны 1 болон 2 дугаар улиралд тус бүр 7.0%-иар өссөн нь сүүлийн 30 жилийн хугацаан дахь хамгийн бага өсөлт юм. Эдийн засгийн өсөлт ийнхүү буурсан нь 2015 оны эхний 7 сарын байдлаар хөрөнгийн тогтмол зардлын өсөлт 2000 оноос хойшхи хамгийн доод түвшин буюу 11.2%-д, Засгийн газрын дэд бүтцэд оруулсан хөрөнгө оруулалтын өсөлт 18.6%-д хүрч буурсантай холбоотой байна. Тогтвортой бус байдлыг бууруулах, эдийн засгийн өсөлтийг дэмжих, бүтцийн шинэчлэл хийх зэрэг асуудлуудын тэнцвэрийг олох нь тулгамдсан асуудал хэвээр байгаа бөгөөд сүүлийн үед бий болсон зээл болон хөрөнгө оруулалтын хурдтай өсөлтөөс үүдэлтэй хэлбэлзлийг сааруулах тал дээр БНХАУ-ын Засгийн газар, бодлого боловсруулагчдын зүгээс илүүтэй анхаарах хандлагатай байна. Үүний дагуу үл хөдлөх хөрөнгө, зээл, хөрөнгө оруулалтын илүүдэл буурч байгаа, экспортыг дэмжих, санхүүгийн тогтвортой байдлыг хангах, ханшийг эдийн засгийн суурь нөхцөлтэй нь нийцтэй түвшинд хүргэх зорилгоор юанийн ханшийг сулруулсан, одоогийн хэрэгжиж буй бүтцийн шинэчлэл болон түүхий эдийн үнийн уналт нь хэрэглэгч төвтэй үйл ажиллагааг дэмжих хүлээлттэй байгаа зэрэг үндэслэлээр БНХАУ-ын эдийн засгийн өсөлт үргэлжлэн саарч 2015 онд 6.8%-иар, 2016 онд 6.5%-иар тус тус өснө хэмээн эдийн засагчид үзэж байна.

2015 оны 2-р улиралд 17%-д хүрсэн инфляци бодит цалинг бууруулж, үүнийг дагаад хувийн хэрэглээ буурснаар Оросын эдийн засаг 1, 2-р улиралд -2.2%, -4.6%-иар буурлаа. 1 баррель Brent маркын газрын тосны үнэ 7 сарын байдлаар өмнөх оны мөн үетэй харьцуулахад 50\$-оор, рублийн ханш өмнөх оны мөн үеэс 80%-иар суларч эдийн засгийн хямрал бий болсон. Рублийн ханш ийнхүү огцом суларсан нь нөгөө талаас ирээдүйн экспортыг урамшуулж, эдийн засгийн өсөлтийг дэмжих нэг хөшүүрэг болж байна. 2015 оны эцэст ОХУ-ын Төв банк бодлогын хүүгээ 9.5%-д хүргэж бууруулах замаар мөнгөний зөөлөн бодлогоо үргэлжлүүлэх, импортыг орлох бүтээгдэхүүнийг дэмжих зорилготой уялдан ам.доллартай харьцах рублийн ханш 50-55 рубль/\$ хооронд хэлбэлзэх төсөөлөлтэй байна. Эдийн засгийн өсөлт 2015 оны эцэст -2.2%-иар буурч (агшиж), 2016 оноос инфляци нэг оронтой тоонд орж, ОХУ-ын эдийн засаг 0.4%-иар өсөх хандлагатай байна.

Эрчим хүчний үнэ хямд, еврогийн ам.доллартай харьцах ханш сул байгаагаас экспорт өсч Евро бүсийн эдийн засаг 2015 оны 1, 2-р улиралд 1%, 1.3%-иар өслөө. Испани, Португаль зэрэг ажилгүйдлийн түвшин харьцангуй өндөр орнуудад хөдөлмөрийн зардал буурсан нь компаниудын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлж, тухайн орнуудын гадаад позицыг дээшлүүлэх гол түлхэц болсон. 2015 оны 6 дугаар сард Евро бүсийн аж үйлдвэрийн PMI индекс 2011 оны 5 сараас хойших хамгийн өндөр түвшин буюу 54.1-т хүрлээ. Инфляцийн түвшин 2016 он хүртэл 1%-иас хэтрэхгүй хэмээн судлаачид үзэж байна. Европын Төв банк банкны салбар өсөлттэй байх шинж тэмдгүүд ажиглагдаж байна хэмээн тодорхойлсон ба энэ оны 7 сард хуралдсан хурлаар QE хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ хэмээн мэдэгдсэн. 2016 онд Евро бүсийн эдийн засаг ялимгүй өсч, 1.6%-д хүрэх таамаглалтай байна.

Ийнхүү (i) дэлхийн нийт ДНБ-ий 20 гаруй хувийг бүрдүүлэгч, голлох эдийн засаг буюу АНУ 2015 оны эцэст мөнгөний бодлогоо чангатгах төлөвтэй, (ii) манай орны экспортын бараа бүтээгдэхүүний гол зах зээл⁴ болох БНХАУ-ын эдийн засгийн өсөлт удаашраад байгаа, цаашид үргэлжлэн удаашрах хандлагатай, (iii) ОХУ-ын эдийн засаг уналттай хэвээр байгаа бол (iv) Евро бүсийн эдийн засаг 2016 онд ялимгүй өсөх төлөвтэй зэргээс үзэхэд манай оронд орж ирэх хөрөнгө оруулалтын урсгал болон экспортын бараа, бүтээгдэхүүний гадаад эрэлт 2016 онд огцом нэмэгдэх магадлал бага, гадаад секторын таагүй, тодорхой бус байдал үргэлжлэхээр байна.

Алт. БНХАУ болон Энэтхэг Улсын алтны эрэлт бага байгаа, БНХАУ-ын макро эдийн засгийн төсөөлөл тааруу байгаагаас шалтгаалан хөрөнгө оруулагчдын итгэл буурч БНХАУ-ын аж үйлдвэрийн PMI индекс 15 сарын доод түвшиндээ хүрч буурсан, хөрөнгө оруулагчид Холбооны нөөцийн банкнаас мөнгөний бодлогын хүүгээ өсгөж ам.долларын өгөөж улам бүр нэмэгдэнэ гэсэн хүлээлттэй, инфляцийн дарамт бага байгаа зэрэг нь Лондонгийн үнэт металлын бирж дэх алтны үнэ энэ оны эхний 8 сарын дунджаар 1186 ам.доллар/унц болж буурахад нөлөөлөв. Цаашид БНХАУ-ын эдийн засгийн өсөлт удаашрах, ам.долларын ханш хүчтэй хэвээр байх, ХНБ-ны богино хугацаат хүү нэмэгдэх, алтны эрэлт бага байх хүлээлттэй байгаа тул 2015 онд алтны үнэ дунджаар 1175 ам.доллар/унц, 2016 онд үргэлжлэн бага зэрэг буурч 1158 ам.доллар/унц-д хүрнэ гэсэн төсөөлөлтэй байна.

Цэвэршүүлсэн зэс. 2015 он гарсаар Лондонгийн металлын бирж дэх зэсийн үнэ 5 дугаар сар хүртэл тогтмол өссөн хэдий ч, эхний 8 сарын дунджаар 5782 ам.доллар/тонн болж сүүлийн 6 жилийн хамгийн доод түвшинд хүрч буураад байна. Үүнд дэлхийн цэвэршүүлсэн зэсийн хамгийн том хэрэглэгч болох БНХАУ-ын хөрөнгө оруулалтын өсөлт саарч, аж үйлдвэрлэлийн салбар, жижиглэнгийн худалдаа болон экспорт буурч байгаатай холбоотой эрэлтийн бууралт голлох нөлөөг үзүүлжээ. Цаашид юанийн ханшийн сулралттай холбоотойгоор БНХАУ-ын экспорт нэмэгдэж, БНХАУ-ын нийт зэсийн хэрэглээний 70 орчим хувийг бүрдүүлдэг барилга, цахилгаан эрчим хүчний дэд бүтцийн салбаруудын үйлдвэрлэл, цаашлаад зэсийн хэрэглээ нэмэгдэх боломжтой. Гэвч үл хөдлөх хөрөнгийн бүтээн байгуулалт удаашрах хүлээлттэй байгаагаас БНХАУ-ын зэсийн хэрэглээний өсөлт 2016 онд 2.5% болж бууран, цэвэршүүлсэн зэсийн үнэ 2015

⁴ 2014 онд нийт экспортын 87.8%-ийг, 2015 оны эхний 7 сарын байдлаар 86.1%-ийг БНХАУ руу хийсэн байна.

онд 5656 ам.доллар/тонн, 2016 онд 5435 ам.доллар/тонн болж буурах төсөөлөлтэй байна. **Коксжих нүүрс.** БНХАУ-ын аж үйлдвэрлэлийн PMI индекс 2015 оны эхний 7 сарын дунджаар өнгөрсөн оны мөн үеэс 1.3%-иар буурч 7 сарын эцсийн байдлаар 50.0-д буюу аж үйлдвэрлэлийн өсөлт зогсонги түвшинд хүрсэн. Өөрөөр хэлбэл, үүнтэй уялдан тус улсын аж үйлдвэрлэлийн түүхий эдийн эрэлт буурсаар байна. Тухайлбал, 2015 оны эхний 7 сарын байдлаар өнгөрсөн оны мөн үеэс коксжих нүүрсний эрэлт 0.94%-иар, коксжих нүүрсний импорт 21.6%-иар тус тус буурчээ.


Хүснэгт 10. Түүхий эдийн үнийн төлөв хандлага

Түүхий эдийн төрөл				Төсөөлөл				Эх сурвалж
	2013	2014	2015M8	2015f	2016f	2015f/2014	2016f/2015f	
Алт (\$/унц)	1,412	1,266	1,186	1,206	1,253	-5%	4%	EIU
				1,145	1,040	-10%	-9%	JP morgan
				1,175	1,180	-7%	0%	Блүмберг
Цэвэршүүлсэн зэс (\$/тонн)	7,326	6,863	5,782	5,994	6,463	-13%	8%	EIU
				5,511	4,400	-20%	-20%	JP morgan
				5,490	5,325	-20%	-3%	Standard chartered
				5,563	5,139	-19%	-8%	IMF
				5,720	5,850	-17%	2%	Блүмберг
Коксжих нүүрс (\$/тонн)*	132	101	86					
Төмрийн хүдэр (\$/тонн)	135	98	59	56	45	-43%	-20%	IMF
				56	57	-43%	2%	Блүмберг
Түүхий нефть BRENT (\$/баррель)	109	100	58	60	69	-39%	15%	EIU
				52	50	-48%	-2%	IMF
				56	63	-44%	12%	Блүмберг


* Австралийн зүүн эргээс экспортлож буй хатуу коксжих нүүрс (фоб)

Эх сурвалж: Блүмберг, EIU судалгааны институт

Зураг 46. Аж үйлдвэрлэлийн индекс



Зураг 47. Хятадын коксжих нүүрсний импорт



Эх сурвалжууд: Блүмберг


Нийлүүлэлт талаас дэлхийн зах зээл дээрх хамгийн том тоглогч болох Австрали Улс коксжих нүүрсний экспортоо нэмэгдүүлэх бодлого баримталж байгаа, БНХАУ-тай чөлөөт худалдааны гэрээ байгуулснаар БНХАУ-ын импортын татвараас чөлөөлөгдсөн зэрэг нь коксжих нүүрсний нийлүүлэлтийг нэмэгдүүлж, энэ байдал цаашид үргэлжлэх төлөвтэй байна. Иймд, нэг талаас коксжих нүүрсний эрэлт сул байгаа ч, нийлүүлэлт нэмэгдэж байгаа тул үнэ төдийлөн өсөхөөргүй байна.

Түүхий нефть. Дэлхийн зах зээл дэх нефтийн эрэлт харьцангуй нэмэгдсэн, АНУ-ын нефтийн үйлдвэрлэл илүү хурдтай буурна гэсэн хүлээлтээс шалтгаалж 2015 оны эхний хагас жилд нефтийн үнэ хүлээгдэж байснаас илүү хурдан эргэж сэргэлээ. Гэвч хөгжиж буй орнуудын эдийн засгийн өсөлт саарч байгаа, нефтийн нийлүүлэлт тогтвортой нэмэгдэж нөөц бүрдэж байгаа, Иран Улсын түүхий нефтийн нийлүүлэлт нэмэгдэх хүлээлттэй байгаа тул түүхий нефтийн үнэ 2015 онд 56 ам.доллар/баррель, 2016 онд 61 ам.доллар/баррель-д байх төсөөлөлтэй байна.

4.7.БАНКНЫ САЛБАРЫН ТОГТВОРТОЙ БАЙДАЛ


Банкны салбарын нийт активын хэмжээ 2015 оны 8 дугаар сарын эцсийн байдлаар 20.7 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 1.2 их наяд төгрөгөөр өслөө. Активын өсөлтийн хурд 2014 оны эхнээс саарсаар 6.0 хувьд хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 13.6 нэгж хувиар буурчээ. Активын өсөлтийн хурд ийнхүү буурахад банкуудын үндсэн актив болох мөнгөн хөрөнгө, зээлийн хэмжээ төдийлөн нэмэгдээгүй болон Засгийн газрын болон Төв банкны үнэт цаасанд оруулсан хөрөнгө оруулалтын хэмжээ буурсантай холбоотой байна.

Зураг 48. Активын өсөлт, бүрэлдэхүүн хэсгүүдээр



Эх сурвалжууд: Монголбанк

Зураг 49. Зээлийн чанарын үзүүлэлт /хувиар/




Банкны салбарын нийт зээлийн үлдэгдэл 11.7 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 456.9 тэрбум төгрөгөөр буюу 3.7 хувиар буурлаа. Банкуудын тогтвортой эх үүсвэр болох харилцах, хадгаламжийн хэмжээ төдийлөн өсөөгүйн зэрэгцээ гадаадын зах зээлээс эх үүсвэр татан төвлөрүүлэх нөхцөл сайжраагүй, эдийн засгийн голлох салбаруудад олгосон зээлийн чанар муудаж байгаа зэрэг нь зээл олгох үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж улмаар зээлийн хэмжээ буурах үндсэн шалтгаан боллоо.

Чанаргүй зээлийн хэмжээ 2015 оны 8 дугаар сарын эцсийн байдлаар 762.5 тэрбум төгрөгт, хугацаа хэтэрсэн зээлийн хэмжээ 642.3 тэрбум төгрөгт хүрч өссөн. Энэ нь төлбөрийн тэнцлийн 2013 оны хямралаас шалтгаалж үүссэн эдийн засгийн хүндрэлээс шууд шалтгаалж байна. Ялангуяа гадаад валютын ханшийн эрсдлээс хамгаалах санхүүгийн үүсмэл хэрэгсэл ашиглаагүй хэр нь гадаад валютын зээл авсан зээлдэгчид хувьд хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн хэмжээ өндөр байна. Тухайлбал, 2015 оны 8 дугаар

сарын эцсийн байдлаар төгрөгийн чанаргүй зээлийн хувь 4.6 хувь байхад гадаад валютын чанаргүй зээлийн хувь 12.2 хувь байна.

Эдийн засгийн голлох салбаруудад олгосон зээлийн чанарыг авч үзвэл уул уурхай, боловсруулах үйлдвэрлэл, барилгын салбарт олгосон зээлийн чанар бусад салбаруудаас илүүтэйгээр муудах эрсдэлтэй байна. Олон улсын зах зээл дэх түүхий эдийн үнийн бууралт нь нүүрс, төмрийн хүдэр зэрэг уул уурхайн гол нэр төрлийн бүтээгдэхүүний экспортын орлого болон гадаадын шууд хөрөнгө оруулалтыг бууруулж, үүнийг дагаад уул уурхайн салбарт олгосон зээлийн эргэн төлөлт удааширч байна. 2015 оны эхний хагас жилийн байдлаар уул уурхайн салбарт олгосон нийт зээлийн 13.4 хувь нь чанаргүй, 19.6 хувь нь хугацаа хэтэрсэн ангилалд ангилагджээ.

Зураг 50. Зээлийн чанар, эдийн засгийн голлох салбаруудаар*



Эх сурвалж: Монголбанк

* Дээрх зурагт тод өнгөөр илэрхийлсэн нь чанаргүй зээлийн хувь, бүдэг өнгөөр илэрхийлсэн нь хугацаа хэтэрсэн зээлийн хувь хэмжээ болно.

Иргэдийн орон сууцны эрэлт буурч, барилгын салбарт орон сууцны илүүдэл нийлүүлэлт үүссэн, борлуулалт удааширсны улмаас зарим барилгын компаниудын үйл ажиллагаа зогсонги байдалд орсон зэргээс шалтгаалан барилгын салбарт олгосон зээлийн эргэн төлөлтөд хүндрэл үүсэхээр байна. Барилгын салбарын нийт хугацаа хэтэрсэн зээлийн хэмжээ 78.2 тэрбум төгрөгт хүрсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 58.5 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Цаашид уг салбарын хугацаа хэтэрсэн зээл чанаргүй ангилалд шилжихэд банкуудын ашигт ажиллагаа, зохистой харьцааны үзүүлэлтүүд болон үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй байна.

Бөөний болон жижиглэнгийн худалдааны салбарын чанаргүй зээлийн хувь 4.8 хувьд хүрсэн нь салбарын дунджаас харьцангуй бага байгаа хэдий ч, эдийн засгийн идэвхжил удааширч, өсөлт саарсантай уялдан цаашид худалдааны салбарын зээлийн чанар муудах эрсдлийг нэмэгдүүлж болзошгүй юм.

Харин нийт зээлийн багцын 42.3 хувийг бүрдүүлж буй иргэдэд олгосон хэрэглээний болон орон сууцны ипотекийн зээлийн чанар харьцангуй сайн байгаа бөгөөд чанаргүй зээлийн хувь нь хэмжээ нь харгалзан 2.0, 0.6 хувьтай байна.


Эдийн засгийн голлох салбаруудын үйл ажиллагаа удааширч, улмаар зээлийн чанар муудаж байгаатай холбоотойгоор банкуудын эдгээр салбаруудад олгох зээлийн хэмжээ дагаж буурсаар байна. Тухайлбал, уул уурхай, худалдаа, барилгын салбарт олгосон зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс харгалзан 33.0, 19.1, 13.5 хувиар буурсан байна. Харин боловсруулах үйлдвэрлэлийн салбар болон иргэдэд олгосон хэрэглээний зээлийн хэмжээ тогтвортой өссөн хэвээр байна. Цаашид эдийн засагт шинээр орж ирэх гадаад валютын хэмжээ, гадаад актив өсөхгүй, нөхцөл байдал сайжрахгүй бол банкны салбарын зээлийн чанарт сөрөг нөлөө үргэлжилж болзошгүй байна.

Зураг 51. Зээлийн бүтэц, салбараар
/2015 оны II улирлын байдлаар/



Эх сурвалжууд: Монголбанк

Зураг 52. Салбаруудын зээлийн жилийн өсөлт
/2015 оны II улирлын байдлаар/



Банкуудын зээл олголтын хэмжээ буурч, чанаргүй зээл өсч байгаагаас шалтгаалан зээлийн хүүгийн орлогын өсөлт саарч, зээл төлөгдөхөд учирч болзошгүй алдагдлаас хамгаалах сангийн зардал өсч байна. Зээлийн хүүгийн орлого 2015 оны 8 дугаар сарын эцсийн байдлаар 1.4 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 13.2 хувиар өссөн бол чанаргүй болон хугацаа хэтэрсэн ангилалд шилжсэн зээлүүдэд байгуулсан зээлийн эрсдлийн сангийн зардал 119.5⁵ тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс ойролцоогоор 2 дахин нэмэгдсэн. Үүнтэй уялдан банкны салбарын ашигт ажиллагааны үзүүлэлтүүд болох активын болон өөрийн хөрөнгийн өгөөж өнгөрсөн оны мөн үеэс 0.6, 5.3 нэгж хувиар буурч 1.0, 7.6 хувь болжээ.

Банкны салбарын нийт эх үүсвэрийн хэмжээ 2015 оны 8 дугаар сарын эцсийн байдлаар 18.3 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 818.3 тэрбум төгрөгөөр өслөө. Эх үүсвэрийн жилийн өсөлт 4.7 хувьд хүрч өмнөх оны мөн үеэс 13.2 нэгж хувиар буурахад нэг талаас эдийн засагт орж ирэх гадаад валютын урсгал, гадаадын шууд хөрөнгө оруулалт сэргээгүй хэвээр байгаатай, нөгөө талаас Монголбанкнаас өмнөх жилүүдэд хэрэгжүүлсэн хөтөлбөрийн зээл эргэн төлөлтөөрөө буурч, эдийн засгаас цэвэр дүнгээрээ төгрөг татагдсаар байгаа нь нөлөөлж байна.

Нийт эх үүсвэрийн 56.7 хувийг харилцах, хадгаламж, 8.0 хувийг Монголбанкнаас


⁵ Шинээр олгосон зээлүүдэд байгуулсан 1 хувийн ерөнхий эрсдэлийн сангийн зардлыг хасч тооцсон.

хөтөлбөрийн хүрээнд банкуудад олгосон эх үүсвэр, 14.4 хувийг бусад банк санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр, үлдэх 20.9 хувийг төслийн зээлийн санхүүжилт, банкнаас гаргасан үнэт цаас зэрэг бусад төрлийн эх үүсвэрүүд бүрдүүлж байна. Эх үүсвэрийн бүтцээс харахад харилцах, хадгаламжийн нийт эх үүсвэрт эзлэх хувь хэмжээ аажмаар буурч байна.

Зураг 53. Эх үүсвэрийн жилийн өсөлт



Зураг 54. Эх үүсвэрийн бүтэц /их наяд төгрөг/




Эх сурвалжууд: Монголбанк

4.7.1 Банкны салбарын өөрийн хөрөнгө болон төлбөрийн чадварын үзүүлэлтүүд

Эдийн засгийн нөхцөл байдал хүндрэлтэй, макро эдийн засгийн тэнцвэрийг хангаж, түүнийг бэхжүүлэх нь чухал байгаа үед чанаргүй болон хугацаа хэтэрсэн зээлийн хэмжээ нэмэгдсэн хэдий ч, банкны салбарын зохистой харьцааны үзүүлэлтүүд тогтвортой хангагдсан хэвээр байна. Банкны системийн эрсдэл даах чадварыг тодорхойлдог өөрийн хөрөнгийн хэмжээ 2015 оны 8 дугаар сарын эцсийн байдлаар 2.4 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 17.2 хувиар буюу 351.5 тэрбум төгрөгөөр өслөө.

Зураг 55. Банкны салбарын зохистой харьцааны үзүүлэлтүүд



Эх сурвалжууд: Монголбанк

Банкны салбарын нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, эрсдлээр жигнэсэн активын харьцаа 12.2 хувь, нийт өөрийн хөрөнгө эрсдлээр жигнэсэн активын харьцаа 16.7 хувь байгаа нь Монголбанкнаас тогтоосон шалгуур үзүүлэлтээс харгалзан 3.2 ба 4.7 нэгж хувиар тус тус өндөр байна.

Шигтгээ 3. Банкны нягтлан бодох бүртгэлийг олон улсын стандартад нийцүүлэх тухай

Дэлхий даяар бизнесийн үйл ажиллагааг нэг стандартын дагуу тайлагнах нь компаниудын санхүүгийн мэдээллийг ойлгомжтой, найдвартай, харьцуулахуйц болгодог. Иймд Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ыг дэлхий нийтийн бизнесийн хэл гэж тодорхойлсоор иржээ. Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс дэлхийн эдийн засаг, санхүүгийн чиг хандлага болон олон улсын бизнес эрхлэгчид, зохицуулагч байгууллагуудаас ирүүлсэн санал, зөвлөмжид үндэслэн СТОУС-ыг жил бүр шинэчлэн гаргадаг бөгөөд одоогийн байдлаар СТОУС нь нийтдээ 41 стандарт, 21 тайлбараас бүрдэж байна.

Манай улсын хувьд аж ахуйн нэгж, байгууллагууд СТОУС-ыг мөрдөхөөр Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулинд заасан байдаг. Иймд Монголбанкнаас “Банкны нягтлан бодох бүртгэлийн багц материал”-ыг СТОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Банкны тухай хууль, бусад холбогдох хууль, тогтоомжид тулгуурлан шинэчлэн боловсруулж, Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн сайдын 2015 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн А35/20 дугаар хамтарсан тушаалаар батлууллаа. Уг багц материал нь дараах таван хавсралтаас бүрдэнэ. Үүнд:

1. Банкны нягтлан бодох бүртгэлийн заавар
2. Дансны жагсаалт
3. Санхүүгийн тайлангийн маягт, загвар
4. Банкны санхүүгийн тайлан, тодруулга бэлтгэх аргачлал

Банкны нягтлан бодох бүртгэлийн зааварт банкинд мөрдөгдөх нягтлан бодох бүртгэлийн тулгуур зарчмууд, бодлогын өөрчлөлт, алдааны залруулгыг бүртгэх, санхүүгийн тайлан, түүний үзүүлэлтүүд, нягтлан бодох бүртгэлийн удирдлага, зохион байгуулалтын зарчим, тэнцлийн болон тэнцлийн гадуурх дансдын ангилал тус бүрээр хүлээн зөвшөөрөх, хэмжиж үнэлэх, бүртгэх, тодруулах зарчмыг тодорхойлж, дансдын нийтлэг бичилтүүдийг жишээний хамт тусгасан болно.

Дансны жагсаалт нь банкны бүх үйл ажиллагаа болон санхүүгийн тайлангийн үзүүлэлтийг илэрхийлж чадах дансны төлөвлөгөө бөгөөд 8-10 оронтой код бүхий тэнцлийн болон тэнцлийн гадуурх 3000 гаруй дансаас бүрдэж байна.

Санхүүгийн тайлангийн маягт, загвар нь санхүүгийн тайлангийн мэдэгдэл, санхүүгийн байдлын тайлан, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгаас бүрдэх бөгөөд банкууд энэхүү маягт, загварын дагуу санхүүгийн тайлангаа нэгдсэн байдлаар бэлтгэж, тайлагнаж байна.

Банкны санхүүгийн тайлан, тодруулга бэлтгэх аргачлалд санхүүгийн тайлангийн зорилго, бэлтгэх үндэслэл, зарчим, бүтэц, агуулгыг тодорхойлж, санхүүгийн тайлангийн төрөл тус бүрээр толилуулгын зарчим, тайлангийн зүйлсийн агуулга, бүтцийг заасан. Мөн санхүүгийн тайлангийн тодруулгад тусгагдах нягтлан бодох бүртгэлийн ерөнхий ба тусгай бодлогыг тодорхойлж, санхүүгийн тайлангийн зүйл тус бүрээр хийгдэх тодруулгын шаардлагыг тусгасны зэрэгцээ балансын гадуурх зүйлс, эрсдлийн удирдлага, өөрийн хөрөнгийн удирдлага, бодит үнэ цэнийн талаарх тодруулгыг бэлтгэх удирдамжийг багтаасан болно.

Энэхүү “Банкны нягтлан бодох бүртгэлийн багц материал”-ыг 2016 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн банкуудын үйл ажиллагаанд нэвтрүүлэхээр бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. Ингэснээр банкны салбарын санхүүгийн сахилга батыг дээшлүүлэх, тайлан тэнцэл нь бизнесийн үйл ажиллагааг бодитой илэрхийлдэг байх, банкны эрсдлийн удирдлагыг сайжруулах, үйл ажиллагаа нь банкны хөрөнгө оруулагч, харилцагчдад ил тод, ойлгомжтой байх нөхцөлийг бүрдүүлнэ гэж үзэж байна.

Банкны салбарын түргэн борлогдох активын хэмжээ 7.1 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 785.4 тэрбум төгрөгөөр нэмэгдсэний үр дүнд төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа 39.3 хувьд хүрч 2.8 нэгж хувиар өслөө. Нийт хөрвөх активын 60.2 хувийг мөнгөн хөрөнгө, 30.7 хувийг Засгийн газрын үнэт цаас, 7.2 хувийг Төв банкны үнэт цаас, үлдэх 1.6 орчим хувийг богино хугацаатай репо үнэт цаас бүрдүүлж байна. Хөрвөх активын бүтцээс харахад банкууд Төв банкны үнэт цаасанд оруулах хөрөнгө оруулалтын хэмжээгээ бууруулж, Төв банкин дах харилцах хадгаламжийн хэмжээгээ нэмэгдүүлсэн байна. 2015 оны 8 дугаар сарын эцсийн байдлаар банкуудын Төв банкны үнэт цаасанд оруулсан хөрөнгө оруулалтын хэмжээ 511.7 тэрбум төгрөгт хүрч өмнөх улирлаас 660.2 тэрбум төгрөгөөр буурсан бол, Төв банкны харилцахын хэмжээ 2.1 их наяд төгрөгт хүрч 467.4 тэрбум төгрөгөөр нэмэгджээ.

Түүнчлэн банкууд гадаад валютын нээлттэй позиц, өөрийн хөрөнгийн харьцааг нэг валютын хувьд +/-15 хувийн дотор, нийт нээлттэй позицийн хувьд +/-40 хувийн дотор барьж байх шаардлагатай. Тайлант оны эцсийн байдлаар банкны салбарын гадаад валютын зохистой харьцааны үзүүлэлт нэгж валютын хувьд 0.7 хувь, нийт валютын хувьд 2.7 хувьтай байгаа нь Монголбанкнаас тогтоосон зохистой харьцааны үзүүлэлтийг хангаж байна.

Шигтгээ 4. Орон сууцны ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бүрдүүлэх хөтөлбөр

Монголбанкнаас Засгийн газартай 2013 оны 4 дүгээр сарын 13-ны өдөр “Ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бий болгох” талаар хамтран ажиллах харилцан ойлголцлын санамж бичгийг байгуулсан нь урт хугацаанд тогтвортой ажиллах ипотекийн хоёрдогч захад суурилсан орон сууцны санхүүжилтийн шинэ тогтолцоог бий болгох анхны нөхцөл бүрдүүлсэн юм.

Энэхүү хөтөлбөр нь орон сууцны эрэлт, нийлүүлэлтийн уялдааг хангах замаар орон сууцны үнэ болон орон сууцны түрээсийн үнийг тогтвортой байлгах, улмаар иргэдийн эрүүл, аюулгүй орчин дахь орон сууцны хүртээмжийг нэмэгдүүлэх зорилготойгоос гадна барилгын болон түүнтэй холбоотой салбарын ажил эрхлэлтийн түвшинг нэмэгдүүлэх, эд хөрөнгийн харилцааг илүү үр ашигтай болгох, хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх, нөөцийн хуваарилалтыг сайжруулах, дотоодын хуримтлалд суурилсан эдийн засгийн тогтвортой өсөлтийг бий болгох зэрэг чухал зорилтуудыг агуулсан.

Хөтөлбөр хэрэгжиж эхэлснээс хойш Монголбанкнаас банкуудад нийт 2.8 их наяд төгрөгийн ипотекийн санхүүжилт олгосон бөгөөд банкуудаас Монголбанкинд 347.3 тэрбум төгрөгийг харилцах данснаас, 1.5 их наяд төгрөгийг давуу эрхтэй Ипотекийн Зээлээр Баталгаажсан Бонд (ИЗББ)-оор тус тус эргэн төлсөн. Монголбанкнаас банкуудад олгосон ипотекийн санхүүжилтийн үлдэгдэл 2015 оны 8 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 1.0 их наяд төгрөг байна.

Банкуудын дахин санхүүжүүлсэн зээлийн хэмжээ 571.6 тэрбум төгрөг, ипотекийн зээл шинээр олгохоор шийдвэрлэсэн нийт хэмжээ 2015 оны 8 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 2.1 их наяд төгрөг байна. Банкуудын ипотекийн зээлийн тайлангаарх үлдэгдэл 2015 оны 8 дугаар сарын эцсийн байдлаар 3.3 их наяд төгрөг, үүнээс 8 хувийн хүүтэй ипотекийн зээлийн үлдэгдэл 2.4 их наяд төгрөг байна. Ипотекийн хөтөлбөрийн үр дүнд ипотекийн зээлдэгчийн тоо 73,949-д хүрсэн бөгөөд үүний 52,858 зээлдэгч нь энэхүү хөтөлбөр (2013 оны 6 дугаар сараас эхэлсэн)-т хамаарагдаж байна.

Монголын Ипотекийн Корпораци Орон Сууцны Санхүүжилтийн Корпораци ХХК-ийн байгуулсан Тусгай зориулалтын компани (ТЗК) нийт 6 удаагийн хэлцлээр 1.87 их наяд төгрөгийн ИЗББ гаргаж банкуудад арилжаалсан бөгөөд Монголбанк банкуудаас нийт 1.69 их наяд төгрөгийн давуу эрхтэй ИЗББ худалдан авснаас улирал тутам бондын үндсэн болон купоны төлбөр төлөгдөж, үлдэгдэл нь 1.59 их наяд төгрөг болоод байна.

Манай улс 2003 оноос эхлэн орон сууцны ипотекийн зээл олгож эхэлсэн. Хөтөлбөр хэрэгжиж эхэлснээс хойш ипотекийн зээлийн хэмжээ болон зээлдэгчийн тоо эрс нэмэгдэж, Улаанбаатар хотын нийт өрхийн 20 хувь (хөтөлбөр эхлэхээс өмнө 9% байсан) нь ипотекийн зээлдэгч болж, орон сууцжуулалтын хувь өссөн байна.

Хүснэгт 11. Орон сууцны ипотекийн зээлийн үзүүлэлт

Үзүүлэлт	2003	2012	2013	2014	2015.08
Зээлийн үлдэгдэл /тэрбум төгрөг/	8	845	1939	2845	3267
Ипотекийн зээл/ДНБ	0.5%	6.1%	11.0%	13.1%	
Ипотекийн зээл/Нийт зээл	1%	12%	18%	23%	27%

Хоёрдогч захад суурилсан орон сууцны санхүүжилтийн тогтолцоог бий болгосноор тогтмол орлоготой, ажилтай иргэд өөрийн гэсэн орон байртай болж, ингэснээр дундаж орлоготой иргэдийн хөрөнгө, баялаг нэмэгдэх, мөн иргэдийн ажил хөдөлмөр эрхлэх сонирхол, тогтвортой, хариуцлагатай ажиллах хүсэл эрмэлзлийг өдөөх, нөгөө талаас нуугдмал орлого багасах, шимтгэлийн ил тод, үр ашигтай тогтолцоонд шилжиж, хуримтлалын сан үүсэх боломж бүрдэх зэрэг эерэг үр нөлөөг дагуулсан.

Хөтөлбөрийг Засгийн газарт шилжүүлэх ажлын хүрээнд Засгийн газар Нийгмийн даатгалын сан (НДС)-г хөрөнгөжүүлэн бие даасан мэргэжлийн хөрөнгө оруулагч бий болох боломжийг бүрдүүлж, Монголбанкны эзэмшиж буй давуу эрхтэй ИЗББ-ыг НДС-гийн активт хөрвүүлэх, эсхүл Засгийн газрын бондоор солих арга хэмжээг авах шаардлагатай байна. Ингэснээр Монгол Улсын дундаж давхаргын хуримтлалыг нэмэгдүүлэх бодлого цаашид тасралтгүй үргэлжлэх, ингэснээр эдийн засгийн урт хугацааны тогтвортой өсөлтийн суурийг бүрдүүлэхэд дэмжлэг болно. Мөн НДС-г мэргэжлийн хөрөнгө оруулалтын сан хэлбэрээр шинэчлэн зохион байгуулж, нийгмийн даатгалын тогтолцоог олон улсын туршлагад нийцүүлэн шинэчлэх шаардлагатай.

Цаашид хоёрдогч захад суурилсан орон сууцны санхүүжилтийн тогтолцоог хөгжүүлэхэд хөрөнгийн захын мэргэжлийн хөрөнгө оруулагч сангуудыг бий болгох, санхүүгийн захын дэд бүтцийг сайжруулах, даатгалын тогтолцоог үр ашигтай болгох замаар хөрөнгийн захын хөгжлийг эрчимжүүлэх ажлыг Засгийн газар, холбогдох төрийн байгууллагууд хэрэгжүүлэх нь энэхүү тогтолцоо урт хугацаанд ажиллахад эерэг нөлөө үзүүлэх юм.

ХАВСРАЛТ

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1. Мөнгөний бодлогын нөлөө эдийн засагт бүрэн мэдрэгдэх хугацаа	11
Хүснэгт 2. Гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах дунд хугацааны хөтөлбөрийн зээлийн үлдэгдэл, хугацааны эцэст (тэрбум төгрөгөөр)	27
Хүснэгт 3. Салбаруудын жилийн өсөлт /2015Н1-н өсөлтөд эзлэх хувиар эрэмбэлсэн/	46
Хүснэгт 4. Төсвийн орлого, зардлын тасралт (2015 оны эхний 8 сард).....	49
Хүснэгт 5. Улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэл (2015 оны эхний 8 сард, тэрбум төгрөгөөр)	50
Хүснэгт 6. Төсвийн төлөвлөгөө ба гүйцэтгэл	51
Хүснэгт 7. Мөнгөний үзүүлэлтүүд 2014-2016 он (тэрбум төгрөгөөр)*.....	55
Хүснэгт 8. Монгол Улсын гадаад хөрөнгө оруулалтын позиц.....	63
Хүснэгт 9. Гадаад өрийн үлдэгдэл /тэрбум \$/	65
Хүснэгт 10. Түүхий эдийн үнийн төлөв хандлага	68
Хүснэгт 11. Орон сууцны ипотекийн зээлийн үзүүлэлт.....	75

Зургийн жагсаалт

Зураг 1. Мөнгөний бодлогын шилжих механизмын бүдүүвч	11
Зураг 2: Улаанбаатар хотын сарын ба жилийн инфляци	29
Зураг 3: Жилийн инфляци (голлох 4 ангиллаар)	30
Зураг 4: Улаанбаатар хотын жилийн инфляци (бүтцээр)	30
Зураг 5: Монгол Улсын төлбөрийн тэнцэл (сая ам.доллараар)	32
Зураг 6: Гадаад худалдааны эргэлтээр жигнэж тооцсон төгрөгийн нэрлэсэн (NEER) ба бодит (REER) ханшийн индексийн жилийн өөрчлөлт*	33
Зураг 7: Төгрөгийн ам.доллартай харьцах Монголбанкнаас зарласан ханшийн өөрчлөлт (хувиар илэрхийлсэн интервалаар)	34
Зураг 8: Гадаад валютын улсын нөөц (сая ам.доллар) ба импортын хэрэгцээг хангах түвшин (сараар)	34
Зураг 9: Гадаад худалдааны тэнцэл, жил бүрийн эхний 8 сард (сая ам.доллар)	35
Зураг 10: Төлбөрийн урсгал тэнцэл, жил бүрийн эхний 7 сард (сая ам.доллар)	35
Зураг 11: Банкны системийн өөрийн хөрөнгийн хүрэлцээ (CAR)	36
Зураг 12: Банкны системийн төлбөр түргэн гүйцэтгэх чадвар (LR)	36
Зураг 13: Банкны салбарын чанаргүй зээл ба нийт зээлийн харьцаа (NPL Ratio)	36
Зураг 14. Улсын болон Улаанбаатар хотын инфляци	45
Зураг 15. Улаанбаатар хотын жилийн инфляци болон ханшийн өөрчлөлт	45
Зураг 16. ДНБ-ий жилийн өсөлт	46
Зураг 17. ДНБ-ий өсөлт, бүрэлдэхүүнээр	47
Зураг 18. Засгийн газрын хэрэглээ	47
Зураг 19. Улсын төсвийн орлого, зардал, тэнцэл (тэрбум төгрөгөөр)	48
Зураг 20. Улсын төсвийн орлого, зардлын жилийн өөрчлөлт (%)	48
Зураг 21. Төсвийн нийт орлого ба тусламж	50
Зураг 22. Төсвийн нийт зарлага ба цэвэр зээл	50
Зураг 23. Хөгжлийн банкны зардлыг оруулж тооцсон төсвийн тэнцэл	51

Зураг 24. Инфляцийн төсөөлөл	52
Зураг 25. ДНБ-ий жилийн өсөлтийн төсөөлөл	53
Зураг 26. М2 мөнгөний өсөлт, бүрэлдэхүүнээр /актив/	54
Зураг 27. М2 мөнгөний өсөлт, бүрэлдэхүүнээр /пассив/	54
Зураг 28. БХЗ-ын жигнэсэн дундаж хүү	56
Зураг 29. Банк хоорондын захын арилжааны хэмжээ /тэрбум төгрөг/	56
Зураг 30. Засгийн газрын үнэт цаасны хүү	57
Зураг 31. Хадгаламж, зээлийн хүү	57
Зураг 32. Төгрөгийн ам.доллартай харьцах Монголбанкнаас зарласан ханш	58
Зураг 33. Ханшийн өдрийн хэлбэлзлийн гистограм	58
Зураг 34. Төлбөрийн тэнцэл	58
Зураг 35. Урсгал тэнцэл	58
Зураг 36. Барааны гадаад худалдаа	59
Зураг 37. Үйлчилгээний гадаад худалдаа	59
Зураг 38. Хөрөнгө, санхүүгийн данс	61
Зураг 39. Гадаад валютын нөөц	61
Зураг 40. Монгол Улсын бэлэн, бэлэн бус валютын урсгалын схем	62
Зураг 41. Судалгаануудын үр дүнг ашигласнаар БМХ актив дансанд гарах өөрчлөлт (сая\$).....	63
Зураг 42. Бэлэн валютын зарцуулалт (сая \$)	63
Зураг 43. Гадаад актив	64
Зураг 44. Гадаад пассив	64
Зураг 45. Нийт гадаад өрийн үлдэгдэл	65
Зураг 46. Аж үйлдвэрлэлийн индекс	68
Зураг 47. Хятадын коксжих нүүрсний импорт	68
Зураг 48. Активын өсөлт, бүрэлдэхүүн хэсгүүдээр	69
Зураг 49. Зээлийн чанарын үзүүлэлт /хувиар/	69
Зураг 50. Зээлийн чанар, эдийн засгийн голлох салбаруудаар*	70
Зураг 51. Зээлийн бүтэц, салбараар /2015 оны II улирлын байдлаар/	71
Зураг 52. Салбаруудын зээлийн жилийн өсөлт /2015 оны II улирлын байдлаар/	71
Зураг 53. Эх үүсвэрийн жилийн өсөлт	72
Зураг 54. Эх үүсвэрийн бүтэц /их наяд төгрөг/	72
Зураг 55. Банкны салбарын зохистой харьцааны үзүүлэлтүүд	72

Шигтгээний жагсаалт

Шигтгээ 1. Инфляцийн зорилтыг дунд хугацаагаар томъёолох шаардлага	11
Шигтгээ 2. Судалгааны үр дүнгээр төлбөрийн тэнцлийн бэлэн мөнгө, харилцах дансанд тохиргоо хийх нь	62
Шигтгээ 3. Банкны нягтлан бодох бүртгэлийг олон улсын стандартад нийцүүлэх тухай	73
Шигтгээ 4. Орон сууцны ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бүрдүүлэх хөтөлбөр	75

